			11 дугаар жилийн урсгуулагч хэмээх хороон тахын жилийн сар шинэет саяраг тохиолдуулан дүүргийн нийт ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай засаг даргын захирамж, тавигч тэргэн даргын тушаалуудыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Дүүргийн хэмжээнд 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй нийт 21000 ахмад настан амьдарч байна. Үүнээс 95-аас дээш насны 49 ахмад настан оршин сууж байна. 98, 99 настай 15 ахмадад нийслэлийн Засаг дарга, 100 ба түүнээс дээш настай 8 ахмадад МУ-ын Ерөнхийлөгч хүндэтгэл үзүүлсэн ба 95, 96, 97 настай 26 ахмад, 60-аас дээш насны 9000, харьяалалгүй 3000, зорилтот өрхийн 4000 ахмад, нийт 16000 гаран ахмадад дүүргийн Засаг даргын Тамгын газраас хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа. Уг ажлыг хороодын ажлын алба, Тамгын газрын албан хаагчид хамтран 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 02 дугаар сарын 4-ний өдрийг дуустал зохион байгууллаа. Хороо бүр Ахмадуудаа хорооны иргэний танхимд ээлжээр хүлээн авч, хэвтрийн ахмадууддаа гэрээр нь очин хүндэтгэл үзүүллээ. Уг арга хэмжээнд дүүрэг, хороодын удирдлагууд, дүүргээс сонгогдсон хурлын төлөөлөгчид хуваарийн дагуу оролцлоо. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ажлын гүйцэтгэчийг холбогдох журмын дагуу төндөр зарлан шалгаруулж, арга хэмжээг зохион байгууллаа. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас тэтгэвэрт гарсан 74 ахмадыг 01 дүгээр сарын 30-ны өдөр Тамгын газрын хүндэтгэлийн өргөөнд хүлээн авч, санал хүсэлтийг сонсоон, хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардууллаа. Монголын ахмадын өдрийг тохиолдуулан 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар паласын их танхимд дүүргийн 3000 ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Хүндэтгэлийн арга хэмжээнд УИХ, нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид болон албаны хүмүүс оролцож нийт ахмадууддаа баяр хүргэлээ. Энэ үеэр 51 ахмадыг төрийн дээд одон медаль болон НИТХ-ын хүндэт өргөмжлөл, дүүргийн шагналаар шагнаж урамшууллаа. Баянгол дүүргийн 10 иргэн "Хүндэт иргэн"-ээр тодорлоо. Мөн Үндэсний Урлагийн Их театрын уран бүтээлчдийн урлагийн тоглолтыг сонирхуулан, гарын бэлэг гардууллаа. Түүнчлэн 23 хороон дээр ахмад настныг алдаршуулах, хүндэтгэл үзүүлэх, хүлээн авах, нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх зэрэг олон арга хэмжээг зохион байгуулж 2300 ахмад настныг хамруулсан байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар 19000 ахмадад хүндэтгэл үзүүлсэн байна.					

Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хүн амыг чийрэгжүүлэх олон нийтийн сайн дурын клубуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана	Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх материаллаг орчин нөхцөлийг сайжруулж, нийтийн биеийн тамир, спортын наадам, тэмцээн уралдаан, сургалт зохион байгуулна.	Зохион байгуулсан ажил, тоогоор	4	30,000,000 Дүүргийн төсөв	100	Биеийн тамир, спорт хороо Нийгмийн хөгжлийн хэлтэс
		хамрагдсан хүн, тоогоор	50,000			
2.3-1	Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/198 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бие бялдрын сорилыг зохион байгууллаа. Сорилд нийт 72 байгууллагын 27,646 хүн хамрагдлаа. Баянгол дүүргийн Биеийн тамир, спорт хороо "Биеийн тамир, спортын тухай" хуулийн хэрэгжилтийн хүрээнд жилийн эцсээр нийтийн биеийн тамирын арга хэмжээ 90 удаа зохион байгуулж, 759 аж ахуйн нэгж, байгууллагын 35,029 иргэд хамрагдаж, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 4,520,600 төгрөг, өөрийн хөрөнгөөс 1,258,000, бусад эх үүсвэрээс 5,520,500 төгрөгийг зарцууллаа. Нийтийн биеийн тамир спортын тэмцээн уралдаан нийт 22 удаа зохион байгуулж, 305 байгууллагын 4965 хүүхэд залуучууд хамрагдаж, улсын төсвөөс 28,795,900 төгрөгийг зарцуулан ажиллалаа. "Улаанбаатар марафон-2019, автомашингүй өдөр" Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 17-ны А/147 дугаар захирамж, Дүүргийн Засаг даргын А/155 дугаар захирамжийн дагуу "Улаанбаатар марафонд нэгдэгчдээ-2019" цомын аяныг 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл Баянгол дүүргийн цэцэрлэг, ЕБС, их дээд сургуулиуд, төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллага, 23 хороодын иргэдийг идэвхтэй хамруулах зорилгоор дүүргийн 99 байгууллагаар амжилттай аялууллаа. 2019 оны 05 дугаар сарын 18-нд Сүхбаатарын талбайд гүйлтийн тэмцээн амжилттай зохион байгуулагдаж нийт 2165 иргэд оролцлоо. Мөн Баянгол дүүргийн "Монголын Үндэсний Их Сургууль"-ийн 1000 оюутан тэмцээнийг зохион байгуулах үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдлаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53 дугаар зарлиг "Хүн ам бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил" – ыг дүүргийн засаг даргын А/108 захирамжийн дагуу энэ оны эхний хагас жилд багтааж дүүргийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, оюутан, сурагч, хүүхдүүд нийт 16,702 иргэн, төрийн болон Төрийн бус байгууллагын 18-64 насны 1629 ажилтан албан хаагчид хамрагдлаа.					
	Хүрсэн түвшин, хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 1697 хүн хамрагдсанаас 659 хүүхэд, 454 насанд хүрэгч, 584 хүн цагаар тус тус хичээллэсэн байна. БСШУЯ-ны харьяа "Шинэ Эрин" сургуулийн 46 хүүхэд, "Шинэ Эхлэл" сургуулийн 45 хүүхэд биеийн тамирын хичээлийн цагаа усанд сэлэлтийн цаг болгон хамрагдсан. "Дэлхийн зөн" олон улсын байгууллагатай хамтран зорилтот бүлгийн 16 хүүхэд хөнгөлөлттэй үнийн тарифаар, 9-р хорооны ажлын албатай хамтран зорилтот бүлгийн 25 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 12 хүүхэд, 19 ахмад настанд үнэ төлбөргүй усан чийрэгжүүлэлтийн үйлчилгээ үзүүлсэн. "Утааны эсрэг-Усан спорт" аяныг БГД-ийн ЗДТГ-тай хамтран 3 дах жилдээ амжилттай зохион байгуулж агаарын чанарын 3 дугаар бүсэд орон байраа цахилгаан болон хийн халаагуураар халаадаг айл, өрхүүдийн 5-7 насны 80 хүүхэд үнэ төлбөргүй үйлчилгээ авч, усан чийрэгжүүлэлтийн үйлчилгээнд хамрагдаж байна. Монгол улсад Ардчилсан хувьсгал өрнөсний 30 жилийн ойг тохиолдуулан Усан спортын мастер П.Цэцэгэ агсаны дурсгалыг хүндэтгэх усанд сэлэлтийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж, гурван насны ангиллаар нийт 140 гаруй тамирчид өрсөлдөж аваргуудаа тодруулсан. "Бид Баянгол дүүргээрээ бахархаж байна 2019" зэлжит тойрон аяллыг Баянгол дүүргийн ИТХ-ын ажлын албатай хамтран зохион байгуулж 19 хорооны иргэд манай байгууллагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, усанд сэлэлт түүний ач холбогдлын талаар мэдлэгтэй болсон. Онцгой байдлын байгууллагын мэргэжлийн аварга-усчин, шумбагчийн дунд шатны "АУЦДС-19 1" сургалтыг ОБЕГ-ын Үндэсний аврах бригадтай хамтран зохион байгуулж орон нутгийн Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах анги, салбар, бүлгийн 23 алба хаагч хамрагдсан байна. Манай төвийн тамирчин Ш.Даваадорж мөстэй, өвлийн усанд сэлэлтийн Дэлхийн аварга, дэлхийн цомын аварга, олон улсын тэмцээнээс 5 алт, 12 мөнгө, 2 хүрэл, Швед улсад зохион байгуулсан өвлийн усанд сэлэлтийн Дэлхийн цомын аваргаас 2 алт, 3 мөнгө, Жинанд болсон олон улсын их наадмаас хүрэл медаль, Таержиан, Жинанд болсон өвлийн усанд сэлэлтийн тэмцээнээс 3 алт, 4 мөнгө, 4 хүрэл медаль, Латви улсад зохион байгуулагдсан мөстэй усанд сэлэлтийн Цомын аваргаас 2 мөнгөн медаль тус тус хүртэж амжилт гаргасан. Мөстэй, өвлийн усанд сэлэлтийн Дэлхийн аварга, дэлхийн цом, олон улсын тэмцээнээс 32 алт, 29 мөнгө, 14 хүрэл хүртэж, 2018/19 оны чансаагаар дэлхийд 1-т орж дэлхийн цом эзэмшигч болсон.					
2.3	Усан спорт сонирхогчдод болон зорилтот бүлэгт чиглэсэн сургалт, тэмцээн уралдаан, чийрэгжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулна.	Хамрагдсан хүн, тоогоор	4,000	5,000,000 Дүүргийн төсөв	70	Усан спорт сургалтын төв

2.4	Дүүргийн өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, дэмжлэг үзүүлнэ.	2.3-3	"Баянгол Олимп 2019" иргэдийн спортын наадам зохион байгуулна.	Зохион байгуулагдах тэмцээн, тоогоор Хамрагдах иргэд, тоогоор	8 3,000	20,000,000 Дүүргийн төсөв	100	Биеийн тамир спорт хороо
			Хүрсэн түвшин, хэрэгжилт					
			Нийслэлийн 380 жилийн ой, "Эрүүл чийрэг иргэнтэй Баянгол дүүрэг" хөтөлбөрийн хүрээнд Баянгол дүүргийн Засаг даргын 2019 оны А/469 дугаар захирамжаар "Баянгол олимп-2019" иргэдийн спортын наадам 7 дугаар сарын 12-ноос 10 дугаар сарын 6-ныг дуустал спортын 8 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 23 хорооны 3658 иргэн хамрагдлаа. Иргэдийн спортын их наадмын аварга шалгаруулах шигшээ тэмцээнд спортын 8 төрөлд давхардсан тоогоор 71 хорооны 634 иргэд амжилттай хамрагдлаа. Багийн нэгдсэн дүнгээр: Нэгдүгээр байранд Е.Ариунзул даргатай 2 дугаар хорооны баг тамирчид/ цом, өргөмжлөл, мөнгөн шагнал/ Дэд байранд С.Мөнгөнтулга даргатай 22 дугаар хорооны баг тамирчид/ цом, өргөмжлөл, мөнгөн шагнал/ Гутгаар байранд Ц.Гомбосүрэн даргатай 1 дүгээр хорооны баг тамирчид /цом, өргөмжлөл, мөнгөн шагнал/ Тусгай байранд Д.Эрдэнэтуяа даргатай 11 дүгээр хорооны баг тамирчид / өргөмжлөл, мөнгөн шагнал/ Тусгай байранд С.Мягмарсүрэн даргатай 6 дугаар хорооны баг тамирчид /өргөмжлөл, мөнгөн шагнал/ тус тус эзэллээ. Төрөл тус бүд эхний байруудад шалгарсан баг тамирчид нийслэлийн шигшээ тэмцээнд оролцох эрх авсан. Нийслэлийн шигшээ тэмцээний нээлтийн арга хэмжээнд хороодын иргэд, шалгарсан баг тамирчид оролцсон. Тус шигшээ тэмцээнээс Е.Ариунзул даргатай 2-р хорооны баг тамирчид сагсан бөмбөгийн төрөлд алтан медаль хүртсэн зэрэг амжилтууд үзүүлээд байна.					
2.3-4			Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон нийтийн сайн дурын клубуудын үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Хамтран зохион байгуулсан тэмцээн, уралдаан, тоогоор	4	5,000,000 Дүүргийн төсөв	70	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Биеийн тамир спортын хороо
			Хүрсэн түвшин, хэрэгжилт					
			Дүүргийн Засаг даргын 2019 оны "Эрүүл дүүрэг" нийтийн цэнгээнт бүжгийн аяныг зохион байгуулах тухай А/140 дүгээр захирамжийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд бүжгийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг "Виктория" бүжгийн клубийн бүжгийн багш нар сургалтын хөтөлбөрийн дагуу 4 цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 14 албан хаагч хамрагдаж 10 төрлийн бүжгийн анхан шатны сургалтанд хамрагдлаа. Сургалтаар уран вальс, вальс бостон, сургуулийн вальс, танго, фокстрот, шугаман бүжиг буюу "Африка бум бум" зэрэг бүжгийн анхан шатны сургалтыг зохион байгууллаа. 7 дугаар сарын 12-ны өдөр Хүй долоон худагт Монголын Үндэсний Сурын Харвааны Холбоотой хамтран Үндэсний сурын тэмцээнийг зохион байгууллаа.Тэмцээнд 12 хорооны 24 харваачид оролцлоо. 8 дугаар сарын 17-ны өдөр Монголын Хөгжлийн Бэршээлтэй Иргэдийн Холбоотой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд Баянгол дүүргийн багийг хариуцан оролцууллаа. Харааны бэрхшээлтэй иргэдийн дунд биеийн тамир, спортыг дэлгэрүүлэн эрүүл мэндийг сайжруулах ажлын хүрээнд харааны бэрхшээлтэй хүүмүүсийн Пара-олимпийн наадмын хөтөлбөрт багтдаг Хонхтой бөмбөгийн спортыг сонирхогчдын дунд жил бүр Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохиож баг тамирчдын тоглох ур чадварыг нэмэгдүүлэн туршлага солилцуулан тэднийг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох, холбооны шигшээ багт тамирчин сонгон шалгаруулах зорилготойгоор зохион байгуулагдлаа. Тус тэмцээн нь 2019 оны 06-р сарын 27-29-ний хооронд Эрдэнэт хотын Биеийн тамир, спортын газрын Спортын ордонд зохион байгуулагдсан. Харааны бэрхшээлтэй иргэдийн дунд зохиогдсон "Хонхтой бөмбөг"-ийн улсын аварга шалгаруулах 7-р тэмцээнд Баянгол дүүргээс эрэгтэй 4, эмэгтэй 4, хоёр дасгалжуулагч, 10 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид амжилттай оролцоод ирлээ. Тус тэмцээнд эрэгтэй 15 эмэгтэй 7 багийн 100 гаруй тамирчид оролцсоноос Баянгол дүүргийн эрэгтэй баг тамирчид 6-р байрт, эмэгтэй баг тамирчид 2-р байр эзлэн мөнгөн медаль хүртлээ. Мөн багийн дүнгээр гутгаар байр эзлэн хүрэл цомын эзэд болж амжилттай оролцоод ирсэн байна.					
2.4	Дүүргийн өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, дэмжлэг үзүүлнэ.	2.4-1	Спортын 12 төрлийн өсвөрийн шигшээ багийн тамирчдыг тэмцээн уралдаанд бэлтгэл ханган оролцуулна	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	36,000,000 Дүүргийн төсөв	100	Биеийн тамир, спорт хороо, Нийгмийн хөгжлийн хэлтэс
			Хүрсэн түвшин, хэрэгжилт					
			Баянгол дүүргийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн А/132 дугаар захирамжын хүрээнд Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 12 төрлөөр ажиллуулж байна.3 дугаар улирлын байдлаар 236 тамирчид хичээллэж улс, хотын тэмцээнүүдээс 20 алт, 22 мөнгө, 36 хүрэл медаль хүртсэн амжилттай байна. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг сагсан бөмбөг, волейбол, жүдо, чөлөөт бөх, дугуйн спорт, шатар, бүжгийн спорт, гимнастик, таэквондо, байт харваа, ширээний теннис, бокс гэсэн спортын 12 төрлөөр хичээллэж, тэмцээн уралдаанд оролцож, бэлтгэл сургуулилтаа ханган ажиллаж байгаа ба эхний хагас жилийн байдлаар, хот олон улсын чанартай тэмцээнээс 4 алт, 3 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн амжилттай байсан бол сагсан бөмбөгийн баг тамирчид Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 17 насны эмэгтэй баг алтан медаль, 15 насны эрэгтэй баг мөнгөн медаль, нийслэлийн сурагчдын лиг тэмцээнд 2 алтан медаль, 1 хүрэл медаль хүртлээ. Чөлөөт бөхийн баг тамирчид Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2 алтан медаль,1 хүрэл, волейболын өсвөрийн шигшээ багийн тамирчид идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 3Х3 тэмцээнээс алтан медаль тус тус хүртээд байна. Дүүргийн засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид хүүхдийн спортын VI их наадамд мөн амжилттай оролцож олон медалийн эзэд болсон. Шигшээ багийн тамирчдын дүүргийн Засаг дарга С.Одонтуяа хүлээн авч уулзаж, "Баянголын бахархал-2019" хүндэт өргөмжлөлийг гардуулсан.					
			Монголын хүүхдийн спортын VI их наадмыг зохион байгуулна.	Спортын төрөл, тоогоор	10	20,000,000 Дүүргийн төсөв	100	Биеийн тамир, спорт хороо, Нийгмийн хөгжлийн хэлтэс
			Хүрсэн түвшин, хэрэгжилт					

		2.4-2	Дүүргийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 21-ний А/145 дугаар захирамжаар хүүхдийн спортын VI их наадмын анхан шатны тэмцээнийг зохион байгуулах хороо, нэгдсэн зааврын дагуу спортын 14 төрлөөр сургуулийн АШТ, дүүргийн аварга шалгаруулах тэмцээн гэсэн 2 үе шаттайгаар 2 дугаар сараас 6 дугаар сар хүртэл спортын 16 төрлөөр зохион байгууллаа.Тэмцээнд давхардсан тоогоор 19 сургуулийн 2336 тамирчид хамрагдлаа. Монголын хүүхдийн спортын VI наадамын шигшээ тэмцээнд спортын 27 төрөлд 266 тамирчин оролцож 18 алт, 9 мөнгө, 16 хүрэл медаль хүртэж шагналт тусгай байр эзэллээ. Хүүхдийн спортын VI их наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээн амжилттай зохион байгуулагдаж шилдгүүдээ шалгаруулан Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон. Шигшээ тэмцээнд оролцох эрхээ авсан 266 тамирчин, дасгалжуулагчдыг дүүргийн удирдлагууд хүлээн авч жигдрэлтийн хувцас гардуулж амжилт хүссэн. Баянгол дүүргийн баг тамирчид шигшээ тэмцээнээс 18 алт, 9 мөнгө, 16 хүрэл медаль хүртэж багийн нэгдсэн дүнгээр тусгай байр эзэлсэн. Шилдэг зохион байгуулалттай дүүрэг номинацад 3 дугаар байр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амжилтаар шагналт тусгай байр, буудлагын спорт, бүжгийн спортын баг тамирчид багаараа тэргүүн байр тус тус эзэлсэн.					
2.5	"Утаагүй хот 2030" төсөлтэй уялдуулан агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авна	2.5-1	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөртэй уялдуулан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулна	Төлөвлөгөөний биелэлт 80 хувьд хүрсэн байх, хувиар	100%	-	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
		2.5-2	Дүүргийн нутаг дэвсгэрт сайжруулсан түлш худалдаалах, нийлүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана	Хяналт хийх хороод, тоогоор	9, 10, 11, 21, 22, 23	2,000,000 дүүргийн төсөв	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
		2.5-3	Дүүргийн нутаг дэвсгэрт стандарт хэмжээнээс дээш утаа ялгаруулж хөдөлгөөнд оролцож байгаа авто тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулна.	Хяналт, шалгалтад хамрагдах авто тээврийн хэрэгсэл, тоогоор	1000 дээш	6,000,000 Дүүргийн төсөв	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
		2.5-4	"Агаарын чанарыг сайжруулах 3, 4 дүгээр бүсэд мөрдөх" журмын хэрэгжилтийг хангуулж ажиллана	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Мэргэжлийн хяналтын хэлтэс

ГУРАВ. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ ИРГЭНТЭЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ							
3.1	"Баянгол-Боловсрол 2020" хөтөлбөрийг боловсруулсан хэрэгжүүлнэ.	3.1-1	Боловсролын үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байх боломжийг бүрдүүлэн, багш сурагчийн ажиллах, таатай орчныг бий болгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	20,000,000 Дүүргийн төсөв	Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс
		Хүрсэн түвшин, хэрэгжилт "Баянгол Боловсрол-2020" дэд хөтөлбөрийн сургууль, цэцэрлэггүй хороодод цэцэрлэг сургууль шинээр барих, ашиглалтын шаардлага хангахгүй болсон сургууль, цэцэрлэгийн барилгыг буулгаж шинээр барих өргөтгөх замаар хичээллэх ээлжийн тоог бууруулах чиглэлээр улсын төсвийн хөрөнгөөр боловсролын салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллах үүрэг бүхий "Ажлын хэсэг байгуулах тухай" дүүргийн Засаг даргын А/88 захирамж батлагдан гарч ажлын явцад хяналт тавьж ажиллав. 2019 онд улсын төсвийн хөрөнгө <u>орруулалтаар</u> 2018-2019 онд он дамжин 14,950.0 сая төгрөгийн сургууль, цэцэрлэгийн барилгын угсралт болон өргөтгөлийн ажил хийгдэж байна. Дүүргийн Засаг даргын 2019 оны А/08 дугаар захирамжийн дагуу дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус өмчийн цэцэрлэгийн гадаад, дотоод орчны үнэлгээг хийж мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлээ. Ингэхдээ цэцэрлэгийн барилга байгууламж, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрүүл ахуй, гадаад дотоод орчны эрсдэл, ариутгал цэвэрлэгээ үйлчилгээ, шат, хаалга, харуул хамгаалалт, камер зэрэг нарийвчилсан үзүүлэлтээр үнэлгээ хийж ажлын тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. "Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдалд хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай" дүүргийн Засаг даргын 2019 оны А/248 захирамжийн дагуу өмчийн хэлбэр үл харгалзан үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгийн гадаад, дотоод орчны аюулгүй байдал, эрсдэлд тогтмол хяналт тавьж, болзошгүй эрсдлийг бууруулах, гарсан зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулан ажиллаж 2019 оны байдлаар ерөнхий боловсролын 47 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 65 байгууллага зэрэг нийт 112 байгууллагын гадаад орчны аюулгүй байдалд хяналт тавьж судалгаа гарган, илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан байна. 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулиа амжилттай төгсөж, БНСУ-ын их сургуульд суралцах хүсэлтэй төгсөгчдөдөө зориулан БНСУ-ын Сүхбэн Хян их сургуультай хамтран Баянгол дүүргийн төгсөгч 100 хүүхдэд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах батламж гардуулан өглөө. 2019-2020 оны хичээлийн жилд сургалтын орчныг сайжруулах зорилгоор дүүргийн Засаг даргын 2019 оны А/456 дугаар захирамжийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудад "Зураг зүйн кабинетын иж бүрэн үзүүлэн самбар" хийж хүлээлгэн өгөх, дүүргийн Засаг даргын 2019 оны А/455 захирамжийн дагуу ерөнхий боловсролын 38 дугаар сургуульд үндэсний хэл бичиг соёлын "Монгол хэл, соёлын өргөө" байгуулан хүлээлгэн өгөх, дүүргийн Засаг даргын 2019 оны А/457 дугаар захирамжийн дагуу сургуулийн өмнөх боловсролын 85 дугаар цэцэрлэгт үндэсний ёс зан заншилын "Монгол ёс, зан үйлийн өргөө" гэр хүлээлгэн өгөх ажлыг тус тус зохион байгуулан ажиллалаа. Хүүхэд багачуудын чөлөөт цаг, танин мэдэхүүд зориулсан "Үлгэрийн цаг-бүтээлч өдөр" аяныг дүүргийн Засаг даргын 2019 оны А/560 захирамжийн дагуу сургууль, цэцэрлэгүүд болон дүүргийн "Хүүхэд залуучуудын соёлын ордон" ОНӨААТУГ тай хамтран бямба гараг бүр зохион байгуулан ажиллаж байна.					
		3.1-2	Амьдрах ухаан, бие даах чадвартай, зөв хөгжил төлөвшилтэй иргэн төлөвшүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж хэвшүүлнэ.	Зохион байгуулах ажил, тоогоор	3	13,000,000 Дүүргийн төсөв	Боловсролын хэлтэс, "Баянгол Агропарк" ОНӨТҮГ
		Хүрсэн түвшин, хэрэгжилт Цэцэрлэгүүд МУ-ын Засгийн газрын 2018 оны 189 дугаар "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай" тогтоолын хэрэгжилтийг хангаж, 2019 оны 03-р сарын 01-нээс эхлэн гялгар уутыг хэрэглэхгүй байх талаар төрийн болон төрийн бус өмчийн 105 цэцэрлэг эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт, сурталчилгаа хийснээр даавуун улавчийг хэрэглэж хэвшсэн. Цэцэрлэгүүд оюун ухааны болон урлаг, спортын 19 төрлийн дугуйланд 7121 хүүхэд хамруулж, 242 багш хичээллүүлэн, хүүхдийн авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Дугуйлан хичээллүүлснээр хүүхдийн хурд, хүч, авхаалж самбаа, тэсвэр тэвчээр, оюун ухаан, анхаарал, танин мэдэхүйн бүтээлч сэтгэлээг дэмжин хөгжүүлж байна. "Хүүхдээ сонсьё" ажлын хүрээнд "Шинэ эрин" сургуультай танилцах "Зочин сурагч" үйл ажиллагааг зохион байгуулж, 4 сургуулийн 20 сурагч хамрагдсан. "Усаа хэмнэж, эх дэлхийгээ аваръя" сэдвээр 42 дугаар сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдад сургалт зохион байгууллаа. "Усны зохистой хэрэглээ", "Усаа гамная", "Ус чандмань эрдэнэ" сэдвээр 26 цэцэрлэг 3800 гаруй эцэг эхэд сургалт зохион байгуулж, нөлөөллийн ажил хийсэн. "Мод тарих аргачлал" зурагт хуудсыг 46 сургуульд цахимаар түгээж, мод тарих өдрөөр дүүргийн хэмжээнд 1000 гаруй гацуур, монос, нарс зэрэг олон төрлийн мод тарьж арчлан ургуулж байна. 48 цэцэрлэг цэцэгний үрсэлгээ хийх, тасалгааны цэцэг, мандлын цэцэг тарих аргачлал, гарын авлага, брошур 2860 тараасан. Хороодтой хамтран "Гялгар уут биш даавуун уут ашиглая" сэдвээр 6 сургуулийн 120 ахлах ангийн сурагчдад зохион байгуулсан. Ахлах ангийн сурагчид өвсөн уутаараа сайн үйлсийн аянд оролцон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандивлалаа. Сурагчид өөрийгөө хөгжүүлэх 32 төрлийн дугуйлан, секцид 19200 хүүхэд хамрагдаж байна.					
			Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад суурилсан цөм хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлж, сургалтын чанарыг ахиула.	Зохион байгуулах ажил, тоогоор	3	11,000,000 Дүүргийн төсөв	Боловсролын хэлтэс

	3.1-3	Хүрсэн түвшин, хэрэгжилт БСШУ-ны сайдын 2013 оны 287 тоот тушаалаар батлагдсан "СӨБ-ын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журмын дагуу 2-4 жилийн үндсэн сургалтад хамрагдан багшлах үр чадвараа дээшлүүлэх сургалтанд 10 цэцэрлэгийн 53 багш хамрагдаж, батламж авлаа. Хөгжим, биеийн тамир, бүлгийн багш нарын дунд байгууллага, хэсэг, дүүргийн хэмжээнд үр чадварын уралдаан зохион байгуулж, багшлах арга ажиллагааг сайжруулах бусад багш нартаа арга туршлагаа хуваалцан нийт 550 багш нар нээлттэй хөгжүүлэх үйл ажиллагааг хувиарын дагуу зааж явуулсан. Нийт 25 удаагийн үйл ажиллагааг нээлттэй зохион явуулсан байна. "Суралцагчдын ялгаатай байдлыг сургалтад харгалзах нь" сэдвээр илтэлийн уралдааныг байгууллага, хэсэг, дүүргийн түвшинд зохион байгуулж нийт 6 багш амжилттай оролцлоо. Дүүргийн НХХ-ээс зохион байгуулсан "Сургуулийн өмнөх насны хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь" сургалтанд 35 багш хамрагдсан. ТББ -аас зохион байгуулсан "Шидэт хүүхэдтэй" сургалтанд 275 туслах багшийг хамрууллаа. "Нийслэлийн боловсрол-2020"-тэй уялдан гарсан "Баянгол боловсрол-2020" хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлд "Цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн одоогийн болоод ахисан түвшнийг тогтоож ажиллана" гэж тусгасны дагуу 2018-2019 оны хичээлийн жилд гарааны үнэлгээг ахисан түвшинтэй харьцуулахад 18.4%-иар өссөн байна. Улсын дундажтай харьцуулахад нийгэмшихүйн чадамж дундаж түвшинд үнэлэгдэж байгаа нь багш нар илүү сайн ажиллах шаардлагатайг зөвлөлөө. Амжилтын гараа IV уралдаанд 12-р ангийн 995 сурагч 10 судлагдахуунаар оролцсон бөгөөд Нийслэлд 13,93,28-р сургуулиуд тэргүүлж өргөмжлөлөөр шагнагдсан. Шалгалт нь ЭЕШ-ын бэлтгэл хангах, сурагчид хариултын хуудастай ажиллах туршлагатай болж сургуулиудын амжилтад 03-0,8 хувийн ахиц гарсан. Шалгарсан 3 сургуулийн захирал Япон улсад туршлага судлах эрх авсан. Шинэ эхлэл сургуулийн МХУЗ-ын багш доктор Д.Туяатай хамтран хамтран "Эсээ бичих арга зүй, эсэзний бүтэц найруулан бичих дадлага" сэдвээр 3 дүүргийн 170 багшид сургалт зохион байгуулсан. "Залуу багш - 2019" бага ангийн багш нарын үр чадварын уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгуулж, 1-р шатанд 90 багш, 2-р шатанд 18 багш оролцож, 113, 20-р сургуулийн багш нар эхний байранд шалгарч, нийслэлд амжилттай оролцсон.											
		<table><tr><td>Багшийн хөгжлийг дэмжих, тэдний мэргэжил, үр чадварыг дээшлүүлэх, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</td><td>100%</td><td>90,000,000 Дүүргийн төсөв</td><td>100</td><td>Нийгмийн хөгжлийн хэлтэс</td></tr></table> Хүрсэн түвшин, хэрэгжилт						Багшийн хөгжлийг дэмжих, тэдний мэргэжил, үр чадварыг дээшлүүлэх, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	90,000,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс
		Багшийн хөгжлийг дэмжих, тэдний мэргэжил, үр чадварыг дээшлүүлэх, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	90,000,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс						
2019 оны 02, 03 дугаар сард зохион байгуулсан "Цэцэрлэгийн хүүхэд бүрийг хөгжүүлэх үзэл баримтлал" сэдэвт Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн 105 эрхлэгч, 78 арга зүйч хамрагдаж, арга зүйд суралцлаа. НБГ, "Хүүхэд зорчиж байна" ТББ хамтарсан "Зан чанар-харилцаа" сургалтад дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн 358 багш хамрагдаж, төрийн өмчийн 6 бүсийн үзүүлэх ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгууллаа. 250 багш үзүүлэн, сургалтын хэрэглэгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж, 82 багш сургалтын үйл ажиллагааг зохион явуулан 540 гаруй багш нарт шилдэг туршлагаа түгээн дэлгэрүүлж, харилцан бие биенээсээ туршлага судалсан, ажлын байран дээрээ хөгжсөн, бусдад шинэ санаа өгч, өөрийн арга зүйг сайжруулсан үр дүнтэй ажил болсон. НБГ-аас 2019 оны 05 дугаар сарын 26-нд дүүргийн төрийн өмчийн 326 багшид "Хэл яриа, Байгаль, нийгмийн орчин" суралцахуйн чиглэлийн сургалт зохион байгуулагдлаа. ЕБС-ийн "Ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалтад 50 багш, нийгмийн ажилтан хамрагдсан. 2019 оны 02 дугаар улиралд гадаад орны тэргүүн туршлага солилцох, мэргэжил арга зүйгээ дээшлүүлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 18 эрхлэгч Бүгд найрамдах Вьетнам улсад 7 хоног ажилласан байна. Дүүргийн англи хэлний багш нарын дунд "Шилдэг заах арга зүйтэй багш" шалгаруулах 3 дахь удаагийн уралдааныг дүүргийн Засаг даргын 2019 оны А/104 захирамжийн дагуу зохион байгуулж 25 багш хамрагдлаа. Монголын багш нарын баярын 53 дахь өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын хамтарсан 2019 оны А/134-А/442 дугаар захирамж батлагдан гарч 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн Багш нарын баярын өдрийг дүүргийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлээ. Тус үйл ажиллагаанд дүүргийн Тэргүүний 14 байгууллага, 36 багш ажилтныг шалгаруулан амжилт үр бүтээлтэй ажилласан багш нарыг төрийн дээд алтан гадас одон болон салбар яамны тэргүүний ажилтан, жуух бичиг шагналаар шагнаж урамшуулсан ба нийт 3000 багшид хүндэтгэл үзүүлээ. Мөн багшийн хөгжлийг дэмжих, үр чадварыг дээшлүүлэх, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/520 дугаар захирамжаар Нийслэлийн 38 дугаар сургуулийн захирал Ч.Отгондавааг Япон улсын Токио хотод мэргэшүүлэх сургалтад оролцуулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.													

 3.2 | Насан туршийн боловсрол олгох сургалтын хүртээмжийг сайжруулж, сургууль завсардалтыг 50 хувиар бууруулна. | 50 | хувиар | 3.2-1 | **Сургууль завсардсан болон завсардах эрсдэлтэй хүүхдүүдийн илрүүлэг судалгааг хороодтой хамтран хийж дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсролыг эзэмшүүлнэ** **Хүрсэн түвшин, хэрэгжилт** 2018-2019 оны хичээлийн жилд дүүргийн 23 хороодтой хамтран сургууль завсардсан болон завсардах эрсдэлтэй хүүхдийн илрүүлэг судалгааг явуулж, нийт 12 хүүхэд илэрсэнээс, бага боловсролыг 5 хүүхэдэд, суурь боловсролыг 5 хүүхэдэд эзэмшүүлсэнээс 2 хүүхэд нь 9 дүгээр ангиа төгсөж суурь боловсролын гэрчилгээгээ гардан авсан. 1 хүүхэд ДЦП буюу хөгжлийн бэрхшээлтэй сургуульд сурах боломжгүй 1 хүүхэд Хэнтийн Гал шар сум руу шилжсэн. Тус төв нь дүйцсэн хөтөлбөрийн бага ангийн холимог бүлэгт 35, суурийн холимог бүлэгт 31, бүрэн дунд боловсролд 14 нийт 80 суралцагч суралцаж байна. 2019-2020 оны хичээлийн жилд дүүргийн 23 хороотой хамтран сургууль завсардсан болон завсардах эрсдэлтэй хүүхдийн илрүүлэг судалгааг явуулж одоогийн байдлаар 4 хүүхэд илэрсэн. Энэ хичээлийн жилд бага боловсролд 30 хүүхэд, суурь боловсролд 23, бүрэн дунд боловсролд 7 хүүхэд суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 7 хүүхэд суралцаж байна. Тус төв нь дүйцсэн хөтөлбөрийн бага, суурь холимог, бүрэн дунд боловсрол эзэмшихээр нийт 60 хүүхэд суралцаж байна. Өмнөх хичээлийн хичээлийн жилд суралцаж байсан 12 хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулсан байна. | | | | | || | | | | | | | |---|------------------------------------|------|---|-----|---| | Амьдрах ухаан, гэр бүл, иргэний боловсрол, гоо зүй, ёс суртахуун төлөвшилийн боловсрол олгох үндсэн 5 чиглэлийн сургалтыг насан туршийн боловсролын төвөд зохион байгуулна. | Сургалтад хамруулах иргэн, тоогоор | 3500 | - | 100 | Албан бус насан туршийн боловсролын төв | |---|------------------------------------|------|---|-----|---| **Хүрсэн түвшин, хэрэгжилт** | | | | | |
| | | | | | |

		3.2-2	Амьдрах ухааны сургалтаар "Харилцаа", "Мэргэжил сонголт бидний ирээдүй", "Хүн байхын учир", "Ус ба байгаль" зэрэг 7 сэдвээр 18 удаагийн сургалтыг 781 иргэнд, Гэр бүлийн боловсрол олгох сургалтаар "Гэр бүл төлөвлөлт", "Харилцаа ба ёс зүй", "Архины хор уршиг" зэрэг 10 сэдвээр 17 удаагийн сургалтаар 975 иргэнд Иргэний боловсрол олгох сургалтаар "Е соёл", "Экологи ул мөр" зэрэг 2 сэдвээр 9 удаагийн сургалтаар 684 иргэнд, Гоо зүйн боловсрол олгох сургалтаар "Эрүүл гоо сайхан байхын тулд залуурч болохгүй", "Гоо сайхны бүтээгдэхүүний сөрөг нөлөө", "Бие бялдрын хүмүүжил" зэрэг 3 сэдвээр 11 удаагийн сургалтыг 459 иргэнд, Ёс суртахуун төлөвшилийн сургалт "Амьдралын утга учир", "Ёс суртахуун ба харилцааны соёл", "Шударга ёс нийгмийн сэтгэл", зэрэг 2 сэдвээр 8 удаагийн сургалтаар 660 иргэнд, Бичиг үсгийн анхан шатны сургалтанд 5 иргэнд, Компьютерийн анхан дунд шатны сургалтанд 45 иргэнд, Англи хэлний анхан шатны сургалтад 40 иргэнд, Оёдол эсгүүрийн сургалтад 12 иргэнийг хамрууллаа. Сургалтад БГД-ийн 1- 23-р хорооны иргэд, ОНБААТҮГ, ХҮТ- 11,12,13 төвийн ажилчдад,ХХҮХ -ийн дэргэдэх "Загвар төв"-ийн суралцагчид, "Баруун түгээх" төвийн ажилчид," Бэст буйдан" ХХК ажилчид, "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв"-ийн ажилчид, "96-р сургуулийн" төгсөх ангийн суралцагчид, эцэг эхчүүдэд," Номч" сургуулийн багш, ажилчид, суралцагчид, СХД, БГД АБ-НТБТөвүүдийн багш нарт "Тогтвортой хөгжлийн боловсрол" сэдвээр, дүүргийн цэргийн насны залууст, "Валана" сүлжээ дэлгүүрийн хамт олон хамрагдсан. Нийт 3559 иргэнд сургалт зохион байгуулан 100% үр дүнтэй ажилласан байна.					
			Хүүхдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, авьяас чадвараа хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллана.	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	100%	-	100	Хүүхэд, залуучуудын соёлын ордон, Баянгол хүүхдийн зуслан
			Хамрагдсан хүүхэд тоогоор		500			
			Хүрсэн түвшин, хэрэгжилт					
		3.3-1	2019 оны зуны сургалтыг дараах 12 төрлөөр 45 хоногийн хугацаанд явуулж, нийт 140 хүүхдийг хамруулсан. Үүнд: Математик /бага анги/-15 сурагч, Соробан сампин-10 сурагч, Англи хэл-27 сурагч, Математик-20 сурагч, Герман хэл-55 сурагч, Шатар-11 сурагч, Бүжиг-10 сурагч, Дуулаач-4 сурагч, Драм-Илтэх урлаг-15 сурагч, Төгөлдөр хуур-14 сурагч, Гитар-8 сурагч, Морин хуур-2 сурагч хамрагдлаа. 2019-2020 оны хичээлийн жилийн сургалтаар 13 төрлийн дугуйланд 521 хүүхдийг хамруулан сургаж байна. Үүнд: Математик /бага анги/-35 сурагч, Соробан сампин-13 сурагч, Англи хэл-86 сурагч, Математик-30 сурагч, Герман хэл-55 сурагч, Шатар-45 сурагч, Бүжиг-90 сурагч, Дуулаач-7 сурагч, Драм-илтэх урлаг-32 сурагч, Төгөлдөр хуур-89 сурагч, Гитар-26 сурагч, Юкүлэлэ- сурагч, Морин хуур-21 сурагч хамрагдлаа. Түүнчлэн МХБХолбооны дэргэдэх "Номт академи" ТББ-тай хамтран жүдо бөхийн сургалтад 200 орчим хүүхдийг жүдо бөхийн дугуйланд хамруулан ажиллаж байна. Тус ордон нь 4000 гаруй номын фонд бүхий 40 хүний суудалтай нийтийн номын сангаар дүүргийн хүүхэд, залуучуудад тогтмол үйлчилж байна. Өнөөдрийн байдлаар номын санд ЕБС-ын 700 хүүхэд карт нээлгэж, уншигчаар бүртгүүлэн үйлчлүүлж байна. Өдөрт дунджаар 50-100 хүүхэд тогтмол үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Мөн дүүргийн хүүхэд, залуучуудын авьяас чадварыг хөгжүүлэх, урамшуулах зорилгоор 10 гаруй нэр төрлийн тэмцээн уралдаан, олон нийтийн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Баянгол хүүхдийн зуслан нь хүүхэд, багачуудыг эрүүл, аюулгүй орчинд амрах таатай орчинг бүрдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл хоол хүнсээр хангах, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулах зорилгоор нэг ээлжиндээ 450 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, үйл ажиллагаагаа жилийн 4 улирлын турш явуулах хүүхдийн зуслан үйл ажиллагаагаа эхлэхэд шаардлагатай нийтийн хоолны гал тогооны техник тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, зөөлөн эдлэл, хөгжмийн техник тоног төхөөрөмж гэх зэрэг холбогдох бараа материалыг авч дууссан байна.					
			Эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	Зохион байгуулсан арга хэмжээ, тоогоор	4	5,500,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучуудын хэлтэс, Цагдаагийн газар
			Хүрсэн түвшин, хэрэгжилт					
		3.3-2	Гэр бүлийн тухай хуулийн 63, 64 дүгээр зүйлийн хүрээнд 2014-2018 онуудад асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгосон 104 хүүхдийн судалгаа гаргасан. Судалгаанд үндэслэн тус хуулийн 72 дугаар зүйлийн дагуу Засаг даргын Тамгын газрын даргаар 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан "Хүүхдийн гэр бүл, орчны эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний маягт"-аар эрсдэлийн түвшинг тогтоосон. Үүнээс 26 хүүхэд хаяггандаа амьдардаггүй. Эрсдэлийн түвшин өндөр гэж тогтоогдсон хүүхэд судалгаанаас илрээгүй болно. Асрамжийн газарт асруулж буй хүүхдийг үрчлүүлэх дүүргийн Засаг дарга болон Эрүүл мэндийн яамны харьяа Хүүхдийн төв сувицлын Захирлын хамтарсан захирамж, тушаалаар батлагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр хуралдуулан үрчлэгдэх боломжтой 2 хүүхдийн асуудлыг шийдвэрлэн ажилласан. Дэлхийн зөн ОУ-ын байгууллагатай хамтран 20, 21, 22 дугаар хороодын зорилтот бүлгийн 300 өрхийн эрсдэлт нөхцөлд байгаа 300 хүүхдийг сонгон авч "Хүүхэд хамгаалал-нөлөөлөл" төслийг хэрэгжүүлж байна. Дүүргийн 20, 21, 22 дугаар хороодын төслийн зорилтот бүлгийн 300 хүүхдийг Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулж, цаашид үзүүлэх үйлчилгээг тодорхойлон ажилласан. Үзлэгт хамрагдсан нийт 174 хүүхдээс шүдний цооролтой 50 хүүхэд буюу 28,7%, арьсны өвчтэй 7 хүүхэд буюу 4%, чих хамар хоолойн өвчтэй 11 хүүхэд буюу 13,4%, бөөрний үрэвсэлтэй 3 хүүхэд буюу 1,7%, гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй 14 хүүхэд 8,04%, буюу шээсний шинжилгээгээр өөрчлөлттэй 63 хүүхэд буюу 36,2%, давхар өвчлөлтэй хэдэн 24 хүүхэд буюу 13,7%, эрүүл 83 хүүхэд буюу 47,7% -ийг тус тус эзэлж байсан. Давхар өвчлөлтэй хүүхдүүдийг дүүргийн Эрүүл мэндийн төвд илгээжүүлэн ажилласан. Төслийн 20, 21, 22 дугаар хороодын төсөлд хамрагдсан 300 хүүхдийг томуу, томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс Томуугийн вакцинуудыг Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан хийлээ. Вакцинд хамрагдвал зохих 300 хүүхдээс 20 дугаар хорооноос 14 хүүхэд, 21 дүгээр хорооноос 57 хүүхэд, 22 дугаар хорооноос 50 хүүхдийг нийт 121 хүүхэд буюу 40,3%-ийг хамрууллаа. Хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон өрхийн хүүхдүүдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ оношлогоо, нийгмийн халамжийн дэмжлэг тусламж үзүүлэх, ар гэрийн насанд хүрсэн ажилгүй иргэдийг хөдөлмөрт зуулах, ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган нийт 5 удаагийн арга хэмжээг хамтран зохион байгуулан ажилласан. Тус хөтөлбөрт хамрагддаг иргэдийг зөв дадалд сургах гэр бүлийн зэрэг уур амьсгалыг төлөвшүүлэхэд чиглэсэн 6 удаагийн тэмдэглэлт баярын арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт 500 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Дэлхийн зөн ОУ-ын байгууллагатай хамтран 20, 21, 22 дугаар хорооны зорилтот 300 хүүхдийг сонгон авч "Хүүхэд хамгаалал ба нөлөөлөл" төслийг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр төслийн хаалтын арга хэмжээг зохион байгуулсан. Дүүргийн гэр бүл, хүүхдийн статистик тоон мэдээллийг журмын дагуу боловсруулан гаргахад төрийн байгууллагын салбар тус бүрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэн, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх статистик мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйн сургалтыг 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр 09:00-16:00 цагийн хооронд дүүргийн Иргэний танхимд зохион байгуулсан. Сургалтад салбар салбарын статистикийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд /Боловсролын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Статистикийн хэлтэс/ болон хороодын хөгжлийн нийгмийн ажилтнууд нийт 36 ажилтан албан хаагчид хамрагдсан. Сургалтыг Монголын Үндэсний статистикийн хорооны мэргэжилтнүүд чиглүүлэн явуулсан. Уг ажилд "Дэлхийн зөн" ОУБ-ын санхүүжилтээр 1,132,620 төгрөгийг зарцуулсан байна.					
3.3	"Хүүхдэд ээлтэй Баянгол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.							

3.3

"Хүүхдэд ээлтэй Баянгол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

		Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, аян, нөлөөллийн ажлыг зохион байгуулна Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн гэр бүл, хүүхдийн статистик тоон мэдээллийг журмын дагуу боловсруулан гаргахад төрийн байгууллагын салбар тус бүрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэн, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх статистик мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйн сургалтыг 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр 09:00-16:00 цагийн хооронд дүүргийн Иргэний танхимд зохион байгуулсан. Сургалтад салбар салбарын статистикийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд /Боловсролын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Статистикийн хэлтэс/ болон хороодын хөгжлийн нийгмийн ажилтнууд нийт 36 ажилтан албан хаагчид хамрагдсан. Сургалтыг Монголын Үндэсний статистикийн хорооны мэргэжилтнүүд чиглүүлэн явуулсан. Уг ажилд "Дэлхийн зөн" ОУБ-ын санхүүжилтээр 1,132,620 төгрөгийг зарцуулсан байна. Цагдаагийн газар нь "Өсвөрийн сэргийлэгч-Бид чадна" аяныг хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль дээр өрнүүлэх ажлыг эхлүүлэн, хууль эрх зүйн мэдээ мэдээлэлээр хангаж үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан. Нийт ерөнхий боловсролын 28, 40, 73, 38, 77, 54, 93, 19, 113, Гурван тамир сургуулийн 90 өсвөрийн сэргийлэгч, 14 багш нийгмийн ажилтан нарт сургуулийн орчинд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийн талаар сургалт хийсэн. "Эрдмийн баяр" нэгдсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын Эрдмийн өргөө цогцолбор, Эрдмийн ундраа цогцолбор, 13, 19, 20, 38, 93, 113 сургуулиудын төгсөх ангийн 21 бүлгийн 762 сурагч болон Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургууль, Нийгмийн сэтгэл судлалын дээд сургууль, Техник технологийн дээд сургууль, Анагаахын үндэсний шинжлэх ухааны үндэсний их сургуулиудын 167 оюутанд төгсөлтийн арга хэмжээг архи, согтууруулах ундаагүй тэмдэглэн өнгөрүүлэх талаар уриалга гарган архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх чиглэлээр "Монгол улсын Зөрчлийн тухай" хууль болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн холбогдох зүйл заалтуудаар сургалт, яриа таниулга хийн 120 ширхэг санааж, сэрэмжлүүлэг хуудсыг тарааж ажилласан. Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, яриа сургалт сурталчилгааны чиглэлээр нийт 19 удаагийн өдөрлөг, хэлэлцүүлэг, уулзалт, сургалт, мэдээлэл, сурталчилгааны хүрээнд давхардсан тоогоор 18 ерөнхий боловсролын сургуулийн 1784 сурагч, 8 дээд сургуулийн 327 оюутанд сургалт, ухуулга яриа таниулга хийсэн. Монгол улсын ерөнхийлөгч 2019 оноос 2020 оныг "Хүүхдийн хөгжил хамгааллын жил" болгон зарласантай холбогдуулан цагдаагийн байгууллагаас Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Зөв Тусгал" нэгдсэн арга хэмжээг зохион явуулсан. Дээрхи арга хэмжээний хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, эерэг аргаар хүмүүжүүлэх, ёс суртахуунтай гэр бүлийг төлөвшүүлэх зорилгоор Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран тус эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа нийт 50 хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч болон ерөнхий боловсролын 40, 47, Хүрээ тулга дунд сургуулийн нийт 600 эцэг, эхчүүдэд сургалт сурталчилгаа нөлөөллийн ажил зохион байгуулж ажилласан.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	13,000,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс Цагдаагийн II II хэлтэс
	3.3-3	"Баянголын багачууд" хүүхдийн баярын арга хэмжээ зохион байгуулна Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн хэмжээнд "Баянголын багачууд" сэдэвт хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах тухай дүүргийн иргэдийн Хурлын дарга, дүүргийн Засаг дарга нарын хамтарсан 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/95 – А/303 дугаар захирамжаар баярын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөө батлагдан гарсан. Нэгдсэн төлөвлөгөөний дагуу доорх дөрвөн төрлийн арга хэмжээ зохион байгуулагдлаа. "Баянголын багачууд" нэгдсэн арга хэмжээ, "Баянголын багачууд" хороодын 4 бүсийн арга хэмжээ, "Эзжүүддээ баярлалаа" 1000 ээжид хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, "Одонтой ээж" 300 ээжид алдарт эхийн одон гардуулах ёслолын ажиллагааг тус тус амжилттай зохион байгууллаа. Хүүхдийн баярын парадад дүүргийн удирдлагууд, ЕБС, цэцэрлэгийн сурлага, урлаг, спортоор бусдыгаа манлайлан суралцаж буй авъяаслаг хүүхэд багачууд мөн үлгэрийн баятрууд, төр захиргааны байгууллагын албан хаагчид, үлээвэр найрал хөгжим, "Зөв тусгал" хөдөлгөөнтэй хамтран 750 хүүхдийн баярын жагсаалыг ТЗДС-иас УБ паласын задгай талбай хүртэл зохион байгуулж, хүүхэд бүрийн хүслийг багтаасан хүслийн шаарыг тэнгэрт хөөргөсөн. Энэ үеэр дүүргийн шилдэг 25 сурагчдад сурагчдын холбооны шагнал үнэмлэх, тэмдгийг гардуулан өгсөн юм. Жил бүрийн хүүхдийн баярын өдрийг Баянгол дүүргийн хүүхэд багачууд хамтдаа тэмдэглэн өнгөрөөдөг уламжлалтай. Энэхүү баярын хүндэтгэлийн арга хэмжээ 5 газарт зохион байгуулагдсан нь хүүхэд бүрт хүрч очсон, хүүхэд бүр баярлах боломжийг олгож өгсөн. Мөн зорилтот бүлгийн 2000 хүүхдэд гарын бэлгийг гардуулан өгсөн нь хүүхэд бүр баярлах эрхтэй гэсэн зорилгыг хангаж өгсөн. 70 дугаар тусгай сургуулийн болон хөгжлийн бэрхшээлтэй 650 хүүхдэд гарын бэлэг гардуулсан. Үүний хажуугаар дүүргийн хүүхдүүдээс сурлага хөдөлмөр, авъяас чадвараараа манлайлсан 25 сурагчийг алдаршуулан сурагчдын холбооны шагналаар шагнаж, хүүхдийн нийгмийн хамгааллын төлөө ажиллаж амжилт гаргасан багш, эмч, нийгмийн ажилтнуудыг урамшуулж дүүргийн Засаг даргын жуух бичиг, ИТХ-ын шагналаар шагнасан. Хүүхдийн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх захирамжийн дагуу дүүргийн төр захиргааны байгууллагууд өөрсдийн хариуцсан ажлаа зохион байгуулалтын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэнээр арга хэмжээний үеэр гарсан элдэв зөрчилгүй, эрүүл аюулгүй байдлыг хангасан арга хэмжээ болж өндөрлөлөө.	Оролцсон хүүхэд, тоогоор	3,000	20,000,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс
	3.3-4	Залуучуудын өдрийг тохиолдуулан дүүргийн залуучуудын чуулга уулзалт зохион байгуулна Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн Засаг даргын 2019 оны А/288 захирамжийн дагуу "Дүүргийн хөгжилд залуусын оролцоо" сэдвийн дор салбар салбартаа амжилт бүтээлээрээ манлайлсан залуусын төлөөлөл болох 250 залууг хүлээн авч уулзалт арга хэмжээг 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулан ажилласан. Арга хэмжээнд дүүргийн удирдлагууд, Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид оролцон залуусаас гарсан санал санаачилгыг дэмжин ажилласан.	Зохион байгуулсан ажил, хамрагдсан хүн, тоогоор	1 удаа 100 хүн	6,000,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс
	3.4-1	Зорилтот бүлгийн залуучуудад чиглэсэн 5 төрлийн 24 удаагийн сургалт, 6 нөлөөллийн ажлыг зохион байгуулна Хүрсэн түвшин, хэрэгжилт Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан залуучууд, тоогоор	15000	4,000,000 Дүүргийн төсөв	40	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс	

3.4	"Залуучууд хөгжлийн төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлж залуучууд руу чиглэсэн сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.	3.4-2	2019 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр "Өөртөө итгэх итгэл" сэдвээр зорилтот бүлгийн 6 залууд зан үйлд нөлөөлөх зорилгоор, 2019 оны 02 дугаар сарын 10-нд зорилтот бүлгийн 6 залууд "Харилцаа" сэдвээр, 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр 3 залууд зорилгоо тодорхойлох, зорилготой байх сэдвээр амьдрах ухааны хичээл, 2019 оны 04 дүгээр сарын 23-ний өдөр 7 залууд хорт зуршил сэдвээр амьдрах ухааны сургалт, 2019 оны 05 дугаар сарын 27-нд зорилтот бүлгийн 3 залууд "Асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах" сэдвээр амьдрах ухааны сургалт, мөн Баянгол дүүргийн 113-р сургуулийн 9-р ангийн 150 сурагчдад амьдрах ухааны хичээлийг "Үе тэнгийнхний дарамт шахалт, түүний үр дагавар" мөн "Цахим орчин дахь зохистой хэрэглээ" сэдвэт сургалтыг 4 дүгээр сарын 15-ны өдөр, 2019 оны 11 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд "Найрамдал олон улсын хүүхдийн зуслан"-д Баянгол дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын нийт 20 өсвөр үеийн сурагчдад "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Бэлгийн эрүүл мэндийн боловсрол, Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх" сэдвүүдээр "сертификат"-тай сургагч багш бэлтгэх сургалт тус тус зохион байгуулж нийт 195 залуучуудыг хамрууллаа. Тус сургалт маань 2019 оны 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд дахин 20 залуучуудыг хамруулан зохион байгуулагдана. Зорилтот бүлгийн залуучуудад зан үйл нөлөөлөх амьдрах ухааны болон залуучуудын хөгжлийн төвийн үндсэн сургалтуудыг заасанаар тухайн залуучууд зан байдал илүү чөлөөтэй, нээлттэй болж сургалтанд идэвхитэй оролцож бусдадтайгаа болон сургагч багштайгаа илүү сайн харилцаатай болсон. Нөхөн үржихүйн эрүүл мэнд болон бэлгийн замын халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх сэдвээр сертификаттай сургагч багш болсоноор сурагчид өөрсдийн сургуулийн өсвөр үеийн сурагчдад өөрийн сурсан мэдсэн чиглэлээр сургалт орох давуу талтай болж байгаа юм.					
		3.4-3	Зорилтот бүлгийн залуучуудыг сэтгэл зүй, хууль эрх зүй, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилна.	Холбон зуучлах үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн залуучууд, тоогоор	1000	600,000 Дүүргийн төсөв	40	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
		3.4-4	Залуучуудын биеийн тамир, чийрэгжүүлэлт, байгаль орчноо хайрлан хамгаалах амьдрах ухааны боловсрол олгох "Эко аялал" сургалт, тоогоор	"Эко аялал" сургалт, тоогоор	4	4,750,000 Дүүргийн төсөв	70	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
3.5	Өсвөр болон бага насны хүүхдүүдэд цэрэг, эх оронч хүмүүжил олгох "Эх орон-36" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	3.5-1	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад "Эх орон-8, 16, 36" хөгжлийн хөтөлбөрүүдийг төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	"Эх орон 36" хөтөлбөрт хамрагдсан сурагчид, тоогоор	2000	16,500,000 Дүүргийн төсөв	70	Баянгол Хүүхдийн зуслан, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Усан спорт сургалтын төв
		3.5-1	Хүүхэд багачуудын бие бялдрыг сайжруулах, өв тэгш хүмүүжил, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой "Эх орон-8" хүүхэд хөгжлийн хөтөлбөр 2019 оны нээлтийн арга хэмжээ 05 дугаар сарын 02-ны өдөр 11 цагаас Нийлэлийн 141 дүгээр сургууль, 05 дугаар сарын 09-нд 13 дугаар сургууль, 05 дугаар сарын 23-нд 51 дүгээр сургууль, 10 дугаар сарын 18-ны өдөр Эрдмийн өргөө цогцолбор сургуулиудад тус тус зохион байгуулсан. Арга хэмжээнд ахлах ангийн нийт 610 сурагчдын дунд амжилттай зохион байгуулагдлаа. Арга хэмжээнд Улаан загалмайн нийгэмлэг, Онцгой байдлын хэлтэс, Цэргийн штаб, Скаутын зөвлөл, скаутын багш нар оролцож сурагч хүүхдүүдэд гал унтраах анхан шатны дадлага, Газар хөдлөлтөд өөрийгөө болон бусдын амь насыг хамгаалах арга, Байгалийн гэнэтийн гамшиг, онцгой байдлын үед эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ хэрхэн үзүүлэх, уяа зангилаа, гал гаргаж сурах, луужингаар зүг чигээ олох зэрэг хүүхэд, залуучуудын заавал мэдэж байх хэрэгтэй зүйлүүдийг заасан үр дүнтэй сургалт боллоо. Мөн хөтөлбөрт хамрагдах ёстой 590 хүүхдийг дүүргийн Скаутын холбоонд бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Нийт 1200 хүүхдийг хамруулан ажилласан.					
		3.5-1	Эх оронч үзлийг төлөвшүүлэх чиглэлээр цэрэг спортын тэмцээн болон бусад сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	25,000,000 Дүүргийн төсөв	100	Цэргийн штаб

		3.5-2	"Эх орон-36" хөтөлбөрийн хүрээнд дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурагчдад сурталчлах зорилгоор "Бид ирээдүйн эр цэрэг" тойрон аяллыг 2019 оны 03 дугаар сарын 06 өдөр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албатай хамтран зохион байгууллаа. Тойрон аялалд ахлах ангийн 95 сурагч оролцож Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн үйл ажиллагаа болон Монгол цэргийн музейн үзвэрүүдтэй танилцаж, хугацаат цэргийн албан хаагчдын байрыг танилцуулан, сонирхсон асуултанд хариулан сонирхолтой мөчийг өнгөрүүлсэн. Нийслэл хот байгуулагдсаны 380 жил, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ой, "Халхын голын ялалтын 80 жил", "Эх орон-36" хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх төслийн хүрээнд дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл-2019" цогцолбор тэмцээнийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл-2019" тэмцээнийг 3 дугаар сарын 11-ны өдөр жилийн 0164 дүгээр ангийн байрлалд зохион байгуулж, тэмцээнд төрийн өмчийн 16 сургууль, хувийн хэвшлийн 1, нийт 17 сургуулийн баг тамирчид 10 төрлөөр авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдөж, амжилттай зохион байгууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдсан "Халхын гол- 80 жил" сэдэвт зохион бичлэгийн уралдаанд нийт 140 гаруй бүтээл ирүүлж, тэргүүн, дэд байруудыг шалгарууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдсан "Бид дэлхийн цэрэг" сэдэвт гар зургийн уралдаанд нийт 30 гаруй бүтээл шалгаран Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагмалаар шагналаа. Нийслэл хот байгуулагдсаны 380 жил, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Халхын голын ялалтын 80 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Монгол хурандаа нийгэмлэг, Монгол цэргийн музейтэй хамтарч, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдар, сэтгэл зүй тэсвэр, тэвчээртэй зөв иргэн болох, ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлж "Миний эх орон" сэдэвт яриа танилцуулгыг 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдөр "Монгени" цогцолбор сургуулийн урлаг зааланд зохион байгууллаа. Мөн "Халх голын дайны ялалтын түүхэн мөрөөр" сэдэвт Монгол цэргийн музейн үзмэрүүдийг дэлгэн дээрхи сургуулиудын сурагчдад танилцууллаа.					
		3.6-1	Шинээр гэр бүл болж буй хосууд, шинэ төрсөн иргэд, иргэний үнэмлэхээ гардан авч буй залуусын ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах, олон хүү, охин төрүүлсэн ээжүүдийг алдаршуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулна.	Ёслолын үйл ажиллагаа, тоогоор	300	-	100	Гэр бүл ёслолын ордон, Улсын бүртгэлийн хэлтэс
		3.6-2	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийт болон аж ахуй нэгж байгууллагуудыг татан оролцуулж, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж буй иргэд олон нийтийг урамшуулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	5,000,000 Дүүргийн төсөв	100	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хороодын ажлын алба, Цагдаагийн I, II хэлтэс
3.6	Гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлж, гэр бүлийг дэмжих чиглэлээр олон талт үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор зохион байгуулна.	3.6-2	Хүрсэн түвшин, хэрэгжилт Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн болон 23 хороодын Нийгмийн ажилтнууд төрийн болон төрийн бус 11 байгууллага, 17 аж ахуй нэгжүүдтэй хамтран Ерөнхий боловсролын 9 сургуулийн 1020 сурагчид болон 540 эцэг эхчүүдэд гэр бүлийн хүчирхийллийн хуулийг таниулах сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллалаа. Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зорилтод бүлгийн 25 өрхийн 50 эцэг эхэд "Хүүхэд хүмүүжлийн зөрөг арга" сургалтын талаар мэдээлэл өгч гарын авлага зөвлөмжийг тараасан. Цагдаагийн газар нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Гэр бүлийн радио 104.5" радиогоор сард 2 удаа урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл солилцож байхаар гэрээ байгуулан хамтран ажиллаж 9 удаагийн мэдээлэл өгч ажилласан. Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 27 хөршийн хяналтын бүлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллуулж бүлгийн гишүүдээс гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр мэдээлсэн зөрчлийн шинжтэй 51 мэдээллийг хууль тогтоомжийн дагуу шалган шийдвэрлэж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан 2 арга хэмжээний хүрээнд 450 ширхэг санамж, сэрэмжлүүлэг хуудсыг айл өрхүүдэд тарааж ажилласан. Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран архины хамааралтай, архинаас сайн дураараа татгалзаж байгаа иргэдэд сэтгэл зүйн зөөлөгөө, дэмжлэг үзүүлэх чиглэлээр долоо хоногийн Мягмар, Пүрэв гаригуудад 22 дугаар хорооны иргэдийн танхимд ганцаарчилсан уулзалт, сэтгэл заслын арга хэмжээг АА нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын бас нэг хэлбэр бол хүчирхийлэл үйлдсэн этгээд бүрт хуулийн хариуцлага ноогдуулах явдал юм.Иймээс тус хэлтэс нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдсон тохиолдол бүрт зөрчлийн тухай хуульд зааснаар 7-30 баривчлах шийтгэл оногдуулж байгаа бөгөөд эхний 6 сарын байдлаар 112 иргэнд баривчлах шийтгэл оногдуулаад байна. Иргэдэд тавих тайлангийн хурлын арга хэмжээний үеэр хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон Баянгол дүүргийн 5 дугаар хорооны иргэн Ц.Бадамсүмъяа, 13 дугаар хорооны иргэн Б.Зоригтбаатар нарыг Нийслэлийн Цагдаагийн газрын даргын "Талархал" бичиг тус бүр 20.000 төгрөг, 21 дүгээр хорооны иргэн С.Орлогыг Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын даргын Талархал" бичиг 20.000 төгрөгөөр шагнаж урамшуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан.					

	3.6-3	Залуучуудад гэр бүлийн боловсрол олгох сургалт, өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.	Зохион байгуулсан ажил, тоогоор	12	2,000,000	70	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
		Хамрагдсан хүн, тоогоор	3,000	Дүүргийн төсөв			
		Хүрсэн түвшин, хэрэгжилт Сар бүрийн сүүлийн 7 хоногийн бямба гарагийг "Гэр бүлийн өдөр" хэмээн тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд 2 удаагийн өдөрлөг зохион байгуулж, 510 иргэнд гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг танилцуулж, тэмцээн уралдаанд хамруулан урамшуулж ажиллалаа. 2019 оны 4 дүгээр сарын 28-нд "Гэр бүлийн өдөр"-ийг И-март сүлжээ дэлгүүрт зохион байгуулж 56 гэр бүл буюу 112 залуучуудыг үйл ажиллагаанд хамруулан ажиллалаа. 2019 оны 5 дугаар сарын 23-нд "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдвээр дулааны 4 дүгээр цахилгаан станцын 162 залуучуудад сургалтаа хүргэж ажиллалаа. Уг сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар гэр бүлийн аз жаргал, халуун дулаан уур амьсгал юунд оршдог, гэр бүлдээ зориулсан цаг хугацаа хэдий хэрийн үнэ цэнэтэйг орчин үеийн завгүй гэр бүлүүддээ бага ч болов ойлгуулах явдал байлаа. 2019 оны 07 дугаар сарын 18 болон 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрүүдэд тус тус "Анхаарал хариуцлага эрсдэлгүй орчин" аяныг зохион 300 гэр бүлийн 600 иргэнийг хамруулж ажиллалаа. 2019-2020 оны хичээлийн жил эхлэж байгаатай холбогдуулан дүүргийн 23 хороодын засаг дарга, аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллаж 100 хүүхдэд хичээлийн хэрэглэл, цүнх бэлэглэсэн. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран мэргэжил олгох 45 хоногийн сургалт зохион байгуулж 10 иргэнийг хамруулсан. Тус сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар гэр бүлийн аз жаргал, халуун дулаан уур амьсгал юунд оршдог, гэр бүлдээ зориулсан цаг хугацаа хэдий хэрийн үнэ цэнэтэйг орчин үеийн завгүй гэр бүлүүддээ ойлгуулах, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой гэр бүлийн хүүхдийн суралцах эрхийг хангах зэрэг үр дүнгүүд гарч байна.					
3.6-4	Гэр бүл, хүүхэд, залуучуудад чиглэсэн үйлчилгээний мэдээлэл хяналтын тогтолцоог бэхжүүлж, "Intranet.gov.mn" хүүхэд хамгааллын нэгдсэн программ "Эрсдлийн түвшин тогтоох программ"-д баяжилт, бүрдүүлэлт хийж, ашиглалтыг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс	
Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн судалгааг 23 хороодоос нэгтгэн авч эрсдлийн түвшин тогтоох "Intranet.gov.mn" программ-д бүртгэлжүүлэх ажил хийгдэж байна. 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 645 хүүхдийн мэдээлэл орж эрсдлийн зэргийн үнэлгээг хийж, үүнээс эрсдэл өндөр 60 хүүхдийг сонгон авч "Хүүхдийн эрсдлийн даатгал"-ын үйлчилгээнд хамруулахаар ажиллаж байна.							
ДӨРӨВ. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ ИРГЭНТЭЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ							
	4.1-1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төсөл хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс,
		Хүрсэн түвшин, хэрэгжилт Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр батлагдсантай холбоотойгоор Баянгол дүүргийн хэмжээнд 2019 оны эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийн талаарх мэдээллийг Хэлтсийн цахим хуудас, нийгмийн сүлжээ, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан хорооны мэргэжилтнүүдэд хүргэж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гэрээтэй вэб сайт, хороодын мэдээллийн самбарт байршуулан, UBS ТВ, Өлзий ТВ, SBN телевизийн шууд нэвтрүүлгээр 4 дээш удаа хүргэж мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд түргэн шуурхай, тэгш хүртээх зорилтыг хангаж ажилласан. Үүний үр дүнд нийт 3200 гаруй иргэнд зар мэдээ хүрсэн байна. 35-с дээш хөдөлмөрийн насны иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр төсөлд -138 иргэн хүсэлт ирүүлснээс 69 иргэний төслийг шалгаруулж 291,400,000₮ олгосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр төсөлд-68 иргэн хүсэлт ирүүлснээс 40 иргэн шалгарч 155,000,000 төгрөг олгосон. Ахмад настны ажлын байрыг дэмжих хөтөлбөр төсөлд -49 иргэн хүсэлт ирүүлснээс 17 төсөл шалгарч 36,000,000 төгрөгийн санхүүжилт олгогдож 26 байнгын ажлын байр бий болсон. Ахмад мэргэжилтний зөвлөл үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 29 иргэн материал ирүүлснийг судлан 16 ахмад мэргэжилтний зөвлөл үйлчилгээг дэмжин гэрээ байгуулан ажиллаж байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг Монголын Үндэсний маркетингийн холбоо төрийн бус байгууллагатай хамтран хавар намартаа зохион байгуулах гэрээг байгуулж хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийн бүртгэлийг цахимаар явуулж 235 залуучууд бүртгүүлж 3 өдрийн сургалтад 149 залуучуудыг хамруулав. 55 шинэ бизнес санаанаас 27 гарааны бизнес төсөл 5 долоо хоногын хурдасгуур хөтөлбөрт хамруулсан. Үүнээс нийт 20 баг шалгарч 190,000,000 сая төгрөгийн гарааны санхүүжилтыг авсан. Үүний үр дүнд: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төсөл хэрэгжүүлж 2019 оны жилийн эцсийн байдлаар хүсэлт гаргасан 520 гаруй иргэдээс шалгарсан 162 төсөлд 672,400,000₮-ийн санхүүжилт олгосон байна. Иргэд төсөл хөтөлбөрт хамрагдсанаар өрхийн үйлдвэрлэл болон ажлын байрыг дэмжсэн үйл ажиллагаа болж байна.					

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээг хөдөлмөр нэмэгдүүлж, нэг өрх, нэг хашаанд хүрч ажиллах зарчмыг баримтална.

4.1-2	Мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулна.	Хамрагдах хүн, тоогоор	5000	5,000,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт					
	Ажил идэвхтэй хайж байгаа, бүртгэлтэй ажилгүй болон зорилтод бүлгийн иргэдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээнд 15-55 насны нийт 1300 иргэнийг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр, мэргэжил олгох түр сургалт, мэргэжлээ хэрхэн зөв сонгох, ажил хайх арга зам, ажилд ороход шаардлагатай бичиг баримт боловсруулах, ажлын ярилцлагад хэрхэн бэлдэх талаарх зөвлөгөө мэдээллийг өгсөн байна. Үйлчилгээ авсан иргэдийг зорилтод бүлгээр авч үзвэл: Ажил хайгч 451, ажилгүйдэлд өртөж болзошгүй 59, ажил олоход хүндрэлтэй иргэн 68, ХБИргэн 11, ЕБС-н сурагч 369, их дээд сургууль төгсөгч 285, ажилтан, албан хаагч 38, гадаадаас эргэн ирсэн 19 иргэн байна. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх бүлгийн сургалтыг ЕБС болон МБС-ийн сургуулийн төгсөх ангийн сурагчид болон ажил хайгч 5250 иргэдэд 20 удаагийн сургалт зохион байгуулж, ажил мэргэжлийн чиглэлийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаас ажил, мэргэжлийн онцлог, хөдөлмөрийн зах зээл, өөрийн нөөц боломжийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болсноор зорилгоо зөв тодорхойлж, ажил, мэргэжлээ оновчтой сонгох, ажил хайж олох, ажлын байранд дасан зохицох, хөдөлмөрийн харилцааны талаар мэдээлэлтэй болсон. Үүний үр дүнд мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сурталчлах чиглэлээр 1300 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан сургалт зөвлөгөө өгч 20 удаагийн мэргэжил сурталчлах арга хэмжээнд 5250 иргэнийг хамруулан чиг баримжаа олгосон байна.					
4.1-3	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй мэргэжилтэй иргэдийг тогтвортой ажлын байраар хангах ажлыг зохион байгуулна.	Ажлын байранд зуучлуулах бүртгэлтэй ажил хайгч иргэд, тоогоор	500 дээш	-	100	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт 2019 оныг "Иргэд төвтэй хөдөлмөр эрхлэлтийн жил" болгон зарласантай холбогдуулан хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем LMIS програмд шинээр болон хуучин бүртгэлтэй байсан ажил идэвхтэй хайгч 1685 иргэн бүртгэгдэн 1008 иргэнийг байнгын ажлын байранд зуучилснаас хөгжлийн бэрхшээлтэй 25 иргэн байна.					
4.1-4	"Хүчтэй бай" төслийн хүрээнд ажилгүй иргэдийг бүртгэн ажилд зуучлах, мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд хамруулна.	Шинээр ажлын байртай болох ажилгүй иргэд, тоогоор	500 дээш	-	100	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс санаачлан хэрэгжүүлж байгаа "ХҮЧТЭЙ БАЙ" төслийн хүрээнд 2017 онд цахим групп нээсэн бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар ажил хайгч 1075 иргэн нэгдсэн байна. Тус хуудас 2019 оны 05 дугаар сард "Баянгол дүүргийн ажил хайгчдын нэгдсэн групп" нэртэйгээр шинэчлэгдэж шинээр зарлагдсан ажлын байрны 2900 зарыг тогтмол шинэчлэн оруулж иргэдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэн, иргэдийн холбогдох асуултад цахим хуудсаар дамжуулан тогтмол хариулт өгч ажиллалаа. Тус цахим группт ажлын байрны зар байршуулахаас гадна төсөл хөтөлбөр бусад хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэл цаг үеийн холбогдолтой асуудлаар мэдээлэл хийж иргэдэд хүртээл болгож байна. Үүний үр дүнд ажил хайгч иргэн өөрт тохирох ажлын байртай болох, тухайн иргэдээр дамжин ажлын байрны зар олон нийтэд 7/24 цаг зарчмаар хүртээмжтэй хүргэж байна.					
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана.	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдах иргэн, тоогоор	20		100	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
		Санхүүгийн дэмжлэг авах иргэн, тоогоор	50			
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдах иргэн, тоогоор	30			
		Ажил олгогчийн урамшуулал авах иргэн, байгууллага, тоогоор	3			

4.1-5	Хүрсэн түвшин, хэрэгжилт Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр батлагдсантай холбоотойгоор Баянгол дүүргийн хэмжээнд 2019 онд 2 удаа төсөл зарлагдсан бөгөөд 2019 оны эргэн төлөлттэй санхүүгийн талаарх мэдээллийг Хэлтсийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайт, хороодын мэдээллийн самбарт байршуулснаар нийт 3752 гаруй иргэнд зар мэдээ хүрсэн байна. Тус төсөл хөтөлбөрт Аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэд буюу байнгын асаргаанд байдаг хүүхдээ асардаг эцэг, эхчүүдээс нийт 68 төсөл ирүүлсэн байна. Үүнээс 40 төсөл дэмжигдэж 155,000,000 төгрөгийн санхүүжилт олгогдож 78 байнгын ажлын байр бий болсон. 2019 оны 03 дугаар сард Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэлтэстэй хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй иргэдэд төсөл бичих аргачлал"-ын сургалтыг зохион байгуулав. Тус арга хэмжээнд 46 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэдгээрийн асран хамгаалагчид хамрагдаж 2019 онд хэрэгжих "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр" "Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр" хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний талаар мэдээ мэдээлэл авсан байна. Мөн 5 сард гэрээ байгуулсан 3 байгууллагатай хамтран аж ахуй эрхлэх сургалтад 90 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулан хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэх үр чадварт суралцах сургалтанд хамруулав. 2019 оны 05 сард Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо төрийн бус байгууллагын хүсэлтийн дагуу хөтөч чиглүүлэгчийн дэмжлэгтэйгээр хараагүй иргэдийг ажилд зуучлах гэрээг байгуулан ажиллуулж байна. Мөн 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжлэгтэйгээр ажилд зуучлан байгууллагатай 3 талт гэрээ байгуулав. Мөн 3 байгууллага 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулан ажил олгогчийн урамшуулал хамрагдах хүсэлт гаргасныг үндэслэн 3 талт хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Үүний үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн санхүүгийн дэмжлэгт 40, Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 157, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээнд 9 иргэн тус тус хамрагдаж нийт 206 хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авснаар бусдын адил өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна. Тус хөтөлбөрт хамрагдсанаар өөрийн мэргэжил, үр чадварт нийцсэн хөдөлмөр эрхлэх, улмаар орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байгаа юм.					
	Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдэд боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүргэх замаар зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулна	Хамрагдсан өрх, тоогоор	700	40,000,000 Дүүргийн төсөв	100	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс,
4.1-6	Хүрсэн түвшин, хэрэгжилт "Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-т хамрагдаж буй зорилтот бүлгийн ӨМНС-н 409,672 босго онооноос доогуур 700 өрхийг сонгон авч 23 хорооны АДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн өрхийн хэрэгцээний судалгааг тодорхойлж 2019 онд хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2019 оны 02 дугаар сарын 03-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Сар шинийн баяр"-ын арга хэмжээг зохион байгуулж зорилтот бүлгийн 540 ахмад настанд гарын бэлэг гардуулан хүндэтгэл үзүүллээ. 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр "Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтан "Ачлалтай ээжүүд" арга хэмжээг зохион байгуулав. Тус арга хэмжээнд зорилтот бүлгийн өрх толгойлсон 23 ээж оролцсон бөгөөд өрхийн үйлдвэрлэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын талаар мэдээлэл өгч, гарын бэлэг гардуулан нэгэн өдрийг үр дүнтэй өнгөрүүлээ. 2019 оны 05 дугаар сарын 11 ний өдөр Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан Нийслэлийн нийгмийн халамжийн газар, Гэрлэх ёслолын ордонтой хамтран "Гэр бүлийн үүрэг хариуцлага" сэдэвт арга хэмжээг зохион байгуулан 69 эцэг эхийг хамруулан ажиллалаа. 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдөр "Дэлхийн гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн 89 эцэг эхэд "Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо" сэдэвт сургалтад хамруулж хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж ажиллав. 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эрсдэлт нөхцөлд байгаа 165 хүүхдэд чиглэсэн баярын арга хэмжээг зохион байгуулав. 2019 оны 06 дугаар 10-ны өдөр Хайрхан бүрд ТББ-тай хамтран Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулан-66 иргэнийг хамруулан ажиллав. 2019 оны 09 дүгээр сарын 01-ний Хичээлийн шинэ жилийн баярыг угтан зорилтот бүлгийн 10 хүүхдэд хичээлийн хэрэгсэл олгож ажиллалаа. "Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр" хамрагддаг ажил хөдөлмөр эрхлэх боломжтой хөдөлмөрийн насны иргэдийг Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр байнгын ажлын байранд 129 иргэн, түр ажлын байранд 54 иргэн, нийтийг хамарсан ажилд 24 иргэн, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 32 иргэнийг тус тус хамруулан нийт 239 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамруулан ажиллаж хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээ зохион байгуулан ажилласан байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 1201 иргэнд боловсрол, сэтгэлзүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүргэх замаар зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулан ажиллаж тухайн өрхийн 239 иргэн байнгын болон түр ажлын байртай болж өрхийн орлого нэмэгдэн, амьдралын нөхцөл боломж дээшилсэн байна.					
	Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих гадаад болон дотоод үзэсгэлэн худалдааг зохион байгуулна	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, тоогоор Хамруулах иргэн, ААН тоо	5 250	14,000,000 Дүүргийн төсөв	100	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв

4.2

<

4.3	Дүүргийн нутаг дэвсгэрт хувиараа бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, зах зээлийг өргөтгөх, үйл ажиллагааг сурталчлах, туршлага солилцоход дэмжлэг үзүүлнэ.	4.3-1	"Бизнес инкубатор" төв байгуулах зорилгоор 11, 20 дугаар хорооны хуучин байрыг засварлах ажлыг зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн 20 дугаар хорооны хуучин байр, 23 дугаар хорооны хуучин өрхийн эмнэлэгийн байрыг засварлаж "Бизнес инкубатор" төвийг байгуулан дүүргийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулан үйл ажиллагаагаа эхлэхээс нь тогтворжих хүртэл бойжуулж, түрээсийн төлбөр багатай тогтвортой ажлын байраар ханган, бизнесийн сургалтанд хамрагдах, дотоод гадаадын үзэсгэлэн худалдаанд оролцох, борлуулалтын орлогоо нэмэгдүүлэх зөвлөгөө мэдээллээр хангагдах боломжтой болно. Тухайн байруудад засварын ажил хийгдэж дуусан ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	20,000,000 Дүүргийн төсөв	100	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв
		4.3-2	Үсчин гоо засалчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох уралдаан тэмцээнийг зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр "One event half"-д 10 дахь удаагаа зохион байгуулагдсан "Улаанбаатар-380" Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд батлагдсан удирдамжийн дагуу "Шилдэг эрэгтэй үсчин", "Шилдэг эмэгтэй үсчин", "Шилдэг гоо засалч" гэсэн гурав нэр төрлөөр 8 дүүргийн 80 гаруй мэргэжлийн үсчин, гоо засалч, хумс засалчид өрсөлдөж, Баянгол дүүргээс 6 үсчин, гоо засалчид авьяас ур чадвараа сорин оролцож, туршлага солилцлоо.	Зохион байгуулах тэмцээн, тоогоор	1 удаа	3,000,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс
		4.3-3	Аж ахуйн нэгж, байгууллагын "Бизнес уулзалт, зөвлөгөөн" зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар болон Монголын бизнес эрхлэгчдийн боловсролын академи хамтран байгуулсан "Санамж бичиг"-ийн хүрээнд Токиогийн магадлан итгэмжлэгдсэн "И Би Эй менежментийн зөвлөхийн сургууль"-ийн захирал, бизнесийн зөвлөх ноён Ахиохиро Эгүчийг урьж оролцуулсан "Япон улсын гарааны бизнес ба жижиг, дунд бизнесийн хөгжил, туршлага" сэдэвт жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээлийг өргөжүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх, шинэ суваг нээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулагдсан сургалтанд дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хамт оролцлоо. Сургалтаар Монгол улсын гарааны бизнес болон жижиг дунд бизнесийн хууль, эрх зүйн орчин, цаашдын чиг хандлага, Япон улсын гарааны бизнес ба жижиг дунд бизнесийн хөгжил, туршлага, Япон-Монголын бизнесийн зах зээлийн ерөнхий чиг хандлага зэрэг сэдвээр ярилцан жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний танилцуулга хийн, практик зөвлөгөө, санал солилцох, бүтээгдэхүүний загвар, жишээ, дээж танилцуулах зэрэг арга хэмжээг зохион байгууллаа. Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/2943 дугаар албан бичгийн хүрээнд Нийслэлийн 380 жилийн ойг угтан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан "Их хотын хямдрал – Бизнес фестиваль 2019" арга хэмжээнд дүүргийн 20 гаруй аж ахуйн нэгжийг хамрагдаж, нийслэлийн иргэдэдээ хямдралтай үнээр бараа бүтээгдэхүүнээр үйлчиллээ. Арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан Парад алхалтанд дүүргийн 120 гаруй албан хаагч, мөн дүүргийн "Од групп" ХХК, "Ноён пицца" ХХК, "Баталгаат хүнс" ХХК, "Дамдинсүрэнгийн Батжаргал" ХХК, "Монгол маркет" ХХК гэх мэт томоохон аж ахуйн нэгжийн хамт алхлаа. Мөн төв талбайд байршуулсан 5 асарт хуваарилагдаж оролцсон аж ахуйн нэгжүүд 30%-50% - ийн хямдралтай, урамшуулалтай, сугалаатай худалдаа, үйлчилгээ гарган 1.650.000 төгрөгний борлуулалт хийлээ. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны "Төсөл сонгон шалгаруулалтын үр дүн, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа", хил дамнансан цахим худалдааг хэрхэн үр дүнтэй хийх зэрэг холбогдох мэдээлэл хүргэж мөн ижил төстэй бизнес эрхлэгчидтэй туршлага солилцсон сургалт, зөвлөгөөнийг 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 02/360 дугаар албан бичгийн хүрээнд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Баянгол дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Баянзүрх дүүрэг хамтран 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Үйлдвэрлэлийн зохиистой дадал, дотоод хяналтын тогтолцоо нэвтрүүлэх нь" сэдэвт сургалтанд дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 20 гаруй үйлдвэрийн 25 ажилтан, албан хаагчыг хамруулж оролцлоо. Нийслэлийн 380 жилийн ойг угтан 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Нийслэлийн шилдэг аж ахуйн нэгж, бүтээн байгуулалт, барилга байгууламж, дэвшилтэт техник технологи, үйлчилгээ нэвтрүүлсэн байгууллага, брэнддинг, гарааны бизнес гэсэн төрлөөр шилдгүүдийг тодруулдаг "Гаруда 2019" ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд дүүргийн үйлдвэрлэл эрхлэгч "Грийн Индастри" ХХК-г дэмжин уламжилсанаар дэвшилтэт техник, технологи, үйлчилгээ нэвтрүүлсэн байгууллага төрөлд шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/220 дугаар тушаалын хүрээнд дүүргийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн "Үйлчилгээний соёл 5S-ийг хэрэгжүүлэгч шилдэг байгууллага аяныг зохион байгуулах тухай" А/418 дугаар захирамжийг гарган дүүргийн хэмжээнд худалдаа, нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон аж ахуйн нэгжүүдэд захирамжийг хүргүүлж, 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Бүтээмжийг дэмжих төв, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран худалдаа, нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аяныг дүүргийн 30, Сонгинохайрхан дүүргийн 20 томоохон аж ахуйн нэгжүүдэд сургалтыг зохион байгууллаа.	Уулзалт зөвлөгөөн, тоогоор Хамрагдах бизнес эрхлэгч, тоогоор	2 удаа 250	5,000,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв.
			Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдийн дунд "Баянголд үйлдвэрлэв" шошготой брэнд бүтээгдэхүүнийг тодруулах, сурталчлан таниулах зорилготой "Шилдэг үйлдвэрлэл эрхлэгч" шалгаруулах ажлыг зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт	Шалгаруулалт, тоогоор	1	5,000,000 Дүүргийн төсөв	100	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв

4.4	Дүүргийн зарим томоохон гудамж, өргөн чөлөөнд худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, улирлын ажиглагаатай худалдааны гудамжтай болно.	4.3-4	Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилан, шилдэг үйлдвэр эрхлэгчид болон шинээр үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг "Баянголд үйлдвэрлэв" facebook хуудас, mibgd.mn байгууллагын веб хуудсанд байршуулан сурталчлагаа хийж ажиллалаа. 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн аж ахуй нэгжүүдийн дунд "Баянголд үйлдвэрлэв" шошготой бренд бүтээгдэхүүнийг тодруулах, сурталчлан таниулах зорилготой "Шилдэг үйлдвэрлэл эрхлэгч"-ийг шалгаруулж, урамшуулан сурталчлагаар 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн №02 тоот журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг бусдад таниулах сурталчлах зорилгоор "Баянголд үйлдвэрлэв" цахим хуудсанд дүүргийн 100 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний зурагт танилцуулгыг байршуулан үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах сувгийг нэмэгдүүлсэн. "Баянголд үйлдвэрлэв" гар утасны аппликейшныг гар утасны "iOS", "андроид" үйлдлийн системд, /Play store, App store-/оос үнэ төлбөргүй татах, ашиглах боломжтой боллоо. Тус программын танилцуулгыг 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Баянгол дүүргийн бизнес эрхлэгчийн уулзалт, зөвлөгөөний арга хэмжээний хүрээнд бизнес эрхлэгчдэд албан ёсоор танилцуулсан. Тус аппликейшэнд өнгөрсөн хугацаанд 100 иргэн, аж ахуй нэгж байгууллага бүртгэгдэж, 250 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний танилцуулгыг сурталчилсан байна. "Баянголд үйлдвэрлэв" гар утасны аппликейшны танилцуулгатай нугалбар брошур 500ш, мэдээлэл бүхий тараах материал 500ш-ийг тус тус хэвлүүлэн, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэн ажилласан.						
		4.3-5	Дүүргийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн, нэгтгэсэн "Баянголд үйлдвэрлэв" цуврал сэтгүүл гаргана. Хүрсэн түвшин, хэрэгжилт	Сэтгүүлийн дугаар, тоогоор Хамрагдах ААН, иргэд, тоогоор	2 100	3,500,000 Дүүргийн төсөв	100	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	
		4.4-1	Дүүргийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн нэгтгэсэн "Баянголд үйлдвэрлэв" цуврал сэтгүүлд оролцох 100 аж ахуй нэгж байгууллагын танилцуулга бүхий сэтгүүлийг хэвлэж, иргэд ААН-д хүргээд байна. Мөн аж ахуй нэгж байгууллагын мэдээллийг MIBGD.mn, bayangold uildverlev, "Баянголд үйлдвэрлэв" аппликейшэнд байршуулан, сурталчлан ажиллаж байна. Улирлын худалдаа үйлчилгээг зохион байгуулж, түр ажлын байраар хангана. Хүрсэн түвшин, хэрэгжилт	Түр ажлын байр, тоогоор	50	-	(-)	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	
		4.4-2	49 байршилд улирлын түр ажлын байраар хангах тухай Дүүргийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/297 тоот захирамж 18 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг батлуулан түр зөвшөөрөл олгохоор батлуулсан боловч дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн 2019 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 02-13/117 тоот албан бичгээр улирлын түр зөвшөөрөл олгохгүй байхыг мэдэгдсэн тул түр зөвшөөрлийг олгоогүй байна. Төсөл хөтөлбөрт хамрагдаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан иргэдийг үзэсгэлэн яармаг худалдаанд оролцуулж, шаардлага хангасан түрээслэгчдэд түрээсийн хөнгөлөлт олгоно. Хүрсэн түвшин, хэрэгжилт	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	40	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	
		4.5-1	Алслагдсан хороодод ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдэд сургалт зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт	Сургалт, тоогоор	2 удаа	2,000,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	
		4.5-1	2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр дүүргийн 23 хороодын 100 орчим хүнсний ногооны тарих сонирхолтой иргэдэд Нийслэлийн Хөдөө аж ахуйн газар, Баянгол Агро-Парк ОНӨААТҮГ-тэй хамтран "Хүнсний ногоо тарьж ургуулах арга, технологи" сэдэвт онол, практикын сургалтыг явуулж, тараах материал, гарын авлагаар хангаж ажиллалаа. Мөн 2019 оны 03 дугаар сарын 19-ны өдөр Төв аймгийн "Атрын шим" ХХК-ийн хүлэмжид "Хүлэмжийн хүнсний ногоо тариалах, хүлэмжийн хөрсийг боловсруулах аргачлал" сургалтанд дүүргийн хүнсний ногоо тариалагч 5 иргэнийг хамруулан ажиллалаа 2019 оны 08 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Нийслэлийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн газраас Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд зохион байгуулагдах "Жимс, жимсгэнэ нийлүүлэгчдийн хураалтын технологи, талбайн зохистой дадал нэвтрүүлэх тухай онол практикийн вакумжуулсан сургалт"-д дүүргийн жимс, жимсгэнэ тариалагч 5 иргэнийг хамруулав. 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Шангрила төвд "Хүн амын ахуйн үйлчилгээ-2020" хөтөлбөрийн хүрээнд "Үлэмж грийс" ХХК, Сүхбаатар дүүрэг хамтран зохион байгуулсан үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, стандартыг танилцуулах, шинэлэг технологи сурталчлах, харилцан туршлага солилцох, танилцах сургалтад 10 үсчин, гоо сайханчдыг хамрууллаа.						

4.5	Гэр хороололд ахуй үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4.5-2	Дүүргийн иргэдийн хэрэгцээ, шаардлага, стандартад нийцсэн ахуй үйлчилгээний газруудыг дэмжиж ажиллана Хүрсэн түвшин, хэрэгжилт Австралийн Элчин сайдын яам, Зориг сангаас хамтран зохион байгуулагдаж буй "Эмэгтэйчүүдийн манлайлал" хөтөлбөрийн хүрээнд "Эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд хүчирхэгжүүлэх нь" төсөлд дүүргийн ахуйн үйлчилгээ эрхэлдэг 20 эмэгтэйг хамруулж дэмжин уламжиллаа. Үүнээс оёдол эрхэлдэг 6 эмэгтэй төсөлд шалгаран цаашид хөнгөлттэй зээл тусламж, сургалт хөтөлбөрт хамрагдах боломж бүрдээд байна. Дүүргийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн "Иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчилгах аяныг зохион байгуулах тухай" А/410 дугаар захирамж гарган, ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг хуралдан төлөвлөгөөг батлаж, төлөвлөгөөний дагуу ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 22 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг шинэчлэн баяжуулж, 23 хороо, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулж байна. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудал /агаар, ус, хөрсний бохирдол, нийтийн тээвэр/-ийг шийдвэрлэхэд гадаад улс, хотуудын туршлагаас судлаж нэвтрүүлнэ" ажлын хүрээнд гэр хороололд автомат угаалгын газар бүхий "Нийтийн аж ахуйн үйлчилгээний төв" байгуулах төслийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх халуун усны газруудын судалгааг гарган, Улаанбаатар хотын Хөгжлийн Корпораци ХК-ын мэргэжилтэнүүдийн хамт газар дээр нь очиж танилцлаа. Судалгаанд хамрагдсан 15 халуун усны газраас дүүргийн 10 дугаар хороо, Усан сангийн ард байрлах Нийслэлийн өмчит халуун усны газар, 20 дугаар хороо, Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн урд байрлах Нийслэл, дүүргийн өмчит халуун усны газраас бусад объектууд нь орон нутгийн өмчит бус халуун усны газрууд байсан. Дүүргийн 10 дугаар хороо, Усан сангийн ард байрлах Нийслэлийн өмчит халуун усны газар үйл ажиллагаа зогссон боловч ашиглагдах боломжтой гэж тодорхойлсон. Тус судалгааг гаргаснаар иргэдэд сэтгэлд нийцсэн шинэлэг үйлчилгээ бий болж, үйлчилгээний шинэ чанар стандартыг нэвтрүүлэх боломж бүрдэж байна. 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 06/2358 дугаар албан бичгээр гэр хороололын оршин суугчдын амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор ахуйн үйлчилгээний төв байгуулах боломжтой 5 гэр хороололын байршлын судалгааг Нийслэлийн Захирагчийн Ажлын албанд хүргүүлээд байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	70	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс
		4.5-3	Дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн бие засах газрыг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах төсөв хөрөнгийг тодорхойлно. Хүрсэн түвшин, хэрэгжилт Монгол Улсын 2019 оны төсөвт Баянгол дүүргийн 11, 15, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Нийтийн бие засах газар" барих ажлын 180.0 сая төгрөгийг батлуулж 11 дүгээр хороо "Ахуйн үйлчилгээний автобусны буудал", 15 дугаар хороо "Начинзаан ломбард", "Бирлен бургер" хоёрын дунд, 16 дугаар хороо "Модны 2 автобусны буудал" орчимд хийхээр төлөвлөн газрын кадастрын зургийг "Классик лэнд" ХХК-аар гүйцэтгүүлэн Нийслэлийн Засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/949, 10 дугаар сарын 24-ний А/1120 дугаар захирамжаар газрын гэрчилгээг гаргуулсан. Нийслэлийн Хот байгуулалтын хөгжлийн газарт архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулах хүсэлтийг гаргасан боловч татгалзсан хариу ирсэн тул төсөл, арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	40	Тохиржилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Төлөвлөлт гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс
		4.6-1	Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй хүнсний бүтээгдэхүүн худалдаалж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг зогсооно. Хүрсэн түвшин, хэрэгжилт 2019 онд Баянгол дүүргийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж 13, 14, 7, 20, 5 дугаар хороонд ил задгай, зөвшөөрөгдөөгүй цэгт гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний бүтээгдэхүүн худалдаалж байсан иргэдийн үйл ажиллагааг зогсоож, Цагдаагийн газар хянан шийдвэрлэж, нийт 1336 зөрчилд 64,650,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна. Баянгол дүүргийн "Шуурхай баг", Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ, Баянгол дүүргийн Цагдаагийн газар, Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр нийтийн эзэмшлийн зам болон авто замын ногоон байгууламжид худалдаа хийж байсан иргэдэд хяналт шалгалт хийсэн. Баянгол дүүргийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн "Нийтийн эзэмшлийн зам талбайд ил задгай, сүү цагаан идээ, хүнсний ногооны худалдаа эрхэлж буй иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай" А/415 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд 6 удаагийн хяналт шалгалт хийж зөрчлийг таслан зогсоож, хяналт тавьж ажиллалаа. Мөн дүүргийн 20 дугаар хороо, Хархорин худалдааны төв орчмын ил задгай худалдаа эрхлэгчдийн судалгааг дахин шинэчилэхэд, нийт 86 иргэнээс 61 иргэн Сонгинохайрхан дүүргийн иргэн гэсэн үр дүн гарсан. Иймд тус иргэдийг ажлын байраар хангаж, зөвшөөрөлгүй ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг таслан зогсооход хамтран ажиллах саналыг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 06/2215 дугаар албан бичгийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ж.Сандагсүрэнд хүргүүлээд байна. Мөн дүүргийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн "Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй ил задгай худалдааг зогсоох тухай" А/513 дугаар захирамж гарган холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	1,000,000 Дүүргийн төсөв	70	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс

Дүүргийн хүн амын хүнсний эрүүл, аюулгүй бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулж хяналт тавих, эрүүл хүнсээр хангах, төмс хүнсний ногоо тариалах болон худалдан борлуулахад дэмжлэг үзүүлнэ.

	Хүнсний дэлгүүр, цайны газруудад хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.	Хяналт шалгалт, тоогоор Хамрагдах хүнсний дэлгүүр, цайны газар, тоогоор	4 200	1,000,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй олон улсын сүлжээ дэлгүүрүүд болох "Сиркле Кий" ХХК, "Сэнтрал экспресс Си ви эс" ХХК нь дэлгүүрүүдэд 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хяналт шалгалт хийж, хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн Нийслэлийн онцгой комиссын даргын 2019 оны 01 дүгээр сарын 15-ны 01 дугаар тушаалаар Нийслэлийн нутаг дэвсгэрт импортын бүтээгдэхүүнээс гоц халдварт африкийн гахайн мялзан өвчин илэрсэнтэй холбогдуулан Баянгол дүүргийн гахайн аж ахуй, үйлдвэрийн шалгалтын хэсэг 72 цагийн хугацаанд хяналт шалгалт зохион байгуулж, хоол үйлдвэрлэлийн 62, худалдааны 80, үйлдвэр 14 аж ахуйн нэгж байгууллагад хийж нийт 102 байгууллагын 9552.66 кг махыг битүүмжилж, 88 байгууллагын 7020 кг махыг битүүмжлэлийг буцаан нээлгэж, 11 байгууллагын 225.61 кг махыг устгаж ажилласан байна. МХЕГ-ын даргын баталсан 01/04 дугаартай удирдамжийн дагуу Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 119 аж ахуйн нэгж, 185 иргэнийг хамруулан шалгалт хийлээ. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар нийт 115 зөрчил дутагдал илэрснээс 60 буюу 52.1 хувийг арилгуулж, хүнсний худалдаанаас 276.0 мян/төгрөгийн үнэ бүхий тээвэрлэлтийн явцад хэлбэр дүрсээ алдсан 90 ширхэг пирожен /рулет/, хагт шошгын шаардлага хангаагүй Zombies нэрийн 12 ширхэг чихрийн худалдаалалтыг зогсоон буцаан татан авалт хийлгүүлж, 6 нэрийн 8 ширхэг 119.0 мян/төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүнийг устгаж, зөрчил гаргасан 5 аж ахуйн нэгжид 5.0 сая, 16 иргэнд 6950 мян/төгрөгийн нийт 21 ААНБ, иргэнд 11950.0 мян/төгрөгийн /арван нэгэн сая өсөн зуун тавин мянган төгрөг/ торгуулийн арга хэмжээ авч, 10450 мян/төгрөгийг барагдуулж, албан даалгавар хүргүүлсэн. Хүнсний боловсруулах үйлдвэрт зохистой дадал, дотоод хяналтын тогтолцоо нэвтрүүлж, эрүүл, аюулгүй бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор гурилан бүтээгдэхүүний чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад "Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал, дотоод хяналтын тогтолцоо нэвтрүүлэх нь" сэдэвт сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав. Баянгол дүүргийн гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжийн 20 албан хаагч оролцсон. Сургалтад НХХААГ-ын Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Р.Ундармаа "Хүнсний үйлдвэрлэлийн салбарт төрөөс баримталж буй бодлого"-ын талаар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас "Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн (GMP, GHP) зохистой дадлыг хэрэгжүүлэх зөвлөмж, анхаарах асуудал, Олон улсын менежментийн тогтолцооны стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэгжүүлэх нь, нэвтрүүлснийг баталгаажуулах үйл явц"-ын талаар мэдээлэл хийлээ. Монгол Улсын Шадар сайдын баталсан "Үйлдвэрийн барилга байгууламжид Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамж", дүүргийн Засаг даргын хяналт шалгалтын удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2019 оны 05-р сарын 01-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Баянгол дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 12 байгууллагад дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Онцгой байдлын хэлтэстэй хамтрассан хяналт шалгалтын ажлыг хийж, 91 зөрчил илрүүлж, 38 зөрчлүүдийг газар дээр нь арилгуулан, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 10, Мэдэгдэл 2, танилцуулга 1-ийг бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, зөрчлийн тухай хуулийн 5.14 дэх заалтын хүрээнд 1 хүн, 2 хуулийн этгээдийг 2,300,000 төгрөгөөр торгож, хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хамтарсан тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төв, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүнсчдийн холбоо хамтран 2018 оны хоёрдугаар сараас эхлэн "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" арга хэмжээний хоёрдугаар үе шатанд Баянгол дүүргийн 11, 85, 94, 97, 242 дугаар цэцэрлэгүүд тус тус хамрагдах бэлзэлийг хангасан тул 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 06/2547 дугаар албан бичгээр холбогдох материалуудыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны худалдаа, нийтийн хоолны хэлтэст хүргүүлсэн байна.					
4.6-3	Дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний ногоо тариалж буй иргэн, ААНБ-дэд "Ургамал, ургамлын гаралтай түүхийг эд бүтээгдэхүүнд гарал, үүслийн гэрчилгээ" олгох, хяналт тавих ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	600,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 3 аж ахуйн нэгж, байгууллагад өргөст хэмх 89 тонн, улаал лооль 75 тонн, навчит ногоо 18 тонн тус тус ургамал, ургамлын гаралтай түүхийг эд бүтээгдэхүүнд гарал, үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллаж байна.					
4.6-4	"Намрын ногоон өдрүүд" шинэ ногооны үзэсгэлэн худалдааг зохион байгуулна	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	3,000,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр дүүргийн 23 хороодын 100 орчим хүнсний ногооны тарих сонирхолтой иргэдэд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Баянгол Агро-Парк ОНӨААТҮГ-тэй хамтран "Хүнсний ногоо тарьж ургуулах арга, технологи" сэдэвт онол, практикын сургалтыг явуулж, тараах материал, гарын авлагаар хангаж ажиллалаа. 2019 оны 03 дугаар сарын 19-ны өдөр Төв аймгийн "Атрын шим" ХХК-ийн хүлэмжид "Хүлэмжийн хүнсний ногоо тариалах, хүлэмжийн хөрсийг боловсруулах аргачлал" сургалтад дүүргийн хүнсний ногоо тариалагч 5 иргэнийг хамруулан ажиллалаа. 2019 оны 08 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд зохион байгуулагдах "Жимс, жимсгэнэ нийлүүлэгчдийн хураалтын технологи, талбайн зохистой дадал нэвтрүүлэх тухай онол практикийн вакумжуулсан сургалт"-д дүүргийн жимс, жимсгэнэ тариалагч 5 иргэнийг хамруулав. Дүүргийн 3 дугаар хороо, Барс худалдааны төв орчим зөвшөөрөлгүй ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд таслан зогсоож, хүнсний ногоо худалдаалж байсан 80 иргэнийг нэгдсэн зохион байгуулалтан дор "Намрын ногоон үзэсгэлэн худалдаа"-д хамруулж, ажлын байраар хангаж ажиллалаа. Хүнс, хөдөө аж ахуйн яамны, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 24-ний өдрүүдийн хооронд зохион байгуулагдах "Алтан намар" арга хэмжээнд оролцох 3 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэрсийг хүргүүлэн ажиллалаа.					

4.6-5	Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг дүүргийн иргэдэд хямдралтай үнээр нийлүүлэх, өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	Үзэсгэлэн худалдаа, тоогоор	2 удаа	3,000,000 Дүүргийн төсөө	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын алба, Иргэний танхим, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" хамтран дүүргийнхээ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, үйл ажиллагааг нь сурталчилах, тэдний өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Баянголд үйлдвэрлэв" цагаан сарын үзэсгэлэн худалдааг жил бүр уламжлал болгон 8 дахь жилдээ зохион байгуулж байна. Цагаан сар -2019 өргөтгөсөн худалдааг 2019 оны 01 дүгээр сарын 21-нээс 02 дугаар сарын 04-ийг хүртэл дүүргийн 20 дугаар хороо Барс-2, Соло молл худалдааны төвийн В1 давхарт дүүргийн нутаг дэвсгэрт жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ худалдаа эрхэлж буй 100 орчим иргэн аж ахуйн нэгжүүд цагаан сард зориулсан өргөтгөсөн худалдаанд оролцож өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ борлуулав. Мөн дүүргийн нутаг дэвсгэрт Улаанбаатар паласе ХХК, МҮЭТЗ-ийн соёлын ордон, Оргил худалдааны төв зэрэг газруудад өргөтгөсөн худалдаа зохион байгуулагдаж, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа. Мэргэжлийн хяналтын хэлтэс нь сар шинийн баярыг угтаж Барс-2 худалдааны төв, Улаанбаатар паласе, МҮЭСТО-д зохион байгуулагдсан хүнсний бүтээгдэхүүн-цагаан идээний үзэсгэлэн худалдаанд оролцож буй 96 иргэний худалдаалж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Хяналт шалгалтаар хаяг шошгын зөрчилтэй нийт 6 нэр төрлийн 141 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг татан авалт хийлгүүлж, түргэн гэмтэж муудах хүнсний бүтээгдэхүүнийг зөв хадгалж, худалдаалах талаар давхардсан тоогоор 118 ширхэг зөвлөмж хүргүүлэн ажилласан. "Мах сүүний анхдугаар аян"-ы хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 18, 19-ны өдрүүдэд Баянгол дүүргээс зохион байгуулагдсан махны өргөтгөсөн худалдаанд дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүд хяналт тавьж ажилласан. Махны өргөтгөсөн худалдаанд "Баатрууд тэнгэр" ХХК-ны хөдөлгөөнт нөөцийн мах борлуулах цэг 5 дугаар сарын 18-ны өдөр 14.1тн, 5 дугаар сарын 19-ны өдөр 9.9тн нийт 24тн махыг худалдааллаа. Монгол улсын Онцгой комиссын 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн өргөтгөсөн хуралдааны тэмдэглэлийн дагуу Нийслэлийн хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Баянгол дүүргийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/567 дугаар захирамжаар 13 дугаар хороо, Хишиг төвийн урд талбайд махны өргөтгөсөн худалдааг 2019 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Завхан, Өвөрхангай, Ховд аймгууд оролцож худалдаанд нийт-23,223 гулууз махыг дүүргийн иргэдэд хямдралтай үнээр борлуулсан байна.					
	"Үдийн цай" хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, цайны газруудын тогооч нарт мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалт зохион байгуулна.	Хяналт шалгалт, тоогоор Сургалт, тоогоор	3 2	2,400,000 Дүүргийн төсөө	40	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Боловсролын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс
4.6-6	Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/111 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/66 дугаар тушаалаар "Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP, GHP/ нэвтрүүлэх нь сэдэвт сургалтыг Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Э.Сансар, мэргэжилтэн Б.Бат-Өлзий, О.Баярмаа, Д.Батбаяр, Л.Даваацэрэн, Хоолзүй шим судлалын Монголын нийгэмлэгийн багш, Монгол Улсын зөвлөх инженер Ц.Байгалмаа нар хамтран 2019 оны 03 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтаар хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадалыг нэвтрүүлэх, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт "Давсны хэрэглээг бууруулах" үндэсний стратегийг хэрэгжүүлэх, хэрэглэгчдийн хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдлээ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хамтарсан тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төв, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүнсчдийн холбоо хамтран 2018 оны хоёрдугаар сараас эхлэн "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" арга хэмжээний хоёрдугаар үе шатанд Баянгол дүүргийн 11, 85, 94, 97, 242 дугаар цэцэрлэгүүд тус тус хамрагдах болзлыг хангасан тул 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 06/2547 дугаар албан бичгээр холбогдох материалуудыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны худалдаа, нийтийн хоолны хэлтэст хүргүүлсэн байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2019 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 01/54 дугаартай удирдамжийн дагуу 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгаж үнэлгээ дүгнэлт өгөх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх холбогдох хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор "Сэтгэмж цогцолбор", "Сейнт поул", "Хүрээ тулга" бүрэн дунд сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийн дагуу "Хүрээ тулга" бүрэн дунд сургуулийн цайны газрыг ажиллуулж байгаа Баянхангай ХХК-д улсын ахлах байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлэн, "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах талаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн захирал удирдлагуудад хэлтсийн 02-13/174 дугаартай албан бичиг, НМХГ-ын даргын 02-01/3478 дугаартай "Мэдэгдэл"-ийг тус тус хүргүүлж, цайны газрын үйл ажиллагаа явуулах ААНБ-ын судалгааг авч ажиллалаа.					
	Хүнсний зах, худалдааны төвүүдэд хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, орчны эрүүл ахуйд хяналт шалгалтыг зохион байгуулна.	Хяналт шалгалт, тоогоор	2	-	70	Мэргэжлийн хяналтын хэлтэс
4.6-7	Хүрсэн түвшин, хэрэгжилт МХЕГ-ын даргын баталсан 01/04 дугаар удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 20 аж ахуйн нэгж, 64 иргэний хадгалж, худалдаалж буй ургамал, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаажилт, чанар, аюулгүй байдалд хяналт шалгалт хийж, нийт 54 зөрчил илрүүлэн 42 зөрчлийг газар дээр нь арилгуулж, зөрчил үйлдсэн 4 аж ахуйн нэгж, 10 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 7000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, худалдаалж буй жимс, хүнсний ногооноос 215 дээж авч МХЕГ-ын ХАБҮЛЛ-ийн шинжилгээнд хамруулахад холбогдох стандартын шаардлагыг хангаж байна. Хяналт шалгалт 85%-тай үргэлжилж байна.					

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН БАЯНГОЛ ДҮҮРЭГ						
5.1-1	Иргэдийн сайн дурын нэгдэл Хөршийн холбоодын үйл ажиллагааг эрчимжүүлж "Айл хүний амь нэг" аяныг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.	Шинээр байгуулагдах хөршийн холбоо, тоогоор	3	3,000,000 Дүүргийн төсөв	100	Цагдаагийн газар
	Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн хороодод 6 хөршийн хяналтын бүлэг байгуулагдаж Хөршийн хяналтын 30 бүлэг 180 гишүүнтэйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласаныг хороо хариуцсан хэсгийн байцаагч, цагдаа нараас мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан Хөршийн хяналтын бүлгүүдээс өөрийн оршин суудаг байр, гудамжны орчинд хорооноос зохион байгуулсан 57 удаагийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээнд эргүүлийн үүргийг гүйцэтгэн ажиллан хэсгийн байцаагч, цагдаа, олон нийтийн цагдаа, хороон Засаг дарга нарын хамт архидан согтуурч үр хүүхдээ хайхардаггүй, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байж болзошгүй, гэртээ архичид цуглуулан байнга архидан согтуурч орчин тойрныхоо амгалан тайван байдлыг алдуулдаг айлын талаар мэдээлэл, гэмт хэрэг зөрчлийн талаар 59 удаагийн дуудлага мэдээлэл цагдаагийн байгууллагад өгсөн. Хариуцсан байр, гудамжны оршин суугчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 1500 ширхэг санамж сэрэмжлүүлэг тарааж 450 иргэнд эд зүйлээ алдахаас урьдчилан сэргийлэх яриа хийж, шаардлага тавьж ажилласан байна. Иргэдийн сайн дурын нэгдэл хөршийн холбоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хөршийн холбоодын ахлагч нартай уулзах уулзалтыг зохион байгуулж хөршийн хяналтын бүлгийн ахлагч нарт бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, гишүүдийн тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулж буй хүрээндээ иргэд олон нийтэд хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагааг сурталчлах, ач холбогдлыг ойлгуулах талаар ажил зохион байгуулах, хэсгийн ахлагч, хороодын засаг даргын ажлын албатай хамтран ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч тус хэлтсээс бэлтгэн гаргасан "Та хөршийн холбоонд нэгдсэн үү" богино хэмжээний видео шторкыг хувиан өгч оршин суугч иргэдэд хүргүүлсэн.					
5.1-2	Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан хууль, эрх зүйн актуудыг олон нийтэд сурталчлах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт байрлах хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулж сэрэмжлүүлэг, нийтлэл, нэвтрүүлэг, богино хэмжээний видео /кино/ бэлтгэж, иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулна.	Шинээр бэлтгэх мэдээ, мэдээлэл, давтамжаар	4	3,000,000 Дүүргийн төсөв	100	Цагдаагийн газар
	Хүрсэн түвшин, хэрэгжилт Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газар, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хулгайлах, архидан согтуурах, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, залилан, хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус тус бэлтгэсэн 39 төрлийн нийтлэл, богино хэмжээний видео, анимешн, сэрэмжлүүлэг мэдээллийг хэлтсийн веб болон facebook хуудас болон 5 дугаар хороо нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх Акума төвийн LED дэлгэц, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх Өргөө кино театрын дэлгэцээр кино эхлэхээс өмнө тогтмол, 14 хорооны нутаг дэвсгэрт байрлах "Түмэн плаза" худалдааны төвийн дэлгэцүүдээр гаргах чиглэлээр албан бичиг хүргүүлэн нэвтрүүлж хамтран ажиллаж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлье, Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгжийн оролцоо чухал, "Нэг хором", "Нэг хормын уураа тэвчье", "Зөв тусгал" хөдөлгөөнд нэгдэцгээе зэрэг 13 видео шторкыг бэлтгэн, "Та сэргийлж чадна", "Хулгайгаас сэргийлье", "Дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлье", "Та өөрийгөө болон бусдыг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлээрэй" зэрэг Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газраас бэлтгэн гаргасан 105 төрлийн видео шторж, дээрх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж хүргэх зорилгоор Мэдээллийн булан, Зочны ярилцлага, Өглөө хөтөлбөр зэрэг хөтөлбөрүүдээр алба хаагчдыг оролцуулж 25 сурвалжлага, мэдээлэл өгч хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, UBS, Өлзий, SBN, Like HD телевизүүдээр болон бусад TV5, NTV, Монгол HD, ETV HD, TV25, C1, Eagle зэрэг телевизүүдээр 4 удаагийн давтамжтай нэвтрүүлж иргэд олон нийтэд хүргэхээс гадна дүүрэг, хэлтсийн цахим хуудас, хороод, алба хаагчдын фэйсбүүк хуудсаар санамж сэрэмжлүүлэг, зөвлөмж бүхий зурагт хуудас бүхий 245 мэдээллийг түгээж ажиллалаа.					

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж байгууллага иргэдийн оролцоог нэмэгдүүлж гэмт хэрэг зөрчил илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

5.1-3	Тамхины хяналтын тухай хууль болон Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тамхины тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, хяналт, шалгалт хийх арга хэмжээг зохион байгуулна	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт					
	Дүүргийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн А/129, 05 дугаар сарын 23-ны өдрийн А/294, 07 дугаар сарын 18-ны өдрийн А/407 дугаартай захирамжуудаар нийт 22 аж ахуйн нэгж, байгууллага, 12 иргэнд тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг олгосон байна. Тамхины зөвшөөрлийг олгосноор татварын дансанд 5,600,000 төгрөг, Тамгын газрын дансанд 68,000 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна. Цагдаагийн газар нь "Эмзэг цэг хяналт шалгалт" арга хэмжээг өдөр бүр тогтмол зохион байгуулж ажиллан өдрийн цагаар хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа нар, шөнийн цагаар 1 автомашинтай 2 алба хаагч 22:00 цагаас 06:00 цагийн хугацаанд хөдөлгөөнт байдлаар үүрэг гүйцэтгэн 7 төрлийн шалгалтыг тогтмол хэрэгжүүлэн ажилласан. Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 6 удаагийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 350 аж ахуйн нэгж байгууллага 312 иргэнийг шалган Зөрчлийн тухай хуулийн 6.3 /Тамхины хяналтын тухай хууль зөрчих/ дугаар зүйлийг зөрчсөн 147 иргэнийг 40,650,000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч, 70 хайрцаг тамхийг дүүргийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлж ажилласан. Мэргэжлийн хяналтын хэлтсээс дүүргийн нутаг дэвсгэрт байрлах тамхины худалдаа үйлчилгээ эрхлэх тамхины тусгай зөвшөөрөлтэй Номин тав трейд ХХК-ийн 5, Сонгино хангай ХХК-ийн 2, Наран супермаркет, 113 хүнсний дэлгүүр, 22 түргэн үйлчилгээний цэг, нийт худалдаа үйлчилгээний газар хамрагдсан. Шалгалтад хамрагдсан 113 дэлгүүр тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд түргэн үйлчилгээний цэгүүдэд зөвшөөрөлгүй тамхи худалдаж байгаа зөрчил арилахгүй байна. Худалдаа үйлчилгээний газруудад хийсэн хяналт шалгалтын явцад зохих зөвшөөрөлгүй цэгт утаат тамхи худалдан борлуулсан, утаат тамхийг ширхэглэн худалдсан нь "Тамхины хяналтын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.8 дахь заалт зөрчсөн нийтлэг зөрчил илрүүлж, хуулийн дагуу 1 аж ахуйн нэгж, байгууллагад 1,000,000 төгрөг, 10 иргэнд 500,000 төгрөг, нийт 1,500,000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авлаа. Шалгалтад хамрагдсан газруудад аж ахуйн нэгжийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангах, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, хадгалалт, борлуулалтын эрүүл ахуйн шаардлага, худалдаа, үйлчилгээний газрын эрүүл ахуйн нөхцөл, стандартын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.					
5.1-4	Дүүргийн хэмжээнд саун массаж зочид буудлуудад хяналт шалгалтыг зохион байгуулж хуулийн хэрэгжилтийг тогтмол хангуулж холбогдох арга хэмжээг авч ажиллана.	Хяналт шалгалт, тоогоор	4	2,000,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт					
	Нийслэлийн Аялал жуулчлалын газартай хамтран 2019 оны байдлаар 63 зочид буудал, 46 дэн буудалд хяналт шалгалт хийж стандартын /камер/ шаардлага хангуулж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын буудлын тусгай зөвшөөрлийг олгуулсан байна. Сауны стандартын ерөнхий шаардлагын 9.3-д заасны дагуу 7 сауны газар Эрүүгийн цагдаагийн газраас цагдаагийн тодорхойлолт авч, Баянгол дүүргийн Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл гэрээ байгуулж, гэрчилгээ олгосон байна. 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран "Бэлгийн замаар дамжих халдварыг бууруулахад иргэн, аж ахуйн нэгжүүдийн оролцоо" сэдэвт сургалтыг зохион байгуулж, зочид буудал, саун массажны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 20 гаруй газрын төлөөлөл хамрагдлаа. Мөн 2019 оны 11 дүтгээр сарын 07-ны өдөр Нийгмийн сайн сайхны төлөө Гал голомт үндэсний хөдөлгөөн ТББ –тай хамтран "ХДХВ-ийн халдвараас сэргийлэх ажлын байрны бодлого хөтөлбөр" сэдэвт сургалтанд дүүргийн зочид буудал, саун эрхлэдэг 15 аж ахуйн төлөөлөл оролцлоо. Дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн төв, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс хамтран 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны хооронд "Хайртай хүмүүсээ хамтдаа хамгаалцгаая" аяны хүрээнд хяналт шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтаар 17 саун, массажны газрын 42 хүнээс ДОХ, тэмбүүгийн шинжилгээг авахад тэмбүүгийн хуучин халдвартай 5, шинээр 2 тэмбүүгийн халдварыг илрүүлэн хяналтад авч эмчилгээнд хамруулаад байна. Шалгалтаар дүүргийн 4, 6 дугаар хороонд байрлах "Гранд", "Гоо даль" оноосон нэртэй сауны газар нь стандарт шаардлага хангаагүй тул үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоогоод байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монголын зочид буудлуудын холбоотой хамтран Өрөөний үйлчлэгч, Гэрийн үйлчлэгч, Бариста, Зөөгч, Бартендер, Тогооч, Зочин утгагч, Ачаа зөөгч, Хаалгач гэсэн нийт 9 мэргэжлээр үнэ төлбөргүй 5 өдөр, 40 цагийн сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны хооронд зохион байгуулж байна. Сургалтад дүүргийн 25 буудлын 225 ажилтан одоогоор хамрагдаад байна. Цагдаагийн газар нь Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа саун массажны газруудыг шалгах чиглэлээр нийт давхардсан тоогоор 51 саун массажны газрыг шалган зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан 5 дугаар хороо Массаж центр массажны газар, Шим саун массажны газрын зөрчлийг илрүүлэн шалган Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 100,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ, Монгол Улсын "Садар самуун явдалтай тэмцэх тухай" хуулийг зөрчиж үйл ажиллагаа явуулсан 4 дүгээр хороо Лотус массажны газар, Гранд массаж 2 массажны газар, 5 дугаар хороо Массаж центр массажны газар, 10 СПА массажны газар, Шим саун массажны газар, 6 дугаар хороо ВЛВ массажны газар, 8 дугаар хороо Нобел СПА массажны газруудын зөрчлийг илрүүлэн шалгаж Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу 800,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ, тус хуулийн 6.18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон зөрчил гаргасан 47 хувийг 7 760 000 төгрөгөөр нийт торгуулийн арга хэмжээг заасны					
	Авто засвар, үйлчилгээ, угаалгын газруудад хяналт шалгалтыг зохион байгуулж, хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын зөвлөх үйлчилгээ, сургалт зохион байгуулна	Сургалт, тоогоор	2	1,800,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт					

5.1-5	Дүүргийн нутаг дэвсгэрт авто угаалга, кузов засварын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад Монгол улсын "Авто тээврийн тухай" хууль, Зам тээврийн сайдын 2016 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засвар хийх журам" болон бусад хууль, тогтоомжийг мөрдүүлэх зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/146 дугаартай захирамжаар хяналт, шалгалтыг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны хооронд зохион байгуулж, 20 аж ахуйн нэгж хамрагдлаа. Мөн тус захирамжаар авто үйлчилгээний байгууллагуудад холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр зохион байгууллаа. Тус сургалтанд авто угаалга, кузов засвар, дугуй засвар, болон авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 48 иргэн аж ахуйн нэгж байгууллага хамрагдлаа. Энэхүү сургалтаар "Авто тээврийн тухай" хуулийн 192 .1.1-д 192 , 3.6-д заасны дагуу "Тухайн үйлчилгээний ангилал, стандартад тавигдах шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах, хөдөлмөр аюулгүй байдлын талаархи сургалтыг амжилттай зохион байгууллаа. Иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу нийт 9 иргэн, 16 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж 1 авто засварын газарт 3,000,000 төгрөгний торгууль ногдуулан, зөрчил арилгах мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч ажиллалаа. Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн "Автомашинны засвар, үйлчилгээний газруудад үзлэг шалгалт зохион байгуулах тухай" А/175 дугаар тушаалын дагуу дүүргийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/385 дугаар захирамж гарган ажлын хэсэг байгуулан хяналт шалгалт зохион байгуулж ажиллалаа. Зөрчилтэй 27 авто засвар үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, стандартад нийцүүлж ажиллах тухай мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 5 газрыг нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлүүлж ажиллалаа. Цагдаагийн газар нь хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг авто засвар үйлчилгээ эрхэлдэг 28, угаалгын газар 12 нийт 40 аж ахуйн нэгж байгууллага, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гадаадын иргэн, харъяалалгүй хүмүүсийн визний хугацаа хэтэрсэн эсэх, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй эсэхийг шалгасан. Төв зам дагуу байрлалтай оочер дараалал үүсгэн замын хөдөлгөөнд зохомол түгжрэл үүсгэж болзошгүй 4 авто угаалгын эзэд зөвлөмж хүргүүлж биелэлт үр дүнг тооцсон. Авто засвар үйлчилгээ, угаалгын газрын захирал, ажилчдад Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нэг хором аяны хүрээнд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Зөв тусгал хөдөлгөөний хүрээнд "Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үлгэр дууриал үзүүлэх" сэдвүүдээр 4 удаагийн сургалт зохион байгуулж, 120 иргэнийг хамруулсан.					
	Их дээд сургуулиуд дээр "Оюутан цагдаа" бүлгэмүүдийг байгуулж, сургуулийн орчинд хяналт тавьж ажиллах чиглэлээр сургалт зохион байгуулна	Их дээд сургуулийн хамрагдалт, хувиар	100%	1,500,000 Дүүргийн төсөв	100	Цагдаагийн газар Нийгмийн хөгжлийн хэлтэс
5.1-6	Хүрсэн түвшин, хэрэгжилт Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 11, 14 дүгээр хороонд байрлах Монголын Үндэсний их сургуулийн "Оюутан цагдаа" бүлгэмтэй хамтран их дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад Оюутан цагдаа бүлгэмийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулж их дээд сургууль 8, коллеж 2 нийт 10 сургууль, ерөнхий боловсролын 4 сургуульд сургалт зохион байгуулж сургалтын менежерүүдтэй хамтран "Оюутан цагдаа бүлгэм" байгуулах талаар санал солилцон хамтран ажиллаж "Барилгын политехник коллеж"-ийн 20 оюутныг 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 24-ний өдрүүдэд Оюутан цагдаагийн үүрэг гүйцэтгүүлж, арга хэмжээний хүрээнд Оюутан цагдаа нараас ирүүлсэн гэмт, хэрэг зөрчлийн шинжтэй 50 мэдээ, мэдээллийг хуулийн дагуу шалгаж шийдвэрлэн, идэвхи, санаачлагатай оролцсон оюутан Б.Барсбаатар, Д.Бат-Орших нарыг Цагдаагийн газрын талархал, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургууль, Энх-Орчлон дээд сургууль, Анагаахын үндэсний шинжлэх ухааны их сургуулийн Сувилхуйн сургууль, Техник технологийн дээд сургуулиудтай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн хүрээнд сургууль тус бүрд "Оюутан цагдаа" бүлгэм байгуулсан. "Хуулиа мөрдө" арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн шинжлэх ухааны салбар, Сувилахуйн ухааны сургууль, эм зүйн салбар сургууль дээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи тамхины хор хөнөөл болон Эх оронч үзлийг төлөвшүүлэх чиглэлээр Монгол улсын шилдэг лектор Ж.Цогтсүгарыг урьж хамтран 250 оюутанд сургалт хийсэн. Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төвтэй хамтран "Архи, тамхины хор уршиг", Зөрчлийн тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийсэн. Сургалтад Монголын үндэсний их сургууль болон Олон улсын бизнес эдийн засгийн дээд сургуулийн 500 оюутан хамрагдсан.					
	Цахим тоглоомын газруудын судалгааг гарган хяналт, шалгалт зохион байгуулж, журмын хэрэгжилтэнд хяналт тавих ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	1,000,000 Дүүргийн төсөв	100	Цагдаагийн газар Нийгмийн хөгжлийн хэлтэс
5.1-7	Хүрсэн түвшин, хэрэгжилт Засгийн газрын 410 дугаар тогтоолоор батлагдсан Цахим тоглоомын үйл ажиллагаа явуулах журмын хэрэгжилтийг хангах зорилгоор "Цахим тоглоом" арга хэмжээг Хариуцсан 13 хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Интернэт, цахим тоглоомын үйл ажиллагаа явуулдаг газруудын судалгааг шинэчлэн гаргаж, судалгаанд авагдсан 48 цахим тоглоомын газрын захирлуудтай уулзалт зөвлөгөөнийг 02 сарын 22-ны өдөр зохион явуулсан. Цагдаагийн газраас бүртгэлийн гэрчилгээгүй үйл ажиллагаа явуулж буй цахим тоглоомын газрын үйл ажиллагааг нэн даруй зогсоох, цагийн хуваарийг баримталж ажиллах, 0-10 насны хүүхдэд үйлчлэхгүй байх талаар албан шаардлагыг хүргүүлж ажилласан бөгөөд үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг биеллэн шалгаж ажилласан ба 48 цахим тоглоомын газар шаардлагын хариут бичгээр ирүүлээд байна. Хяналт шалгалтын явцад нийт 48 цахим тоглоомын газар шалгаж зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 6 газар, цаг хэтрүүлэн ажиллаж зөрчил гаргасан 134 газрыг илрүүлэн үйл ажиллагааг нь таслан зогсоож, холбогдох хуулийн дагуу 134 иргэнийг 16,000,000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авсан.					
5.1-8	Насанд хүрээгүй хүн холбогдож, хохирч байгаа гэмт хэргийг бууруулах чиглэлээр ерөнхий боловсролын сургууль бүр дээр "Эцэг эхийн зөвлөл", төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	5,000,000 Дүүргийн төсөв	100	Цагдаагийн газар
	Хүрсэн түвшин, хэрэгжилт					

			Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 18 ерөнхий боловсролын сургуульд бүр дээр насанд хүрээгүй хүн холбогдож хохирч байгаа гэмт хэргийг бууруулах чиглэлээр "Эцэг эхийн зөвлөл" байгуулан, гурвалсан гэрээ байгуулан 2019-2020 оны хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбоотойгоор гэрээг сунган ажиллаж байна. Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран "Нэг хором", "Зөв тусгал" аяны хүрээнд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагчдын дунд зөвлөгөөн зохион байгуулан хариуцсан нутаг дэвсгэрийн 15 ерөнхий боловсролын сургуулийн 900 хүүхдийг хамруулсан.				
		Их дээд болон ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран ажиллах гэрээг гурвалсан байдлаар байгуулж, нэг жилийн хугацаанд гэмт хэрэг, зөрчил гаргаагүй, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхитэй өрнүүлсэн сургуулийг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	10,000,000 Дүүргийн төсөв	100	Цагдаагийн газар
		Хүрсэн түвшин, хэрэгжилт					
		Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 9 дээд сургууль, 18 ерөнхий боловсролын сургуультай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулсан. 2019 оны хичээлийн жилд гэмт хэрэг, зөрчил гаргаагүй урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхитэй өрнүүлсэн сургуулийг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулан Барилгын политехникийн коллежийн "Оюутан цагдаа" бүлгэм сургуулийн орчинд болон хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаж үр дүнг тооцон идэвхи, санаачлага оролцсон 3 оюутанг хэлтсийн даргын баярын бичиг, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. 2019-2020 оны хичээлийн жилд мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон гэрээний хүрээнд хамтран ажиллаж шагнаж урамшуулах талаар гэрээнд тусгуулан ажиллаж байна. "Хуулиа мөрдье" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Архидан согуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчилсан зурагт хуудсыг хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, худалдаа үйлчилгээний төвүүд, баар, караоке, нийтийн хоол, зоогийн газар, хүнсний дэлгүүр зэрэг 256 газарт 400 ширхэгийг байршуулан иргэд олон нийтэд хүргэсэн.					
		Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн дунд болзолт уралдаан зарлан камержуулах аяныг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	5,000,000 Дүүргийн төсөв	100	Тохиромжтой, нийтийн аж ахуйн хэлтэс, Цагдаагийн газар
		Хүрсэн түвшин, хэрэгжилт					
		Гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэлтийг нэмэгдүүлэхээр нийтийн эзэмшлийн гудамж зам талбай руу чиглэсэн камержуулалтыг аж ахуйн нэгж байгууллагын дунд Улаанбаатар хотын ерөнхий менежер 2019 оны А/132 дугаар тушаалаар, иргэд оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээр Сууц өмчлөгчдийн холбоодын дунд дүүргийн Засаг даргын 2019 оны А/380 дугаар захирамжаар тус тус болзолт уралдаан зарлаж, аж ахуйн нэгж байгууллагууд 50 сая төгрөгийн 416 камер, Сууц өмчлөгчдийн холбоод 37.2 сая төгрөгийн 174 камер тус тус суурилуулж, гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглагдах нийт 87.2 сая төгрөгийн 590 камер болзолт уралдааны хүрээнд шийдвэрлэж ажилласан.					
		Камерын нэгдсэн судалгааг гаргаж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засаж, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Тохиромжтой, нийтийн аж ахуйн хэлтэс
		Хүрсэн түвшин, хэрэгжилт					
		Дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэг гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх ажилд ашиглагдаж буй 415 камерын эвдрэл гэмтлийг түргэн шуурхай засварлах, тогтвортой найдвартай ажиллагааг хангах, тоног төхөөрөмж, өмчийн ашиглалтыг сайжруулах зорилгоор дүүргийн төсөвт 200 сая төгрөг батлуулж, "Юу Эм Си Эс" ХХК-тай гэрээ байгуулан 2011 оны 240 камерыг 90%, 2013 оны 175 камерыг 100%-ийн буюу 95%-ийн тогтвортой ажиллагааг хангаж, гэмт хэргийн зөрчлийн илрүүлэлт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжжээ ажилласан.					
		Цагдаагийн газар нь хариуцсан нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа хяналтын камеруудыг хороодоор нь авч үзвэл 4 дүгээр хороонд 16, 5 дугаар хороонд 6, 6 дугаар хороонд 8, 8 дугаар хороонд 10, 13 дугаар хороонд 18, 7 дугаар хороонд 34 нийт 117 хяналтын камер хэвийн ажиллагаатай байна, эвдрэл, гэмтэлтэй байгаа 40 ширхэг хяналтын камерыг "Юу Эм Си Эс ХХК" хариуцан засвар үйлчилгээг хийлгэн ажиллалаа.					
		Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн тусгай зөвшөөрөл, авах, сунгуулах тухай хүсэлтийн хүрээнд нийт 19 байгууллага, аж ахуй нэгжид эрсдэлд өртөх, аюулгүй байдлаа хангасан, орчны болон дотор хяналтын камерын үйл ажиллагаатай танилцсан хэсгийн байцаагч, холбооны инженер нарын дүгнэлт, Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас зөрчилтэй эсэх лавлагаа зэрэгт тулгуурлан тодорхойлолт олгосон. Аж ахуйн нэгжүүдийн дунд Камержуулалт болзолт уралдааныг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс зохион байгуулахаар төлөвлөж байгаа ба гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгддэг гудамж талбай, нийтийн эзэмшлийн зам талбайг аж ахуйн нэгжүүдээр камержуулах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагууд үйлдвэр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл шинээр авах, сунгах тохиолдолд нь цагдаагийн байгууллагаас санал өгөхдөө стандарт шаардлага хангасан камер, гэрэлтүүлгийг гадна орчны 50-100 метр талбайд байрлуулсан тохиолдолд зөвшөөрсөн санал олгох ажлыг эхлүүлж тайлангийн хугацаанд санал авахаар ирүүлсэн 83 материалыг газар дээр нь очиж шалган 28 иргэнд зөвшөөрөл олгуулахаар санал гаргаж, 55 материалыг камер гэрэлтүүлэг тавиулахаар буцаасан нь үр дүнгээс өгч аж ахуйн нэгжүүдийн гадна болон дотор талд 220 камер шинээр тавигдсан байна.					
		Гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй эмзэг цэгийн судалгааг гарган, камержуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, Улс, Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан хяналтын камерыг үе шатаар шинэчлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	500,000 Дүүргийн төсөв	100	Тохиромжтой, нийтийн аж ахуйн хэлтэс, Цагдаагийн газар
		Хүрсэн түвшин, хэрэгжилт					

5.2

Дүүргийн хэмжээнд камерын нэгдсэн хяналтын систем бий болгох "Баянгол-камержуулалт II" төслийг хэрэгжүүлнэ.

		Баянгол дүүргийн Цагдаагийн газартай хамтарч гэмт хэрэг гарч болзошгүй 460 эмзэг цэгт 1250 камер суурилуулах тандалт судалгааны ажил зохион байгуулж, Улс, нийслэл, дүүргийн төсөвт 809 сая төгрөг батлуулан эмзэг 90 цэгт 236 камер суурилуулах ажлыг зохион байгуулсан. Мөн 2020 онд камержуулалт төсөл арга хэмжээг үргэлжүүлэн зохион байгуулахаар хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлыг хангаж, 320 цэгийн 1020 камерын зураг төслийг "Нарлаг хөхий" ХХК гүйцэтгүүлж ажиллаж байна.					
	5.3-1	Иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль, тогтоомжуудыг сурталчлах ажлыг зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах төрийн болон төрийн бус байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, их дээд сургуулиудын оюутан сурагчдыг зам тээврийн гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцуулах, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор дүүргийн боловсролын хэлтэс болон үйл ажиллагаа явуулдаг томоохон аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах "САНАМЖ БИЧИГ" үйлдэн гэрээ байгуулж, гэрээнд заагдсан ажил арга хэмжээнүүдийг тухай бүр зохион байгуулан ажилласан. "Зөрчлийн тухай хууль", "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль", "Замын хөдөлгөөний /шинэчилсэн/ дүрэм", "Оноо тооцох журам", "Тээврийн хэрэгсэл ачиж зөөвөрлөх, түр саатуулах журам" сэдвээр Хилийн цэргийн цэргийн 0164-р анги, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Тэнүүн огоо ХХК, Эрдэм транс ХХК-ийн нийт 126 ажилтан албан хаагч нарт нийт 16 цагийн сургалт зохион байгуулан ажилласан. Сүхбаатарын талбай дээр 2019 оны 05 дугаар сарын 22-ний өдөр Тээврийн цагдаагийн албаны нээлттэй хаалганы өдөрлөгийг Хууль зүй дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын "Бүртгэл хяналтын төв", Авто тээврийн үндэсний төв, Албан журмын даатгагчдын холбоо, нартай хамтран зохион байгуулан иргэдэд хууль зэрх зүй болон албаны үйл ажиллагааг сурталчилан ажилласан. Мөн 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдөр тус дүүргийн 6 хороо Улаанбаатар паласын урд талбайд Цагдаагийн ерөнхий газрын нээлттэй хаалганы өдөрлөгт Замын цагдаагийн газрын үйл ажиллагааг сурталчилан ажилласан. Дүүргийн 23 хороодын засаг дарга нартай хамтран бяцхан зорчигч арга хэмжээний хүрээнд хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг хороодын ард иргэдэд зохион байгуулан ажиллаж байна. Урин дулааны улирал эхэлсэнтэй холбоотой хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Бяцхан зорчигч арга хэмжээг тус дүүргийн 23 хороодын засаг дарганаартай хамтран иргэдийн хурал дээр сургалтыг зохион байгуулан бага насны хүүхдийг аюулгүй байдлыг хангасан газар тогтуулах, тээврийн хэрэгсэлдээ авч явахдаа аюулгүй тээвэрлэх, зэрэг зөвлөмжийг өгч сэрэмжлүүлэг өгөн ажиллаж байна. Хичээлийн шинэ жил "Улсын дугаар" нэгдсэн "Явган зорчигч ба гарц" хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн хүрээнд хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр МҮОНТ, UBS, SBN, VTV, MNC, TB5, TB8, TB9, OTV, Өлзий, MASS, нийт 11-н төлөөлөгчид хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг 14 удаа зочны цагаар 4 удаа тус тус оролцон мэдээ мэдээлэл хүргэн ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах төрийн өмчийн ерөнхий боловсролын 19-н сургууль, хувийн хэвшлийн 24-н сургуулиудын хичээл тарах буюу орох үед сургууль орчимд хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүсийн 4 зохицуулагч, албаны 4-н автомашины чанга яригчаар ухуулга сурталчилгааг 32 удаа сургууль орчимд хийлгэн эцэг эхийн эргүүл буюу 76-н "school police" ажиллаж байгааг шалган зааварчилгаа өгч ажилласан. Мөн хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Zindaa.mn, Шуурхай.мн Түмэн.мн, Үнэн.мн, Жиргээ.мн, Шууд.мн, 24цаг.мн, Арслан.мн, 8 сайтад мэдээ мэдээлэл хүргэж 4 удаа шууд live хийж мэдээ мэдээлэл хүргэсэн ажилласан. Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон замын хөдөлгөөний нөхцөл байдлын талаар Монголын үндэсний олон нийтийн радио 106.4, Гийнгоо 100.5, Бизнес радио 98.9-р тус тус 8 удаа мэдээлэл хүргэн ажиллалаа.	Сургалт сурталчилгаа, тоогоор	2	1,500,000 Дүүргийн төсөв	100	Замын цагдаагийн хэлтэс
	5.3-2	Замын хөдөлгөөний түгжрэл, саатлын шалтгаан нөхцлийг судалж, түүнийг арилгахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт 2019 онд нийт 500 тэмдэг шинээр болон нөхөн байрлуулах санал Нийслэлийн Авто замын хөгжлийн газар хүргүүлж нийт 112ш тэмдэг байрлуулснаас шинээр 36ш тэмдэг, нөхөн 56ш тэмдгийг 61 цэгт байрлуулсан. Мөн тайлангийн хугацаанд тэмдгийн үзлэг шалгалтыг төхник, замын хяналт хариуцсан зохицуулагч, бүс хариуцсан зохицуулагч нараар тогтмол хяналт тавиулж хандалт өөрчлөгдсөн, хазайж мурийсан 38 зөрчлийг илрүүлж газар дээр засварлах боломжтой 25 ш тэмдгийг зохицуулагч, цагдаа зохицуулагч нар засварлаж боломжгүй 13 тэмдгийг засварлуулах саналыг фото зургаар баримтжуулан Нийслэлийн авто замын хөгжлийн газарт хүргүүлсэн 2019 оны 8 дугаар сард зорчих хэсгийн 1-р эгнээг хэвийн байдалд оруулсан. Баянгол дүүргийн 6-р хороо Энхтайваны өргөн чөлөө 10-р хорооллын уулзварын гэрэл дохио, Баянгол дүүргийн 8-р хороо Чингүнжавын гудамж, Чингүнжавын уулзварын гэрэл дохионы тактыг өөрчлөх талаар судалгааг хийж ажилласан. Тайлангийн хугацаанд 2 байршилд 212 м хайс шинээр байрлуулсан. Үүнд: Баянгол дүүргийн нутаг 3, 4 дүгээр хорооллын эцсээс дээш Хасбаатарын гудамж өгсөх замд 75 м усан хаалт, 25 дугаар эмийн сангаас хойш Чингүнжавын гудамж өгсөх замд 135м хуучин төмөр хайс шинээр байрлуулж хөдөлгөөн зохион байгуулалт хийсэн. Сар шинийн баяртай холбогдуулж дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 5 цэгийн 812м хайсыг Хот тохиожилтын газар, Улаанбаатар зам засвар арчлалтын газар, "Баянгол шинэ өргөө" ОНӨААТҮГ-аар тус тус арчиж цэвэрлүүлсэн. Энэбишийн өргөн чөлөөний замын голын тусгаарлах зурвас дээр 12 метр хайс, Чингүнжавын гудамжинд 25 метр хайсыг Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ, Нарны гүүрэн дээр 12 метр хайс, нарны зам барс худалдааны төвийн арын замд 6 метр хайсыг Улаанбаатар зам засвар арчлалтын газраар нийт 55 метр хайс засварлуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт 2019 онд нийт 500 ширхэг тэмдэг шинээр болон нөхөн байрлуулах санал Нийслэлийн авто замын хөгжлийн газарт хүргүүлж нийт 112ш тэмдэг байрлуулснаас шинээр 36ш тэмдэг, нөхөн 56ш тэмдгийг 61 цэгт байрлуулсан. Мөн тайлангийн хугацаанд тэмдгийн үзлэг шалгалтыг төхник, замын хяналт хариуцсан зохицуулагч, бүс хариуцсан зохицуулагч нараар тогтмол хяналт тавиулж хандалт өөрчлөгдсөн, хазайж мурийсан 38 зөрчлийг илрүүлж газар дээр засварлах боломжтой 25ш тэмдгийг зохицуулагч, цагдаа зохицуулагч нар засварлаж боломжгүй 13 тэмдгийг засварлуулах саналыг фото зургаар баримтжуулан Нийслэлийн авто замын хөгжлийн газарт хүргүүлсэн 2019 оны 8 дугаар сард зорчих хэсгийн 1 дүгээр эгнээг хэвийн байдалд оруулсан. Баянгол дүүргийн 6 дугаар хороо Энхтайваны өргөн чөлөө 10 дугаар хорооллын уулзварын гэрэл дохио, Баянгол дүүргийн 8 дугаар хороо Чингүнжавын гудамж, Чингүнжавын уулзварын гэрэл дохионы тактыг өөрчилж хөдөлгөөний ачааллыг 30-40 хувиар бууруулж ажиллалаа. Цаашид Хасбаатарын гудамж эх нялхасын баруун уулзвар, Ард Аюушийн гудамж 4 дүгээр хорооллын эцсийн уулзваруудад гэрлэн дохионы тактыг өөрчлөх талаар судалгааг хийж ажиллаж байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Замын цагдаагийн хэлтэс

Дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

5.3-3	Дүүргийн нутаг дэвсгэрийн зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний зохион байгуулалтын аюулгүй байдлыг хангах болон холбогдох хууль, журамд нийцэж байгаад хяналт тавьж ажиллана. Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Замын цагдаагийн хэлтэс
Хүрсэн түвшин, хэрэгжилт Замын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр байнга баруун гар тийш эргэдэг уулзвар шинээр байгуулах боломжтой 4 уулзварын танилцуулга гаргаж Тээврийн цагдаагийн албанд хүргүүлсэн. Үүнд: Ард Аюушийн өргөн чөлөө 3, 4-р хорооллын эцсийн уулзвар, Ард Аюушийн өргөн чөлөө "Өргөө" уулзвар, Чингүнжавын гудамж Улаанбаатар паласын хойд уулзвар, Гурвалжингийн гүүрний урд уулзвар санал хүргүүлсэн. Үндсэн хуулийн гудамжинд замын хөдөлгөөний ачааллын талаар дараах судалгааг хийлээ. Баянгол дүүргийн 1-р хороо Нарны гүүрний урд уулзвар хойшоо Өгөөжийн уулзаараас ертөнцийн зүгээр баруун тийш Гранд плаза дэлгүүрийн зүүн урд байх тойроогоос хойшоо Гранд плаза дэлгүүрийн зүүн хойд талын уулзвар хүртэл хөдөлгөөний ачаалал ажлын болон амралтын өдрүүдэд маш ихтэй байдаг. "Мөнх хүнхэр-Уул" ХХК-н Энэбишийн өргөн чөлөө, Амарсанаагийн гудамж, Чингүнжавын гудамж, Хасбаатарын гудамж, Ард-Аюушийн өргөн чөлөө, Дилав хутагт Дамдинбазарын гудамж, Жалханз хутагт Жасмыржавын гудамж, Хувьсгалчдын гудамж, Хатанбаатар Магсаржавын гудамж, Хонхны гудамж, Амарсанаагийн гудамж замуудад нийт 13000 м2 тэмдэглэл хийгээд байна. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах тээврийн хэрэгслийн болон явган зорчигчийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохионуудыг бүрэн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллалаа. Хяналт шалгалтын хүрээнд 25-р эмийн сангийн уулзвар /пост-340/ 2 ширхэг явганы Я-2 гэрлэн дохио, Өгөөжийн уулзвар /пост-302/ 2 ширхэг тээврийн хэрэгслийг зохицуулах Т.2-Д3 гэрлэн дохионууд эвдрэлтэй байсныг холбогдох байгууллагад мэдэгдэж хэвийн хэмжээнд ажиллагаанд оруулсан. "Төгс гэрэлтүүлэг" ХХК-наас Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Гурвалжингийн гүүрний урд зорчих хэсгийн 2 талаар байх гэрэлтүүлэгийн шонгуудад үзлэг шалгалт хийж асахгүй байсан 3 шонг засаж, гэрлийг хэвийн хэмжээнд асдаг болгосон.					
5.3-4	Орон сууцны хороолол, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, замын тэмдэг, тэмдэглэл, хайс хашлага, хурд сааруулагч, самбар байршуулах ажлыг зохион байгуулна. Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	500,000 Дүүргийн төсөв	100	Тохиромжтой, нийтийн аж ахуйн хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс
Хүрсэн түвшин, хэрэгжилт Замын цагдаагийн хэлтэстэй хамтарч орон сууцны хороолол, сургууль, цэцэрлэг орчим гудамж зам талбайд 1600м тусгаарлах хайс, 11 уулзварт торон тэмдэглэл, 18 байршилд хурд сааруулагч, 23 гудамжинд 31000м урт тэмдэглэгээ, 322 байршилд шинэ тэмдэг, 188 байршлын тэмдэг сэргээх, сургууль цэцэрлэг орчмын 9 байршилд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах судалгаа гаргаж, Нийслэлийн авто замын хөгжлийн газарт уламжлан 23 гудамжны 31000м урт тэмдэглэгээ, 5 байршилд хурд сааруулагч, 3 уулзварт торон тэмдэглэл, 65 байршлын тэмдэг сэргээх зэрэг ажилд нийт 416 сая төгрөг шийдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.					
5.3-5	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалтыг баримтлан дүүргийн Засаг даргын "Зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	10,000,000 Дүүргийн төсөв	100	Замын цагдаагийн хэлтэс
Хүрсэн түвшин, хэрэгжилт Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгах, иргэдэд хор уршгийг таниулах, олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх, оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор "Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл-2019" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтэс, Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтэс, Төв аймгийн замын цагдаагийн тасаг, хамтарч Улаанбаатар хотоос Өвөрхангай аймгийн чиглэлийн 61 км-т Төв аймгийн Баянчандмань сумын нутаг дэвсгэр баруун аймгуудыг чиглэсэн төв замд хөдөлгөөнд оролцогчдоод ухуулга, нөлөөллийн самбарыг жолооч таниулахаас гадна орон нутгийн замд хурдаа хасан яаралгүй хөдөлгөөнд оролцохыг уриалан "Яараад яахав дээ" хэмээн бичсэн тараах материал нийт-326 ширхэг тараан өгч автомашины наалт стикер ухуулга 258 ширхэгийг автомашинд байрлуулж үнэртүүлэгч, ундаа зэргийг жолооч нарт өгч ажилласан. Мөн "Дураараа биш дүрмээрээ" аяны хүрээнд хүүхдийг зам тээврийн хэрэг осол хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран дүүргийн ерөнхий боловсролын төрийн өмчийн 17 сургуулиудын 12 дугаар ангийн 3524 сурагч нарын дунд "Сурагчийн аюулгүй байдал 2019" хэлэлцүүлэг, "Жолооч та бид дэвжээ 2019" тэмцээнийг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар паласын их танхимд амжилттай зохион байгуулсан. Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох дадал хэвшлийг багаас зөв суулгах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг сайжруулах зорилгоор Засаг даргын А/563 дугаар захирамж гаргуулан ерөнхий боловсролын төрийн болон төрийн бус 22-н сургуулийн 242 бага ангийн сурагчдын дунд "Ногоон гэрэл цагаан шугам-2019" тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Хэлтсийн байр хуучирч муудсантай холбогдуулан шинээр хэлтсийн байр бариулах зорилгоор удаа дараа Засгийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Нийслэл, дүүрэгт хүсэлт гаргасны дагуу 2019 оны нийслэлийн төсөвт байр барихад шаардлагатай 1.3 тэрбум төгрөгийн 700 сая төгрөгийг суулгаж, барилга угсралтын тендерт "Хөх хайрхан трейд" ХХК шалгарч 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс барилгын ажил эхлээд 95 хувьтай яаж байна. Хэлтсийн байр болон байнгын постын мэдээллийн самбарт замын хөдөлгөөнд оролцогчдоод хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шинээр гарсан хууль, дүрэм, журам эрх зүйн мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, холбогдох хууль, дүрмийг 7 хоног бүр шинэчлэн байршуулан хэвшээд байна. Дүүргийн засаг даргын 2018 оны А/117 захирамжийн биелэлт ханган дүүргийн нутаг дэвсгэрт утаа ихтэй хөдөлгөөнд оролцсон 33 тээврийн хэрэгслийн бичиг баримтыг жураан авч зөрчлийг арилгуулахаар Баянгол техник оношилгооны төвд шилжүүлэн ажиллалаа.					

		5.3-6	Дүүргийн замын цагдаагийн байр барих болон шаардлагатай техник, тусгай хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт 2019 оны улсын төсөвт Замын цагдаагийн хэлтсийн барилгын ажилд 1,135.3 сая төгрөг батлагдсан. Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1-4/6359 дугаар тушаалаар Баянгол дүүргийн Засаг даргад худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн. 2019 оны 03 дугаар сарын 13-нд замын цагдаагийн хэлтсийн барилгын ажлын төндөр зарлагдан гүйцэтгэгчээр "Хөх хайрхан трейд" ХХК шалгарж, 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр барилгын ажил гүйцэтгэх №БГД-ХААА/УТ-19-01 дугаар гэрээ байгуулан, барилгын каргаз болон дүүргэлт хийгдэж, барилга угсралтын ажил 80%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Замын цагдаагийн хэлтэс
		5.4-1	Архины хэт хамааралтай иргэдийг бүртгэж, албадан эмчилгээнд хамруулах, нийгэмшүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн нутаг дэвсгэрт оршин суух хаягтай архинд донтох өвчтэй болон архины хэт хамааралд орсон иргэдийг бүртгэх архины албадан болон сайн дурын эмчилгээнд хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж Наркологиын төвд 35 иргэн сайн дурын эмчилгээнд хамруулж, удаа дараа архидан согтуурч орчиндоо түшүүр төрүүлдэг 100 иргэнийг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр Төв аймгийн Баян сумын нутаг дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх төвд хүлээлгэн өгч албадан эмчилгээнд хамруулсан. Эмчилгээнд явж ирсэн болон хоногт эрүүлжүүлэх саатуулах байранд эрүүлжүүлэгдсэн 350 иргэнд сургалт зохион байгуулж ажиллалаа. Мөн "Тэнэмэл" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан архины хэт хамааралтай 88 хүнийг бүртгэл судалгаанд хамруулж, эмчийн үзлэгт оруулан, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээнд хамруулсан. Архины албадан эмчилгээнд 111 иргэнийг, сайн дурын эмчилгээнд 323 иргэнийг тус тус хамрууллаа.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	1,200,000 Дүүргийн төсөв	100	Цагдаагийн газар
		5.4-2	Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх "Гэртээ харих зам" хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. Хүрсэн түвшин, хэрэгжилт Цагдаагийн газраас гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх, болзошгүй гэмт хэрэг зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Тэнэмэл" арга хэмжээг 2019 оны 2 дугаар сард зохион байгуулж хариуцсан нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг тэнэмэл амьдралтай 36 иргэнийг бүртгэн, цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн эсэхийг шалгаж, гарын хээ, зургийг авч, бүртгэл судалгаанд баяжилт хийж, бусад шаардлагатай арга хэмжээг авахуулахаар төрийн бусад байгууллагад шилжүүлүүлэхээр Албадан саатуулах төвд хүлээлгэж өгсөн. Мөн 2019 оны 04 дүгээр сард Төмөр замын автобусны буудал, Тоса худалдааны төвийн орчимд архидан согтуурч иргэдийн амгалан тайван байдлыг алдуулдаг, орон гэргүй тэнэмэл иргэдийг цуглуулан "Тэнэмэл-2" арга хэмжээг зохион байгуулж 14 иргэний бүртгэлд баяжилт хийж, 8 иргэнийг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулсан. Цагдаагийн газар нь Баянгол дүүргийн Улаан загалмайн хороотой хамтран "Тэнэмэл" тусгай арга хэмжээг 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулан орон гэргүй 27 тэнэмэл хүнийг бүртгэл судалгаанд авч, сүрьеэ өвчний үзлэг шинжилгээнд хамруулан, гэр орноосоо дайжсан хараа хяналтгүй 1 хүүхэд 7 хүнийг ар гэрт нь эргэн нэгтгэж, 1 хүнийг "Гэрэл гэгээ" халамжийн төвд хүлээлгэн өгсөн. Хариуцсан нутаг дэвсгэрт орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр согтуурах донтой нь тогтоогдсон 11 хүнийг архины албадан эмчилгээнд хамруулж ажилласан байна. Мөн хараа хяналтгүй, хараа хяналт сул (гэр орноосоо дайжсан тэнэмэл, гуйлга гуйдаг, хөдөлмөр эрхлэгч) 18 нас хүртэлх хүүхдүүдийг илрүүлэх, илэрсэн хүүхдүүдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэр бүлд нь эргэн нэгтгэх, асран хамгаалагч нарт нь хүлээлгэн өгөх, хэрэв асран хамгаалагч нарт нь хүлээлгэн өгөх боломжгүй тохиолдолд хүүхдүүдийг халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах зорилгоор 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 18-ны өдрийн хооронд илрүүлгийн ажлыг зохион байгууллаа. Дүүргийн нутаг дэвсгэр нутаг дэвсгэрт хүүхэд орогнож байрлаж болохоор орц хонгил, гудамж талбай, олон нийтийн газар, цахим тоглоомын газар, үзвэр үйлчилгээний газрууд болон нийтийн хоолны сүлжээ газруудад хяналт тавин ажиллаж хараа хяналтгүй болон хараа хяналт сул 61 хүүхдийг илрүүлснээс 14 хүүхэд дүүргийн харъяалалтай байсан тул бүртгэл судалгаанд авч ажиллалаа. Үүнд: Гуйлга гуйж байсан 4, Төөрсөн 3, Тэнэмэл буюу траншейнд амьдарч байсан 1, Хараа хяналтгүй 1, Гар дээрээс жөжиглэн худалдаа эрхлэгч 1, Оршин суух хаяг тодорхойгүй 3, Хараа хяналт сул 48 хүүхэд тус тус илэрсэн. Эдгээр хүүхдүүдээс 4 хүүхдийг Хүүхдийн тусламжийн утас 108-ын дэргэдэх түр хамгаалах байранд хүлээлгэн өгсөн. Баянгол дүүргийн Засаг даргын 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/124 дүгээр захирамжаар архинаас татгалзан, дахилтаас сэргийлэх ач холбогдол бүхий олон нийтийн үүсгэл санаачилгын АА төвийг дэмжих тухай захирамжилсны дагуу дүүргийн АА төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. "Бодлын хүч", "Өглөөний мэнд" бүлэг, давхар хамааралтай эмэгтэйчүүдийн "Өнөр" бүлэг ажиллаж байсан бол 2019 онд АА-н 2 бүлэг, эмэгтэйчүүдийн давхар хамаарлын нэг бүлэг шинээр нээгдэж нийт 6 бүлэг үйл ажиллагаагаа явуулж байна. АА-н 5 бүлэг архигүй амьдралыг сонгосон ямар ч хүнд хэрэгтэй бөгөөд өнөөдрийн байдлаар манай дүүргийн 60 гаруй хүн хамрагдаж, төдий тооны гэр бүлд амар амгалан амьдралын үүд хаалга нээгдээд байна. Харин Ал-Анон буюу давхар хамаарлын бүлэгт архичны ар гэрт зовж шаналж яваа эмэгтэйчүүд хамаардаг билээ. Дүүргийн анхны Ал-Анон бүлгийн үйл ажиллагааг энэ жил 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 125 хүн хамрагдлаа. Хэрж хандах хүнгүйгээс гудамжинд тэнэмэл байдлаар амьдарч байсан 2 иргэнийг Ахмадын асрамж хөгжлийн үндэсний төвд асруулж, 3 иргэнийг нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвд хүргэн, нийгэмшиж байгаа байдалд хяналт тавин ажиллаж байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	10,000,000 Дүүргийн төсөв	70	Нийгмийн хөгжлийн хэлтэс Цагдаагийн газар

		Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг худалдаа, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль, журмын стандартын талаар сургалт зохион байгуулна	Хяналт, шалгалтад хамрагдах ААН, тоогоор	650	1,500,000 Дүүргийн төсөв	100	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс	
			Сургалт, тоогоор	2	3,000,000 Дүүргийн төсөв			
		Хүрсэн түвшин, хэрэгжилт						
	5.4-3	Дүүргийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын шаардлагыг хангуулах, байгууллагын гадна фасат, орчны тохижилт, гэрэлтүүлэг, үйлчилгээний чанар соёлыг дээшлүүлэх зорилгоор аттестатчиллын шалгалтыг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгууллахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс ирүүлсэн мэдээллийн дагуу "Дельта фүүдс" ХХК-д хяналт шалгалт хийхэд уг компани нь "Эвэр-грийн" рестораныхаа 04/0214 тоот тусгай зөвшөөрлийг иргэнд түрээслэж байсан зөрчил илэрсэн бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 6.5.8 дэх заалтын дагуу торгуулийн арга хэмжээ ногдуулж ажиллалаа. Давхардсан тоогоор 56 удаагийн шалгалт зохион байгуулж давхардсан тоогоор 586 аж ахуйн нэгж байгууллагыг шалгаж 21 насанд хүрээгүй хүнд үйлчилсэн, насанд хүрээгүй хүн ажиллуулсан, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан, гар дээрээс согтууруулах ундаа худалдан борлуулсан зэрэг нийт 42 зөрчлийг илрүүлж 6,390,000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/76 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/185 дугаар захирамжаар Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчилалын шалгалтыг 2019 оны 04 дүгээр 09-ний өдрөөс 05 дугаар сарын 22-ны хооронд зохион байгуулна. Тус шалгалтаар гадна орчноо тохижуулж ногоон байгууламж хийсэн эсэх, эвдэрч гэмтсэн хэсгийг засуулах, байгууллагын гадна фасад, цонх, хаяг, хаягийн байгууламж, хайс хашлага, гэрэлтүүлгийг цэвэрлэсэн эсэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу шат, камерийн стандартыг хангаж байгаа худалдааны 119, хоол үйлдвэрлэлийн 98 аж ахуйн нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгуулахаар, дээрх шаардлагыг хангаагүй худалдааны 36, хоол үйлдвэрлэлийн 26 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2019 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 06/1203 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/749 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд 2019 оны 08 дугаар сарын 18-ны өдөр сургалт зохион байгуулж, "Цагийн хуваарьт хязгаар тогтоох тухай" захирамж танилцуулж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, нормативыг хүн амын тоо, бусад нөлөөлөх үзүүлэлтийг харгалзан шинэчлэн тогтоох, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналыг авлаа. Санал асуулгад нийт 189 аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдаж, тайланг 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 06/2076 дугаар албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанд хүргүүлэн ажиллалаа. Дүүргийн Засаг даргын А/426 дугаар захирамжийн хүрээнд 2019 оны 08 дүгээр сарын 13-наас 10 дугаар сарын 16 хүртэл холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран худалдааны 186 цэг салбар, хоол үйлдвэрлэлийн 113 аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Шалгалтаар 224 зөрчил илрүүлж 96 зөрчил газар дээр нь арилгуулан, бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 42, Мэдэгдэл 29, танилцуулга 1-ийг бичиж, байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, 16 хүн, хуулийн этгээдэд холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Зөрчлийн тухай хуулийн 5.14 дэх заалтын хүрээнд 6 хүн, 6 хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 10,600,000. төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ ногдуулсан. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 3 хуулийн этгээдэд холбогдуулан зөрчлийг хэрэг нээж шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.						
5.5	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.	5.5-1	Дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийн арчлалт, хамгаалалтыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх ажил зохион байгуулна.	Гэрэлтүүлгийн асалт 98 хувиас доошгүй байх хувиар	100%	-	70	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
				Шинээр хийгдэх гэрэлтүүлэг, тоогоор	50			
		Хүрсэн түвшин, хэрэгжилт						
		Дүүргийн нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааг хангах, гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өмчийн ашиглалтыг сайжруулах, шуурхай засвар үйлчилгээ бий болгохоор "Хайрхан наран трейд" ХХК, "Төгс гэрэлтүүлэг" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, 7136 гэрэлтүүлэгт арчлалт засвар үйлчилгээ үзүүлж 98%-ийн асалттай бөгөөд гудамжны өнгө үзэмж, цахилгаан байгууламжийн аюулгүй байдлыг хангаж гэрэлтүүлгийн шонд татсан 13,000м кабель шугамыг цэгцлэх, багцлах зэрэг ажлыг гүйцэтгүүлсэн. Мөн гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Нийслэл, дүүргийн 2019 оны төсвийн хөрөнгөөр 208 сая төгрөгийн 102 гэрэлтүүлэг суурилуулсан бөгөөд 2020 онд гэрэлтүүлэг төсөл арга хэмжээ зохион байгуулахаар 421 гэрэлтүүлгийн зураг төсвийн ажлыг дуусгаж бэлтгэл ажлыг хангасан.						
	5.5-2	Иргэд, оршин суугчдын чөлөөт цаг өнгөрүүлэх гэрэлт гудамж бий болгож, гудамжны өнгө үзэмжийг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	1,500,000 Дүүргийн төсөв	70	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	
Хүрсэн түвшин, хэрэгжилт								
		Баянгол дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Чингүнжавын гудамж дагуу байрлах 57-р байр орчимд "Гэрэлт гудамж" байгуулахаар холбогдох байгууллагатай зөвшилцөж, тохижилтын ажлын иж бүрэн зураг төсвийг хийлгэсэн бөгөөд Улсын төсвийн 150 сая төгрөгийн санхүүжилтээр хүүхдийн тоглоом, сагсан бөмбөгийн талбайн барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр тохиролцож, он дамжуулан зохион байгуулахаар гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан ба гэрэлтүүлэг, усан оргилуур, явган хүний зам, ногоон байгууламж зэрэг бусад барилгын ажлын хөрөнгийг 2020 оны төсөвт тусгуулахаар холбогдох байгууллагуудад ханддаг байна. "Байгаль эх цогцолбор"-ын шинэчлэл, тохижилтын ажлыг амжилттай хийж гүйцэтгэн, иргэд, оршин суугчдын чөлөөт цаг өнгөрүүлэх гэрэлт гудамжны өнгө үзэмжийг нэмэгдүүлэн ажиллалаа.						
	Угсармал орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.	Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэлийн төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Төлөөлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс	
		Хүрсэн түвшин, хэрэгжилт						

5.6		5.6-1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон сууцны байрнуудын гадна дулаалга, дулааны техникийн шинэчлэлийн ажилд 2,993.1 сая төгрөгийн ажил хийгдэж байна. Үүнд: Баянгол дүүргийн 8 дугаар хорооны 14 дүгээр байр 2,3 дугаар орц, 12 дугаар хороо 28 дугаар байр, 13 дугаар хороо 7 дугаар байр, 14 дүгээр хороо 9 дүгээр байрны дулаалгын ажлыг "Тамгат тайж констракшн" ХХК хийж гүйцэтгэн ажлын гүйцэтгэл 20%, 5 дугаар хорооны 12, 41 дүгээр байр, 6 дугаар хорооны 5, 16 дугаар байрны дулаалгын ажлыг "Shining house" ХХК гүйцэтгэн ажлын гүйцэтгэл 40%, 15 дугаар хорооны 25, 31 дүгээр байр, 18 дугаар хорооны 45 дугаар байрны дулаалгын ажлыг "СМБ" ХХК хийж гүйцэтгэн ажлын гүйцэтгэл 30%-тай байна.						
5.7	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын дээвэр, цахилгаан шатны засвар, шинэчлэлийн ажлыг жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган үе шаттайгаар зохион байгуулна.	5.7-1	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, цахилгаан шатны ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээнд үзлэг шалгалт зохион байгуулж, хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлыг хангана.	Засах дээвэр цахилгаан шат, тоогоор	10 дээвэр, 10 цахилгаан шат	-	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Улс, нийслэл, дүүргийн төсвөөр хэрэгжүүлэх засварлах шаардлагатай нийтийн зориулалттай орон сууцны байрны 54 дээвэр, 43 цахилгаан шат, 63 фасад дулаалгын судалгааг гаргаж үзлэг шалгалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран явуулж хөрөнгө оруулалтын саналыг холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн улс, нийслэл, дүүргийн төсөвт нийтийн зориулалттай орон сууцны байрны дээврийн их засварт 1.6 тэрбум, цахилгаан шатны шинэчлэлд 1.1 тэрбум, фасад дулаалгад 2.9 тэрбум нийт 5.6 тэрбум төгрөгийг 2019 онд батлуулж 45 дээвэр, 15 цахилгаан шат, 12 фасад дулаалга зэрэг нийт 72 төсөл, арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтэд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хяналт тавьж ажилласан.						
5.8	Гамшгаас урьдчилан сэргийлэх, учирсан хор хохирлыг арилгах, сэргээн босгох талаар сургалт зохион байгуулна.	5.8-1	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллэх дохио дамжуулах журам"-ын 339 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах дүүргийн нутаг дэвсгэр дэх эрт зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулна.	Дадлага сургуульд хамрагдах дүүргийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж байгууллага, тоогоор	350	-	100	Онцгой байдлын хэлтэс	
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, "Гамшгаас хамгаалах дадлага, сургалт зохион байгуулах тухай" ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг, аж ахуй нэгж байгууллагын удирдлага, гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн бие даан зохион байгуулахаар төлөвлөн, төр, захиргааны байр, улсын онц чухал объект, эмнэлэг, их дээд сургууль, аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулахаар хэлтсийн албан хаагчид хариуцсан тухайн байгууллагын дарга захирал нар нь сургалт, дадлага зохион байгуулах тушаал шийдвэрүүдийг гаргуулан, дүүргийн хэмжээнд байрлах 6 ширхэг автомат, 4 ширхэг гар ажиллагаатай сирень дохионы дуугаралтын байдалд хяналт тавьж ажилласан. Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолоор заагдсан цагт Онцгой байдлын албанаас дундын хянагчаар ажиллах 24 албан хаагч томилогдон ажиллаж, бусад байгууллага орон тооны бус штабын бүрэлдэхүүний хүчээр дадлага сургуулийг зохион байгуулж явууллаа. Нэгдсэн дүнгээр 390 байгууллага, аж ахуйн нэгжийн 57,310 ажилтан хамрагдсан байна. Дадлага сургуулийн илтгэх хуудсыг албан бичгээр байгууллага бүрээр гаргуулан авч Онцгой байдлын хэлтэст материалжуулж, дүнг нэгтгэн ажилласан.						
			5.8-2	Гамшгаас урьдчилан сэргийлэх ангиллын сургалтыг зохион байгуулна.	Хамрагдах иргэн, сургалт, тоогоор	200/6000	-	100	Онцгой байдлын хэлтэс
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Гамшгаас урьдчилан сэргийлэх ангиллын удирдах бүрэлдэхүүний сургалт 13 удаа хийж 476 хүн, ААНБ-дад 47 удаа хийж 1926 хүн, ард иргэдэд 19 удаа хийж 1183 хүн, оюутан сурагч 14 удаа хийж, 744 хүн, өдөрлөг нэгдсэн арга хэмжээг 20 удаа, 5709 хүн хамруулан тус тус зохион байгуулан ажиллалаа.						
			5.8-3	Дүүргийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулна.	Хамрагдах анги, алба, тоогоор Хамрагдах хүн, тоогоор	27 10,000	35,000,000 Дүүргийн төсөв	100	Онцгой байдлын хэлтэс
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд Баянгол дүүргийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль" зохион байгуулах тухай А/115, 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдал"-ын зэрэгт шилжүүлэх тухай А/206 дугаар захирамжийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллалаа. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 26 өдрүүдэд зохион байгуулсан. Нүүн шилжих дадлага сургуулиг үед 19 байршилд 55358 иргэн цугларч, газар хөдлөлтийн гамшгийн үед авах анхан шатны арга хэмжээ, эмнэлгийн анхан шатны тусламжийн талаар мэдээлэлтэй боллоо. Нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байрлах "Баянгол Агро" ОНӨТҮГ паркын талбайд зохион байгуулж, 543 иргэнийг хамруулсан. Газар хөдлөлтийн үзүүлэх сургуульд 14 аж ахуй нэгж байгууллагын 251 албан хаагч оролцсон. Гамшгаас хамгаалах команд штабын далага сургуулийн хүрээнд "Крокус" төв штабт 21 албан хаагч, дүүргийн шуурхай штабын байранд 32 албан хаагч, 23 хороодын штабт 91 нийт 142 албан хаагч 2019 оны 04 дүгээр сарын 24, 25, 26-ны өдрүүдэд газар хөдлөлтийн гамшгийн үеийн 3 цагийн байдал дээр шийдвэр гарган ажиллалаа. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг дүүргийн Засаг даргын Тамгын газар, харъяа хэлтэс, албадын 524 албан хаагч удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллалаа.						

5.9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зэлтэй "Жишиг дүүрэг" болно.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангаж хэрэгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	15,000,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс
		Хүрсэн түвшин, хэрэгжилт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дүүргийн Салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг гишүүдийн саналын дагуу нэгтгэн боловсруулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажлаа зохион байгуулж байна. Хөгжлийн хоцрогдол бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт хүлээн авч хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, арга зүйд суралцуулах" 4 дэх удаагийн сургалтыг 03 дугаар сарын 05-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Сургалтад дүүргийн төрийн өмчийн 34 цэцэрлэгийн бүлгийн багш нийт 70 гаруй хүн хамрагдсан ба Токио Гакутэй их сургуулийн профессор Хашимото Соичи, 186-р тусгай цэцэрлэгийн эрхлэгч Д.Энхмөнх багш нар хүрэлцэн ирж "Хөгжлийн хоцрогдол бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт хүлээн авч хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, арга зүйг багш нарт зааж сургалаа. Багш нар өөрсдөд тулгарч буй арга зүйн бэрхшээлийг ярилцан, харилцан бие биедээ туршлагаа солилцсон, үр дүнтэй сургалт боллоо. Уг сургалтыг Жайка ОУБ-ын санхүүжилтээр зохион байгуулсан. Мөн Энэрлийн Түүчээ ТББ-тай хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг сайжруулах" сургалтын 2 дахь модульд 15, 47, 66, 77, 95-р цэцэрлэгийн арга зүйчдийг 01 дүгээр сарын 14-18-ны өдрийг хүртэл 4 өдөр хамруулж арга зүйг сайжрууллаа. Мөн тус сургалтад 87, 88, 89, 141, 161-р цэцэрлэгийн туслах багш нарыг 01 дүгээр сарын 21-нээс 25-ныг дуустал 4 өдрийн турш 11,15, 77, 89, 114,157 зэрэг цэцэрлэгийн туслах багш нарыг 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд 3 өдрийн турш хамруулан, ХБ-тэй хүүхэдтэй ажиллах боловсон хүчнийг чадаажууллаа. Хараагүй иргэдийн төлөө ажилладаг төр, төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангах, хараагүй иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн хараагүй иргэдийг Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо /МХҮХ/-ны үйл ажиллагаатай танилцуулах, тус холбооноос хэрэгжүүлж буй үйлчилгээг хараагүй иргэдэд хүртээмжтэй хүргэх "Зочин" хөтөлбөрийг 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Энэ хөтөлбөрт: Харааны бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, шинээр групп тогтоолгосон хараагүй иргэд, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, хороодын нийгмийн ажилтнууд нийт 50 хүн хамрагдсан. Мөн Холбооны дэргэдэх хараагүй иргэд ажилладаг Ярьдаг болон брайль үсгийн хэвлэлийн төв, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, "Бэст" массажийн төв, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэртэй танилцан, Хараагүй бариста нарын кофегоор дайлуулан, хараагүй уран бүтээлчдийн урлагийн тоглолт сонирхон 1 өдрийг сонирхолтой өнгөрүүллээ. Мөн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн багш оюутнууд зочиддоо массажийн үйлчилгээ үзүүлсэн юм. "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх нь" төслийн хүрээнд хэрэгжиж буй "Peer Counseling" хөтөлбөрийн 2019 оны ээлжит уулзалт, зөвлөгөөнийг "Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв"-тэй хамтран дүүргийн Хүүхэд залуучуудын соёлын ордны урлагийн зааланд 14 хоног тутам зохион байгуулж байна. Гэрээсээ тэр бүр гардаггүй адил нөхцөл байдалд буй ижил бэрхшээлтэй хүмүүс хоорондоо нийгмийн амьдрал, хууль эрх зүйн талаар харилцан ярилцлага, зөвлөгөө, зөвлөлдөөн хэлбэрээр ярилцаж, бие биедээ дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллаж, нийгмийн харилцаанд оролцоход нь дэмжлэг үзүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, гоо зүйн хүмүүжил төлөвшүүлэх, тэдний дуу хоолойг сонсох, бусдад хүргэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд урлагийн "Алтан намар" наадмыг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Урлагийн наадамд тус дүүргийн 51 иргэн 7 төрлөөр оролцон шилдгүүдээ тодрууллаа. 1-3-р байранд шалгарсан иргэдэд өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулсан бөгөөд тусгай байрт шалгарсан болон оролцсон нийт иргэдэд Батламж, мөнгөн шагнал олгож, тэдний авьяас чадвар, оролцоо, идэвхийг урамшууллаа. Урлагийн наадмын төрөл тус бүр дээр 1-3 дугаар байр эзэлсэн иргэд нийслэлийн уралдаанд оролцож төрөл тус бүр дээр байр эзлэн, амжилт гаргалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийг дүүргийн хэмжээнд зохион байгуулахаар ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.					
		Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	15,000,000 Дүүргийн төсөв	100	Нийгмийн хөгжлийн хэлтэс
5.9-2		Хүрсэн түвшин, хэрэгжилт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурал 2019 онд 19 удаа хуралдаж 375 хүүхдэд дүгнэлт гаргаж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах зөвлөгөө чиглэл өгч ажиллалаа. Тус Салбар комиссоос Хөгжлийн бэрхшээл нь оношлогдон, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа боловч хөгжлийн дэмжлэг, сэргээн засах үйлчилгээнд хамруулах шаардлагатай хүүхдийг холбогдох мэргэжилтнүүд хамтран хэлэлцэж шийдвэрлэх зорилготой "ICF-д суурилсан кэйс хэлэлцүүлэг"-ийг 5 удаа зохион байгууллаа. Төрөлхийн сонсголгүй, аутизмын хүрээний эмгэгтэй, хүүхдийн тархины саа өвчтэй 5 хүүхдэд тулгарсан асуудлыг холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хамтран хэлэлцэж, хөгжлийн дэмжлэг, сэргээн засах үйлчилгээнд хамруулах 1 жилийн хугацаатай төлөвлөгөө гарган ажиллалаа. Кейс ажилласнаар хүүхдийн боловсролд хамрагдалтын асуудлыг шийдвэрлэн, нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээнд явуулан, эцэг эхийг ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж, багш, эцэг эхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сургалт, зөвлөгөөг өгч ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар болон маягт батлах тухай 3 сайдын хамтарсан тушаалын дагуу дүүргийн ЕБС-уудад "Сургуулийн дэмжлэгийн баг" байгуулсан. Сургуулиудын дэмжлэгийн багт зориулсан сургалтын гарын авлага, багц материалыг 18 сургуульд олгож туслан зөвлөж ажиллалаа. Тусгай боловсролын үндэсний төвтэй хамтран сургуулийн дэмжлэгийн баг болон сургууль, цэцэрлэгийн удирдагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.					
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд Баянгол дүүргийн нэрэмжит нээлттэй тэмцээн зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	5,000,000 Дүүргийн төсөв	100	Биеийн тамир спорт хороо

		5.9-3	Хүрсэн түвшин, хэрэгжилт "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын нөхөрсөг тэмцээн"-ийг 11 дүгээр сарын 22-ны өдөр 70 дугаар сургуулийн спорт зааланд 2 дахь удаагаа зохион байгууллаа. Тэмцээн шатар/эр, эм/, ширээний теннис /эр, эм/, гар барилдаан/эр, эм/, дартс, олс таталт, нисдэг таван гэсэн 6 төрлөөр явагдлаа. Тэмцээнд хороодын 4 бүсийн 4 баг, "Түгээмэл хөгжил" Бие даан амьдрах төв, Баянгол дүүргийн ХБИ-ийн холбоо, Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбооны Баянгол дүүргийн иргэдийн баг, нийт 7 багийн 70 тамирчин хурд, хүч авьяасаа сорин өрсөлдлөө.							
ЗУРГАА. АМЬДРАХАД ТААТАЙ ОРЧИНТОЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ										
6.1	Гэр хорооллыг орон сууцжуулах болон ая тухтай амьдрах санал санаачлагыг ажиглана.	дэмжээг	6.1-1	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	70	Төлөвлөлт, гүйцэтгэлийн шинжилгээний хэлтэс	хяналт.
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч "Грийн ресурс констракшн" ХХК Бичил-7 орон сууцны хорооллын 2 дугаар ээлжийн 222 айлын 2 блок орон сууцны барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.							
			"Жишиг хашаа-Жишиг гудамж"-ны зураг төсвийн ажлыг зохих улс Зургасан төсвийн ажлын хэрэгжилтээр	100%	10,000,000 Дүүргийн төсөв	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс			
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн гэр хорооллын бүсэд дүүргийн хэв загварыг харуулсан гэр хорооллын айл өрхүүдийн хашаа, амьдрах орчныг сайжруулах, сайн туршлагыг нэвтрүүлэх, иргэд оршин суугчдын эрүүл, ая тухтай орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн хангамж, дэд бүтэцтэй болгох "Жишиг хашаа-жишиг гудамж"-ний ажлын зураг төсөв хийх ажлыг "Нарлаг хөхий" ХХК-аар гүйцэтгүүлж хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлыг хангасан.							
6.2	Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцыг шинэчлэх ажлыг Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиглана		6.2-1	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг сууц өмчлөгч иргэдийн оролцоотой Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газартай хамтран зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	100	Төлөвлөлт, гүйцэтгэлийн шинжилгээний хэлтэс	хяналт.
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн зориулалттай орон сууцны 1-60, 2-60 дугаар байрны сууц өмчлөгч иргэдээс дахин төлөвлөлтөд хамрагдах эсэх санал авах ажлыг хороодын ажлын албатай хамтран 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан. 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 03/972 дугаар албан бичгээр 1-60, 2-60 дугаар байрны сууц өмчлөгч иргэдийн хүсэлтийг Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт хүргүүлсэн. Дүүргийн17 дугаар хорооны Иргэний танхимд 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр 27 дугаар байрны сууц өмчлөгч иргэдийг төлөөлж үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах иргэнийг сонгох уулзалт хурлыг хорооны ажлын албатай хамтран зохион байгуулж 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03/826 тоот албан бичгээр Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газарт үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах сууц өмчлөгч иргэдийн мэдээллийг хүсэлтийн хамт хүргүүлсэн. Баянгол дүүргийн 1, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн зориулалттай орон сууцны 7, 8, 11, 12 дугаар байрны сууц өмчлөгч иргэдийн хүсэлтийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 15.00 цагт 4 дүгээр хорооны иргэний танхимд НИТХ-ын төлөөлөгч Л.Нарантуяа, Хот байгуулалт, Хөгжлийн газар, Баянгол дүүргийн ЗДТГ-ын холбогдох албан хаагчид болон төсөл хэрэгжүүлэгч "Тэргүүн чансаа" ХХК-ийн удирдах албан хаагчдын хамтарсан уулзалт хурлыг зохион байгуулж төслийн хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцэж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, гэрээ байгуулах үйл явцын талаар санал солилцож шийдвэрлэх арга хэмжээ авч ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/397 дугаар "Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай" захирамжийг тус тус үндэслэн Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн зориулалттай орон сууцны 28, 29, 30 дугаар байр, 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 22, 23, 24, 37 дугаар байрны өмчлөгч иргэдийг төлөөлөн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцох сууц өмчлөгч иргэдийн нэрсийг 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 03/1982 тоот албан бичгээр Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газарт хүргүүлсэн.							
			Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны талаар иргэдийг мэдээллээр хангаж, иргэдийн оролцоотой хяналт тавьж ажиллана	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	100	Төлөвлөлт, гүйцэтгэлийн шинжилгээний хэлтэс	хяналт.	
			Хүрсэн түвшин, хэрэгжилт							

		6.2-2	Дүүргийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн 1 дүгээр хэлтэст 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/665 тоот албан бичиг хүргүүлж 1, 3, 4 дүгээр хорооны ашиглалтын шаардлага хангахгүй, ашиглахыг хориглосон нийтийн зориулалттай орон сууцанд үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад холбогдох хэлтсүүд хамтран 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр албан мэдэгдэл хүргүүлж 2019 оны 04 дүгээр сарын 10-ны дотор үйл ажиллагаагаа зогсоон аюулгүй, байдлаа хангах талаар мэдээлэл өгч ажиллалаа. Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 10, 11, 12 барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/174 дугаар "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай" захирамж батлагдсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр дүүргийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Газрын алба, Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хэрэгжилтэнд хяналт тавьж зөвшөөрөлгүй баригдсан өргөтгөл, барилгын зориулалт төлөвлөлтийг өөрчилсөн, гэрээ байгуулсан, байраа чөлөөлсөн сууц өмчлөгч иргэдийн эрх ашиг, эд хөрөнгө, эрүүл мэнд, аюулгүй байдал, учирч болох эрсдлээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж үйлдвэр үйлчилгээ эрхлэгч 12 аж ахуйн нэгж байгууллагуудад үйл ажиллагаагаа зогсоох тухай хугацаатай албан мэдэгдэл өгч ажилласан. Төсөл хэрэгжүүлэгч "Тэргүүн чансаа" ХХК дүүргийн 1 дүгээр хорооны 10 дугаар байрыг буулган барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна.					
6.3	Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа тоосгон болон дан гараашиг иргэдийн оролцоотой дахин төлөвлөлтөд оруулна.	6.3-1	Төлөвлөлтгүй баригдсан тоосгон гараашийг буулгах болон төмөр гарааш, чингэлгийг нүүлгэн шилжүүлэх, нийтийн эзэмшил гудамж, зам, талбай, инженерийн шугамын хамгаалалттай бүсэд газар ашиглаж байгаа иргэдэд шаардлага хүргэж газар чөлөөлөх ажлыг үе шаттай гүйцэтгэх, зөрчил арилгах ажлыг зохион байгуулна.	Газар чөлөөлөх талбай, тоогоор	150	-	100	Газар зохион байгуулалтын алба
		6.3-1	Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн засаг даргын "Газар чөлөөлөх" тухай 7 удаагийн захирамжийг хэрэгжүүлэн ажиллаж 6 дугаар хорооны нутаг дэвсгэр 10 дугаар хорооллын ард талын далан дээгүүр улсын төсвийн хөрөнгөөр баригдах авто замын трасст орсон 19 ширхэг тоосгон гарааш, 7 ширхэг контейнер болон чингэлэг, 1 ширхэг сандвичин барилга, 2 ширхэг нэгж талбарын блокон хашаа, 1 айлын банзан хашааг, 6 дугаар хорооны нутаг дэвсгэр 10 дугаар хорооллын дунд Зам тээврийн хөгжлийн яамны захиалгаар гүйцэтгэж байгаа авто замын трасст өртсөн 19 дүгээр байрны зүүн болон хойд талын 22 ширхэг зөөврийн объект, харуулын байр, 22-р байрны зүүн урд талын 1 ширхэг ТҮЦ, 2 ширхэг чингэлгийг, 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр 52 дугаар байрны зүүн талд улсын төсвөөр хийгдэж буй дулаан шугамын засварын ажилд саад учруулсан 9 ширхэг тоосгон гарааш, 3 ширхэг төмөр гараашийг албадан нүүлгэж нийт 5 шат, шон 5, хашаа 28, контейнер 15, төмөр гарааш 26, тоосгон гарааш 35, ТҮЦ 24, тоосгон болон бетонон объект 16 буулгаж нийтийн эзэмшил гудамж, зам, талбай, инженерийн шугамын хамгаалалттай бүсэд газар чөлөөллөлтийн ажил хийгдээд байна. Мөн тус дүүргийн 12 дугаар хороонд Ус зайлуулах инженерийн шугам сүлжээний трасст өртсөн 13 контейнер, 1 дүгээр хороонд 49 дүгээр байрны зүүн талд 1 гарааш, 3 дугаар хороо 65 дугаар байрны хойд талаас 1 ТҮЦ, 4-р хороо Golden park хотонд зөвшөөрөлгүй байршуулсан 1 ТҮЦ, 7-р хороо 25 дугаар байрны эргэн тойронд байрлуулсан 30 төмөр гарааш, контейнер, 1 дүгээр хороо Богд-Ар хорооллын зүүн талд байрлуулсан 1 ТҮЦ, 6 дугаар хороо УБ паласын зүүн талд төв зам дагуу байрлуулсан 1 ТҮЦ, 21 дүгээр хороонд орон нутгийн төсвөөр хийгдэх тохижилтын ажлын талбайд байрлуулсан 3 ТҮЦ, 20 дугаар хороонд эзэмшил талбайгаасаа илүү барьсан, бусдын орц гарц хаасан 1 хуулийн этгээдийн бетонон хашаа, 2-р хороонд нийтийн эзэмшлийн талбайд зөвшөөрөлгүй байршуулсан 11 төмөр гарааш, 1 бетонон гараашийг тус тус албадан чөлөөлж нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлсөн.					
		6.3-2	Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа тоосгон болон дан гараашийн судалгааг гаргаж дахин төлөвлөлтөд оруулах ажлыг судална.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	70	Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс, Хороод
		6.3-2	Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн 23 хороодын нийтийн эзэмшлийн зам, талбайд дүүргийн хэмжээнд урьдчилсан судалгаагаар 2861 тоосгон болон дан гарааш байна. Дүүргийн нийт нутаг дэвсгэрт байгаа тоосгон болон дан гараашийг нүүлгэн шилжүүлэх буюу газар чөлөөлөхөд нөхөн олговор зайлшгүй шаардлагатай бөгөөд 2019 онд газар чөлөөлөхөд шаардагдах нөхөн олговорыг шийдвэрлүүлэхээр Улаанбаатар хотын Захирагч бөгөөд Нийслэлийн Засаг даргад уламжилсан. Баянгол дүүргийн 2019 оны байдлаар 35 тоосгон болон дан гарааш 38, төмөр гарааш, контейнер 113-ыг нүүлгэн шилжүүлж газар чөлөөлөөд байна.					
		6.3-3	Орчны тохижилт бүхий газар доорх гараашийн барилгыг барих ажлыг иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын оролцоотой зохион байгуулна.	Дүүрэгтэй хамтран ажиллах гэрээний гүйцэтгэл, хувиар	100%	-	(-)	Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс, Хороод
		6.3-3	Хүрсэн түвшин, хэрэгжилт Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/933 дугаар захирамжаар Баянгол дүүрэгт 11 байршилд газар эзэмших эрх олгогдсон. Үүнээс одоогоор 5 аж ахуйн нэгж байгууллага, иргэн дүүргийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулаад байна. Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба тухайн байршлуудын газрын гэрчилгээг гаргахгүй удаж байгаатай холбогдон одоогоор барилгын ажил эхлээгүй байна. Баянгол дүүргийн 6 дугаар хорооны орон сууцны 19 а, б байрны хойд талд 3774м2 талбай болон орон сууцны 43, 44а, б байрны дунд 1446 м2 талбайд улсын төсвийн хөрөнгөөр тохижилт бүхий газар доорх авто зогсоолын барилга барихаар төлөвлөн тус 2 газрыг Нийслэлийн Засаг даргаар батламжуулахаар Засаг даргын 2019 оны 03/714 дүгээр албан бичгийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, гарсан захирамжийн дагуу зураг төслийн ажил хийгдэж байна.					
			Орон сууцны болон гэр хорооллын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, арчлалт хамгаалалтыг сайжруулах ажлыг олон нийтийн оролцоотой зохион байгуулна.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн гудамж, тоогоор	3	3,000,000 Дүүргийн төсөв	70	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ-ын оролцоотой нийтийн зээмшлийн талбайд тохижилт хийж мод тарих, зүлэгжүүлэх замаар нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, арчлалт хамгаалалтыг сайжруулна.

6.4-1	Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн Засаг даргын 2019 оны А/242 дугаар "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хөтөлбөр зарлах тухай" захирамжаар шинээр мод, бут сөөг тарих, өмнөх онуудад таригдсан модонд арчлалт, нөхөн тарилт хийх зэрэг ажлыг зохион байгуулахаар "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор 5 дугаар сард 3216 мод, бут сөөг, 10 дугаар сард 3082 мод, бут сөөг буюу нийт 6298 мод, бут сөөг тарьсан байна. Мөн нийслэлийн төсвийн хөрөнгөөр Ард Аюушийн өргөн чөлөөнд 1000 гацуур мод тарих арга хэмжээ хэрэгжиж дүүргийн ногоон байгууламжийг 2019 онд нийт 7298ш мод, бут сөөгөөр нэмэгдүүлсэн. Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын А/333 дугаар захирамжаар Магсаржавын гудамжны 3500 м кв талбайд сул шороон талбайд зүлэг, нэг наст цэцэг тарих ажлыг 2019 оны 06 дугаар сарын 18-наас 06 дугаар сарын 23 ны хооронд нийслэлийн Хот тохижилтын газартай хамтран зохион байгуулсан бөгөөд 13, 15, 17, 18 дугаар хороодын 4 байршилд "Ойн төгөл" бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг 46 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр гүйцэтгүүлсэн. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн "Шарилжуй Улаанбаатар-4" аян зохион байгуулах тухай" 2019 оны А/145 дугаар тушаалаар 06 дугаар сарын 20-ноос 08 дугаар сарын 20-ныг хүртэл хугацаанд ургамлын тоосны харшлаас сэргийлэх, өвчлөлийн тоог бууруулах зорилгоор орон сууц, гэр хорооллын нийтийн зээмшлийн гудамж, зам дагуух 180,052 м кв талбайд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, хог тээврийн үйлчилгээний байгууллагуудын оролцоотой шарилж цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, нийт 64 тн хог ургамлыг ачиж тээвэрлүүлсэн.					
	"1000 цэцгийн мандал II" аяныг зохион байгуулна.	Цэцгийн тоогоор	50,000	5,000,000 Дүүргийн төсөв	40	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил" болгон зарласантай холбогдуулан сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг идэвхижүүлэх, ногоон байгууламжийн нэг хүнд ноогдох талбайг иргэдийн оролцоог хангаж нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх үүднээс дүүргийн Засаг даргын 2019 оны А/380 дугаар захирамжаар сууц өмчлөгчдийн холбоодын дунд 5 шалгуур үзүүлэлт бүхий "Миний байр" болзолт уралдааныг 07 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Уг уралдаанд 24 сууц өмчлөгчдийн холбоо өрсөлдөж, ногоон байгууламж шинээр бий болгосон 7, сэргээж ургуулсан 8, гадна талбайд цэцгийн мандал байгуулсан 6, байрны орцод цэцэг байршуулсан 3 зэргээр сууц өмчлөгчдийн холбоод оролцож, уралдааны хүрээнд 8.6 сая төгрөгийн хөрөнгөөр 5111 м кв талбайг ногоон байгууламжаар нэмэгдүүлж, идэвхи санаачлагатай оролцсон шилдэг 1 сууц өмчлөгчдийн холбоог 2 сая төгрөгийн урамшуулж ажилласан байна.					
	Нийтийн зээмшлийн гудамж, талбайн ногоон байгууламжийн арчилгаа, үйлчилгээг сайжруулах, хортон шавьжтай тэмцэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт Раднаабазар, Жасрай, Замчид, Нарны замын туслах зам, Ханбүргэдэйн гудамж болон орон сууцны хороолол дундах 621 улиас модыг хэлбэржүүлэх, өвчин хортноос сэргийлж шохойдох зэрэг ажлыг 04 дүгээр сарын 07-ноос 04 дүгээр сарын 15-ны хооронд "Ариун шимт байгаль" ТББ-тай хамтран зохион байгуулж модны насжилтын дэмжих, үр хөврөлийг бууруулах, харшил үүсгэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан бөгөөд "Улиас модны үндэс, иш орчмоор салаалж ургасан салаа мөчир, гуарыг цэвэрлэх ажил зохион байгуулах тухай" дүүргийн Засаг даргын баталсан удирдамжын дагуу "Баянгол Агропарк" ОНӨТҮГ-тай хамтран 2 удаагийн давтамжтай ногоон байгууламжийн арчлалт үйлчилгээний ажил зохион байгуулсан. Мөн 23 хорооны сууц өмчлөгчдийн холбоо, иргэдэд мод хэлбэржүүлэлт, тайралтын талаарх мэдлэг мэдээлэл хүргэх зорилгоор үзүүлбэр сургалт зохион байгуулсан ба иргэд, сууц өмчлөгчдийн холбоод өөрсдийн дотоод хүний нөөц, боломжоор ногоон байгууламжийн арчилгаа үйлчилгээ, хэлбэржүүлэлтийг ажлыг гүйцэтгэх боломжийг бүрдүүлж өгсөн.					
6.4-4	Ахмад настны чийрэгжүүлэлт, хүүхэд залуучуудын спорт тоглоомын талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, тохижилтын эвдрэл гэмтлийг засварлах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт Улс, нийслэл, дүүргийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтэн байгуулалтын ажлын хүрээнд 4.5 тэрбум төгрөгийн 75 төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн ба үүнийг задалж үзвэл улсын төсвийн хөрөнгөөр 12, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 22, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 41 байршилд сагсан бөмбөгийн болон хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, сул шороон даланг хавтанжуулах зэрэг тохижилтын ажлууд хэрэгжсэн бөгөөд иргэд оршин суугчдын эрүүл аюулгүй орчин амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 23 хорооны хүүхдийн тоглоомын талбайн бүртэн бүтэн байдалд үзлэг шалгалтын ажил зохион байгуулж илэрсэн зөрчил дутагдал, засварлах шаардлагатай ажлын тоо хэмжээ, төсөв санхүүгийн тооцоо судалгааны ажил гүйцэтгэж шаардагдах 30 сая төгрөгийн төсвийг дүүргийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ авч ажилласан. Улмаар батлагдсан төсөв хөрөнгийн хүрээнд холбогдох хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, "Цагираг шугам" ХХК-тай 08 дугаар сарын 07-ноос 09 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд тоглоомын талбайн эвдрэл, гэмтэл зэргийг засварлаж аюулгүй байдлыг хангасан байна.					
	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагад 50м газрыг тохижуулах шаардлага хүргүүлж, орчны өнгө үзэмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
	Хүрсэн түвшин, хэрэгжилт					

		6.4-5	Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх гэрчилгээ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний санал авах иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 50 метр орчмын тохижилтыг хорооны Засаг даргаар баталгаажуулах ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж 873 байгууллагын мэдээллийн сан үүсгэж, шаардлага тавьж ажилласнаас хаягаа солиулсан 184, ногоон байгууламж тариулсан 51, ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав суурилуулсан 124, гадна болон дотор талдаа камер хийсэн 33 байгууллага буюу нийт 392 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тохижилтын ажил хийлгэсэн байна. Мөн Баянгол дүүргийн Засаг даргын 2019 оны А/292 дугаар "Цэмцгэр хашаа аян зарлах тухай" захирамжийн хүрээнд өнгө үзэмж муутай хашаа, хайсыг эзэмшигч, ашиглагч 30 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шаардлага хүргүүлэн засварлан шинэчлүүлж, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран 18 хашаа хайсыг буулган нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлүүлсэн. Нийтийн эзэмшлийн талбайд зөвшөөрөлгүй, хууль тогтоомжийн шаардлага хангаагүй мэдээллийн самбар байрлуулсан 106 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэх хуудас хүргүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллалаа.					
		6.4-6	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ-дод сургалт зохион байгуулж, өөрийн талбайд цэцгийн мандал, зүлэгжүүлэлт хийх ажлыг зохион байгуулна.	Хамруулах аж ахуйн нэгж, байгууллага, тоогоор	45	800,000 Дүүргийн төсөв	70	"Баянгол Агропарк" ОНӨТҮГ
				Хамруулах сууц өмчлөгчдийн холбоо, тоогоор	50			
				Ногоон байгууламж хийх талбай, м2-аар	1500			
		6.4-6	Хүрсэн түвшин, хэрэгжилт Баянгол дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 45 аж ахуйн нэгж, 50 СӨХ-ийг хамруулан мод хэрхэн арчлах талаар практик сургалтыг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Баянгол дүүргийн Замчдын гудамжинд зохион байгуулав. Уг сургалтанд Баянгол дүүргийн Засаг дарга С.Одонтүяа, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Ж.Ганболд нар оролцон иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэв. Нийтийн эзэмшлийн талбайд байгаа мод, бут, сөөгийг хэрхэн хэлбэржүүлж тандалт хийх, зэрлэг ургамлыг устгах, мод ургуулж арчлах, хортон шавьжтай тэмцэх талаар "Баянгол Агропарк" ОНӨТҮГ-ын мэргэжилтэн Н.Баярцогзол, Г.Тэргэл, Г.Нямдорж, Б.Дорждэрэм нар практикаар үзүүлэх сургалт хийв. Сургалтанд хамрагдсан иргэд өөрсдийн гараар мод хэлбэржүүлж мэдлэгээ баталгаажууллаа. Сургалтын хүрээнд мэргэжилтнүүд Замчдын гудамжинд нийтийн эзэмшлийн зам талбайд үргэж буй мод, бут, сөөгийг хэлбэржүүлэн засч тандалт хийн ажиллав.					
			Дүүргийн иргэдийн дунд ил талбайн болон хүлэмжинд таригдах хүнсний ногооны сургалтыг явуулна.	Хамруулах иргэд тоогоор	100	400,000 Дүүргийн төсөв	100	"Баянгол Агропарк" ОНӨТҮГ
				Хамруулах иргэд тоогоор	100	400,000 Дүүргийн төсөв		
		6.4-7	Хүрсэн түвшин, хэрэгжилт Хүлэмж болон гадна талбайд нарийн ногоог тарьж ургуулах, арчлах талаарх сургалтыг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран 23 хороодын иргэдэд зохион байгуулллаа. Тус сургалтаар НХХААГ-ын сургагч багш Ч.Авирмэд, Д.Зандармаа, "Баянгол Агропарк" ОНӨТҮГ-ын мэргэжилтэн Н.Баярцогзол, Г.Тэргэл нар үр сонгох тухай, үрсэлгээний тухай, Нарийн ногоо тариалах арга, Хөрс боловсруулах арга сэдвээр иргэдэд лекц, практик хослуулан иргэдэд анхан шатны мэдлэг олгов. Сургалтад 23 хорооны нийт 100 иргэн хамрагдаж, нарийн ногоо тариалах сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Нутгийн удирдлагын ордны 2 давхрын Иргэний танхимд амжилттай зохион байгуулж, СД-нд буулган өгснөөр иргэд өөрсдийн газар дээр ногоо тарихдаа ашиглах гарын авлагаар хангагдлаа. Сургалтанд хамрагдсан иргэдэд 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл ашиглах түр үнэмлэх олгов. Ингэснээр "Баянгол Агропарк" ОНӨТҮГ-ын 20 дугаар хороонд байрлах газар болон хүлэмжийг ашиглан ногоо тарих боломжтой болов. 2019 оны 05 дугаар сарын 10-нд дүүргийн 23 хорооны иргэдэд зар түгээн хүнсний ногооны практик сургалт зохион байгуулав. Уг сургалтыг 20 дугаар хороонд байрлах "Баянгол Агропарк" ОНӨТҮГ-ын талбай дээр практик хичээл орж иргэдэд ил талбайд болон хүлэмжинд хэрхэн газраа хагалж тариалалтанд бэлтгэх, үрээ хэрхэн сонгох, ямар ногоонууд тохиромжтой байдаг эсэх, усалгаа арчилгааг ямар заавраар хийдэг зэрэг нарийвчилсан мэдээллээр зохион байгууллаа. Сургалтанд 23 хорооноос давхардсан тоогоор 85 иргэн хамрагдаж, сургалтанд хамрагдсан иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад 100% сэтгэл хангалуун, үр өгөөжтэй сургалт болсныг илтгэсэн байлаа. Сургалтын үр дүнд өнөөдрийн байдлаар "Баянгол Агропарк" ОНӨТҮГ-ын талбайд байрлах иргэдийн хүлэмжинд нийт 64 иргэн ногоо тарин, өдөр бүр усалгаа арчилгаа хийж байна. Иргэдэд "Баянгол Агропарк" ОНӨТҮГ-ын мэргэжилтэн Н.Баярцогзол, Г.Тэргэл, Г.Нямдорж нар өдөр бүр мэргэжлийн заавар зөвлөгөө өгөн ажиллаж байна.					
6.5	Иргэдийн чөлөөт цаг өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулна.	6.5-1	Орон сууцны хороолол дундах цэцэрлэг орчмын ногоон байгууламжийг иргэдийн чөлөөт цаг өнгөрүүлэх орчин бий болгох боломжийг судална.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	(-)	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
		6.5-2	Дүүргийн нутаг дэвсгэр дэх усан оргилуурын арчлалт, хамгаалалтыг сайжруулна.	Усан оргилуур, тоогоор	14	-	70	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
		6.5-2	Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, талбай дахь усан оргилуурын өөдрөл, гэмтлийг шалгаж, засвар үйлчилгээг "Төгс гэрэлтүүлэг" ХХК нь 06 дугаар сарын 28-наас 09 дүгээр сарын 15-ныг хүртэл хугацаанд хариуцан ажиллалаа. Уг ажлын хүрээнд нийт 7 усан оргилуурыг засварлаж, хэвийн ажиллагааг ханган иргэд, оршин суугчдын амарч, зугаалах нөхцөл боломжийг хангуулж ажиллалаа.					

			"Тохилор орц" аян зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	10,000,000 Дүүргийн төсөв	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
		6.7-2	Хүрсэн түвшин, хэрэгжилт Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг идэвхижүүлэх, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээ, арчлалт, хамгаалалтыг дээшлүүлэх, ажлын шинэ санал санаачлагыг дэмжих зорилгоор дүүргийн Засаг даргын 2019 оны А/380 дугаар захирамжаар "Миний байр" аяныг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулж, зөвлөгөө мэдээллээр хангаж хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажилласан Аяны хүрээнд 18 байрны 29 орцод 98.0 сая төгрөгөөр урсгал болон их засвар ажил хийгдсэн бөгөөд амжилттай оролцсон сууц өмчлөгчдийн холбоог шагнаж урамшуулж ажиллалаа.					
6.8	Дүүргийн нийтийн зээмшил, орон сууц, гэр хорооллын авто замыг өргөтгөн шинэчлэх, эвдрэл, гэмтлийг засварлах ажлыг зохион байгуулна.	6.8-1	Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон сууцны хорооллын авто замд засвар шинэчлэлт, гэр хорооллын шороон замын нөхцөл сайжруулах ажлыг зохион байгуулна.	Нөхөөс, м2-аар	2000м2 дээш	1,000,000 Дүүргийн төсөв	70	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс
				Зам засвар, шинэчлэлт, км-ээр	2-оос дээш байрлалд			
				Гэр хорооллын зам засвар, км-ээр	30км			
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Авто замын түгжрэл, зам тээврийн осол аваарыг бууруулах ажлын хүрээнд Улс, нийслэл, дүүргийн 2019 оны төсөвт 12.6 тэрбум төгрөгийн хөрөнгө батлуулж, дүүргийн нутаг дэвсгэр дэх авто замын сүлжээнд 3.6км шинэ зам, 4.7км өргөтгөл, шинэчлэл, 7589м2 авто машины ил зогсоол, 7775м2 нөхөөс, 15.6км заадас, 13586м2 хэвтээ тэмдэглэгээ, 49.5км гэр хорооллын шороон замын нөхцөл сайжруулах зэрэг нийт 15 төсөл арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд Улсын төсвийн 3 төсөл арга хэмжээ нь худалдан авах ажиллагаанаас хамаарч он дамжаж зам барилгын ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулаад байна.					
		6.8-2	Явган хүний зам талбайг стандартад нийцүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Шинээр хийгдэх явган хүний зам, метрээр	500	-	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс
Хүрсэн түвшин, хэрэгжилт Дүүргийн нутаг дэвсгэр дэх явган хүний замын нөхцөл сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхээр Нийслэл, дүүргийн 2019 оны төсөвт 995.6 сая төгрөг батлуулж, 14,051м2 явган хүний зам талбайг шинэчлэх болон сэргээн засварлах ажлыг эхлүүлж, 4271м2 явган зам он дамжуулан барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан бөгөөд 9780м2 явган замын барилгын ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд иргэд оршин суугчдын аюулгүй зорчих боломжийг бүрдүүлж, 2020 онд явган хүний замын өргөтгөл, шинэчлэлийг ажлыг эрчимжүүлэхээр барилгын зураг төслийг "Нарлаг Хөхий" ХХК-иар гүйцэтгүүлж бэлтгэл ажлыг хангасан.								
		6.8-3	Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын бэлтгэлийг хангаж, зураг төсвийг бэлэн болгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Нийтийн зээмшил, орон сууцны хорооллын авто машины ил зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг 2020 онд эрчимтэй хэрэгжүүлэхээр 19829м2 ил зогсоол байгуулах боломжтой байршлын судалгаа гаргаж, архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулан 15007м2 талбайн авто машины ил зогсоолын зураг төсвийг "Нарлаг хөхий" ХХК-иар гүйцэтгүүлж, хэрэгжилт 90%-ийн биелэлттэй байна.					
6.9	Дүүргийн алслагдсан хороодод нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд нийтийн тээврийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	6.9-1	Гэр хорооллын нийтийн тээвэрт стандарт, шаардлага хангасан такси болон бага оврын автобусаар үйлчлэх нөхцөл боломжийг судлаж, хэрэгжилтийг зохион байгуулна.	Судалгаа хийгдсэн гэр хорооллын нийтийн тээврийн маршрут, тоогоор	4	-	(-)	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Гэр хорооллын нийтийн тээвэрт бага оврын автобусаар зөвшөөрөлгүй үйлчилгээ эрхлэгчидтэй уулзалт зохион байгуулж, иргэдийн аюулгүй, тав тухтай зорчих нөхцөл боломжийг сайжруулахад дүүргийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Зөвшөөрөлгүй үйлчилгээ эрхлэгчдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, бүртгэлжүүлж батламж олгох ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн гэр хороолол, тэц-4, Дэвшил Сангийн аж ахуй, орчмын айл өрхийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тухайн чиглэлд дамжин өнгөрөх нийтийн тээврийн тоо хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг Нийслэлийн тээврийн газартай зөвшилцөж байна.					
		6.10-1	Хог хаягдалын тогтолцоонд тавих хяналтыг сайжруулах зорилгоор олон нийтийн байцаагчийн ажиллах чиг үүрэг, зохион байгуулалтыг шинэчлэж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100%	-	100	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
			Хүрсэн түвшин, хэрэгжилт Хог хаягдлын олон нийтийн байцаагчдын орон тоог 24 болгон нэмэгдүүлж, тавигдах шаардлагыг батлан хороодын Засаг дарга нарын саналыг үндэслэн томилж, гэрээ байгуулан ажиллаж байна. Хог хаягдлын олон нийтийн байцаагчдын ажиллах чиг үүргийг шинэчилж, 4 бүлэгт хувааж, үүсмэл хогийн цэгийг устгах, ААНБ-ын хог хаягдалд хяналт тавьж ажиллуулж байна. Мөн долоо хоног бүрийн 2 дахь өдөр 23 хорооны 24 байцаагч нартай хуралдаж тус тусын хороодод болж байгаа хог хаягдлын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг болоод байна.					

6.10	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог тээвэрлэлтийн менежментийг сайжруулна.	6.10-2	Бүх нийтийн их цэвэрлэгээг сар, улирал бүр тогтмол зохион байгуулж, "Баянголчуудын Бямба" цэвэрлэгээг үргэлжлүүлнэ.	Жилд зохион байгуулах их цэвэрлэгээ, тоогоор	43	10,000,000	70	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	
			Хамрагдах хүн, тоогоор	15,000	Дүүргийн төсөв				
			Хүрсэн түвшин, хэрэгжилт						
			Иргэдийн ая тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гуу жалганд үүссэн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэхэд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлсэн 3 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг 2019.01.26, 2019.04.20, 2019.09.14-15-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж цэвэрлэгээнд давхардсан тоогоор 6682 аж ахуйн нэгж, байгууллагын 21373 хүн хамрагдаж 102,7 га талбайг цэвэрлэн 526,6 тонн хог хаягдлыг тээвэрлүүлэн ажилласан. Мөн дүүргийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/182 дугаар "Баянголын бямба" бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай захирамжаар 11 удаагийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 8421 байгууллагын 21467 хүн 234,8 га талбайн 376.2 тонн хог хаягдлыг цэвэрлэж тээвэрлүүлсэн.						
			6.10-3	Хог хаягдлын талаарх хууль тогтоомж зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг оновчтой зохион байгуулж, торгох эрх бүхий байцаагч ажиллуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	70	"Баянгол Шинэ Өргөө" ОНӨААТҮГ
Хүрсэн түвшин, хэрэгжилт									
Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад 50 метр орчим ил задгай хогийн цэг үүсгэхгүй байх, зориулалтын бус цэгт хог хаягдлаа хаяхгүй байх талаар зохих журмын дагуу шаардлага тавьж, 159 мэдэгдэх хуудас өгч биелэлтийг нь хангуулан ажиллаж байна.									
6.10-4	Дүүргийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгүүдэд үүсдэг ил задгай хог хаягдлын цэгүүдийг устгаж, тохижуулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	100	"Баянгол Шинэ Өргөө" ОНӨААТҮГ			
	Хүрсэн түвшин, хэрэгжилт								
	2019 оны жилийн эцсээр нийт 46 үүсмэл цэг байгаагаас 16, 10, 22-р хорооны 6 үүсмэл хогын цэгийн асгууруудыг бүрэн устгаж ажиллалаа. Байгууллагын гадна орчноо тохижуулах, хариуцсан төв гудамжуудын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-ын ажилчид 3000 ширхэг мандлын цэцэг үрслүүллээ. Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-ын даргын 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/12 дугаар тушаалийн дагуу дүүргийн хороодтой ажлын уялдаа холбоогоо сайжруулах зорилгоор хог тээврийн календарчилсан хуваарь батлан мөрдөж байна. Тус тушаалын дагуу Баянгол дүүргийнхээ гэр хороолол бүхий 8 хорооны хог тээвэрлэх хуваарийг өөрчлөн нэг хороонд сардаа 3 удаа ажилт хийх болсон нь хог тээвэрлэлтийг үр дүнтэй байгааг иргэдийн санал, сэтгэгдлээр тодорхойлогдож байна. Үүнтэй холбогдуулан гудамжны уулзвар, худаг зэрэг хүн ихээр зорчдог хэсгүүдэд 400 ширхэг хог тээвэрлэх хуваарь бүхий хулдаасан самбар байршууллаа. Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдал хаях зориулалтын 77 ширхэг контейнер асгуур байдаг. Эдгээр асгуурууд иргэдийн санаатай болон санамсаргүй үйлдлээс шалтгаалан шатах, эвдрэх тохиолдол цөөнгүй гарч өнгө үзэмжээ алддаг. Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-н Ногоон байгууламж, тохижилтын хэлтсийн ажилчид 5 дугаар сарын 22-ны өдрөөс 28-ны өдрийн хооронд дээрх 77 ширхэг зориулалтын асгуурыг будаж засварлан өнгө үзэмжийг сэргээлээ.								
6.11-1	Орон сууц, гэр хорооллын дунд орчны бохирдол үүсгэж, үйл ажиллагаа явуулж буй хоёрдогч түүхий эд авах цэгийг холбогдох хууль, журамд нийцүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	-	(-)	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс			
	Хүрсэн түвшин, хэрэгжилт								
	Дүүргийн нутаг дэвсгэрт хоёрдогч түүхий эд авах цэгийн судалгааг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр хийсэн бөгөөд судалгаагаар нийт 8 цэг бүртгэгдсэн. Судалгаанд хамрагдсан 4 цэг нь шил, лааз, хуванцар хүлээн авдаг, 4 цэг нь төмөр, зэс хүлээн авч байна.								

6.11	Орон сууц, гэр хорооллын айл өрхийн хог хаягдалд ангилан ялгах тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор иргэдийн ухамсарт нөлөөлөхүйц сургалт сурталчилгааны ажил зохион байгуулна.	6.11-2	Хог хаягдлын хууль, холбогдох журмыг таниулах, иргэдэд хог хаягдлын талаар хүлээх хариуцлага, ангилан ялгах дадал олгох, мэдлэг ухамсрыг дээшлүүлэх гарын авлага, зурагт хуудас, видео мэдээлэл бэлтгэж сурталчлах ажлыг зохион байгуулна.	Гарын авлага, зурагт хуудас бэлтгэн хэвлүүлсэн тоо, тараасан иргэн, байгууллага, тоогоор	5000	-	70	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
			Зохион байгуулах сургалт, тоогоор	2 сард 1 удаа	-	"Баянгол Шинэ Өргөө" ОНӨААТҮГ		
			Хүрсэн түвшин, хэрэгжилт					
			Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд хог хаягдлыг ангилан ялгах, түүний ач тусыг иргэдэд ойлгуулах зорилгоор дүүргийн 104 СӨХ-дын гүйцэтгэх захирал нарт "Эрүүл байр эвтэй иргэд, хариуцлагатай СӨХ зөвхөн бидэнд" уриатай сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, "Хог хаягдлыг эх үүсвэр дээр хэрхэн ангилан ялгах" сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Тохижилт, хог хаягдлын олон нийтийн 24 байцаагч нарт Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн ТББ-тай хамтран тус тус зохион байгуулсан. Мөн хог хаягдлын менежмент, хог хаягдлыг дахин боловсруулах, барилгын хог хаягдал түүний дахин боловсруулалтыг сайжруулах чиглэлээр Каритас Чех Репаблнк байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчдийн газартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 01-ны өдөр Тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч нарт сургалтыг хийсэн. Мөн дүүргийн Засаг даргын 2019 оны А/318 дугаар захирамжаар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулах, дахин ашиглах чиглэлээр иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах зорилготой "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөө" уриатай "Өгөөмөр өдөр" өдөрлөгийн арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 09-ний өдөр 14 дугаар хороо "Номин их дэлгүүр"-ийн гадна талбайд 11:00-17:00 цагийн хооронд Эмэгтэйчүүдийн эрх, хамгаалал хөгжлийн хүрээлэн ТББ-тай хамтран зохион байгуулсан. Хог хаягдлыг ангилан ялгах, угсармал орон сууцны хогийн бункерийг шинэчлэх замаар хог хаягдлын ачилт тазварлалтийг боловсронгуй болгож менежментийг сайжруулах зорилгоор дүүргийн 1 дүгээр хорооны 06 байр, 6 дугаар хорооны 14а байрнуудад Эко цэг байгуулах туршилтын ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 09-ны өдрөөс хэрэгжүүлж тус 2 байрны 72 оршин суугч нарт хог хаягдал ангилан ялгах сургалтын ажлыг зохион байгуулсан.					
								91.1%